



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2025 оны 06 дугаар сарын 24-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-14
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	15-67

2.Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар 2025.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	14-28
2.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 3 гишүүн 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	29-41
3.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл нарын 26 гишүүн 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	41-52
4.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 11 гишүүн 2025.06.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	52-54
5.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 40 гишүүн 2025.06.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	54-56
6.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ нарын 10 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	56-58
7.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нарын 9 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	58-67

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 06 дугаар сарын 24-ний
өдөр /Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 33 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, Л.Оюун-Эрдэнэ;
Томилолттой: С.Амарсайхан, Т.Доржханд, Ц.Туваан;
Эмнэлгийн чөлөөтэй: Л.Энх-Амгалан.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир хэлэлцэх асуудлын дарааллын хоёрдугаарт байгаа Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 3 гишүүн 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн/-ийг хэлэлцэх эсэх асуудлыг хойшлуулах горимын санал гаргаж, хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин тайлбар хийв.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	6
Татгалзсан	11
Бүгд	17

35.3 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ хэлэлцэх асуудлын дарааллын 7-д байгаа Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нарын 9 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн/-ийг хэлэлцэх эсэх асуудлын дарааллын 2 дахь асуудал болгож хэлэлцье гэсэн горимын санал гаргав.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн гаргасан горимын саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж хуулийн төслийг өргөн барьсан дарааллаар хэлэлцэх нь зүйтэй гэсэн санал хэлэв.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	6
Татгалзсан	11
Бүгд	17

35.3 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Нэг.Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар 2025.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Сангийн сайд Б.Жавхлан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Д.Мөнх-Эрдэнэ, Хууль эрх зүйн газрын дарга Д.Саруул, референт Б.Төрбат, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд нар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Б.Нандингэрэл, Г.Алтанцэцэг, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Баярсайхан, ахлах мэргэжилтэн Б.Галсанбат нар байлцав.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Нэг.Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Хоёр.Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асуугаагүй болно.

Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ж.Бат-Эрдэнэ: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих асуудал гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж саналаа тайлбарлаж, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт тайлбар хийв.

Зөвшөөрсөн	9
Татгалзсан	8
Бүгд	17

52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Ж.Бат-Эрдэнэ: 2.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын “хууль тогтоомж Засгийн газрын шийдвэрийн биелэлтэд хяналт тавих асуудал” гэснийг “хууль тогтоомж, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг Засгийн газрын шийдвэрийн биелэлтэд хяналт тавих асуудал” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал тайлбар хийв.

Зөвшөөрсөн	8
Татгалзсан	10
Бүгд	18

44.4 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

3.Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 3 дахь заалт “шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого төлөвлөлт” гэснийг “Шинжлэх ухаан, технологи, инновацын нэгдсэн бодлого төлөвлөлт” гэж өөрчлөх. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20 дахь хэсгийн 3 дахь заалт Өндөр технологи, Үндэсний инновацын тогтолцооны бодлого төлөвлөлт хөгжүүлэх асуудал гэснийг хасах, мөн энэ хэсгийн “20.Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд” гэснийг “20.Цахим хөгжил, харилцаа холбооны сайд” гэж өөрчлөх, мөн энэ хуулийн 18 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 14 дэх заалт “14.Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам” гэснийг “Цахим хөгжил, харилцаа холбооны яам” гэж өөрчлөх гэсэн санал гаргав.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ дээрх саналын томъёолол нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн төсөлд хөндөгдөөгүй заалт тул санал хураалт явуулах боломжгүй талаар тайлбарлаж, санал хураалт явуулаагүй болно.

Ж.Бат-Эрдэнэ: 4.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, төслийн

1 дүгээр зүйлийн “бууруулах асуудал” гэсний дараа “Бүсчилсэн хөгжлийн үндэсний хороог Эдийн засаг, хөгжил хариуцсан Тэргүүн Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжүүлэх” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж тайлбар хийв.

Зөвшөөрсөн	10
Татгалзсан	8
Бүгд	18

55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дуусав.

Гурав.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дуусав.

Дөрөв.Засгийн газар дахь хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асуугаагүй болно.

Ж.Бат-Эрдэнэ: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл. Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

3.4.Энэ хуулийн 3.1-д заасан этгээдээс хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, захирамж, хурлын тэмдэглэл. Цаашид хууль тогтоомж, бодлого шийдвэр гэснийг хэрэгжүүлэхэд хяналт тавих ажиллагаанд энэ хууль үйлчилнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	10
Татгалзсан	8
Бүгд	18

55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Хуулийн төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

2 дугаар зүйл. Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтын Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны даргаас гэснийг Монгол Улсын сайд. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаас гэж, 11 дүгээр зүйлийн гарчиг мөн зүйлийн 11.1, 11.3 дахь хэсэг 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Хяналт үнэлгээний Үндэсний хорооны даргын гэснийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын гэж, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 17.1.7 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.1, 19.3 дахь хэсгийн Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Хяналт үнэлгээний Үндэсний хорооны даргад гэснийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад гэж, 18 дугаар зүйлийн 18.6 дахь хэсгийн Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Хяналт үнэлгээний Үндэсний хорооны дарга гэснийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	10
Татгалзсан	8
Бүгд	18

55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дуусав.

Тав.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Зургаа.Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэлийн тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан хариулж, тайлбар хийв.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дуусав.

Долоо.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Найм.Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын иХ Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Тогтоолын төслийг заалт бүрээр хэлэлцэж дуусав.

Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийж дуусав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл

*/Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 3 гишүүн 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, **хэлэлцэх эсэх**/*

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, ахлах мэргэжилтэн Б.Галсанбат нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон төслийн үзэл баримтлалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Э.Болормаа, О.Алтангэрэл нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг, Ж.Баярмаа, О.Алтангэрэл, Л.Гантөмөр, Ж.Бат-Эрдэнэ нар үг хэлэв.

Ж.Бат-Эрдэнэ: Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	9
Татгалзсан	10
Бүгд	19

47.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Хамт өргөн мэдүүлсэн:

Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	3
Татгалзсан	16
Бүгд	19

15.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	7
Татгалзсан	12
Бүгд	19

36.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 17 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл нарын 26 гишүүн 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Б.Нандингэрэл, Ц.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, ахлах мэргэжилтэн Б.Галсанбат нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, О.Номинчимэг нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа, Ж.Баярмаа, Л.Гантөмөр, Б.Батбаатар, О.Номинчимэг, О.Цогтгэрэл нар үг хэлэв.

Ж.Бат-Эрдэнэ: Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	8
Татгалзсан	11
Бүгд	19

42.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмааг санал хураалтад дэмжсэнээр тооцож, 47.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 57 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 11 гишүүн 2025.06.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Б.Мажигсүрэн, Ц.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй

байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, ахлах мэргэжилтэн Б.Галсанбат нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин танилцуулав.

Илтгэл болон төслийн үзэл баримтлалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ж.Бат-Эрдэнэ: Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	14
Татгалзсан	5
Бүгд	19

73.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн

тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	14
Татгалзсан	5
Бүгд	19

73.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	14
Татгалзсан	5
Бүгд	19

73.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 03 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 40 гишүүн 2025.06.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Б.Мажигсүрэн, Ц.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, ахлах мэргэжилтэн Б.Галсанбат нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон төслийн үзэл баримтлалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Уг асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын Намын бүлгийн дэд дарга А.Ариунзаяа үг хэлж, завсарлага авах тухай мэдэгдэж, ажлын 5 өдрийн завсарлага авав.

Уг асуудлыг 14 цаг 14 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ нарын 10 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон төслийн үзэл баримтлалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ж.Бат-Эрдэнэ: Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	9
Татгалзсан	10
Бүгд	19

47.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	11
Татгалзсан	8
Бүгд	19

57.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн 11

Татгалзсан 8

Бүгд 19

57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

Долоо.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нарын 9 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх П.Хулан, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, ахлах мэргэжилтэн Б.Галсанбат нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон төслийн үзэл баримтлалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, Г.Уянгахишиг, Ө.Шижир нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижир, Б.Пүрэвдорж, С.Зулпхар, Г.Уянгахишиг, Х.Тэмүүжин, Б.Баярбаатар, Ж.Баярмаа, Ж.Бат-Эрдэнэ нар үг хэлэв.

Ж.Бат-Эрдэнэ: Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн 12

Татгалзсан 7

Бүгд 19

63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл

баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	12
Татгалзсан	7
Бүгд	19

63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 7 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 цаг 17 минут үргэлжилж, 25 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 63.2 хувийн ирцтэйгээр 14 цаг 50 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ГЭРЭЭТ АЖИЛТАН

Д.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 06 дугаар сарын 24-ний өдөр

Мягмар гараг Төрийн ордон “Үндсэн хууль” танхимд 11 цаг 33 минут.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Бат-Эрдэнэ: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая аа. Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя. Жадамбын Бат-Эрдэнэ ирсэн, Сандагийн Бямбацогт гишүүн ирсэн, Нямтайширын Номтойбаяр гишүүн ирсэн, Цэндийн Сандаг-Очир гишүүн ирсэн. Өлзийхүүгийн Шижир гишүүн ирсэн, Баярмагнайн Баярбаатар гишүүн ирсэн, Сархадын Зулпхар гишүүн ирсэн, Эрдэнэбилэгийн Одбаяр гишүүн ирсэн, Ням-Осорын Учрал гишүүн ирсэн, Энхбатын Болормаа гишүүн ирсэн, Одсүрэнгийн Номинчимэг гишүүн ирсэн, Бөхчулууны Пүрэвдорж гишүүн ирсэн, Гончигдоржийн Уянгахишиг гишүүн ирсэн байна аа.

Ингээд Байнгын хорооны ирц бүрдсэн тул Байнгын хорооны 2025 оны 6 сарын 24-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүд /анхны хэлэлцүүлэг/

2.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүлэн нарын 3 гишүүн 2025 оны 3 сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн /хэлэлцэх эсэх/

3.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. УИХ-ын гишүүн О.Цогтгэрэл нарын 26 гишүүн 2025 оны 3 сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн /хэлэлцэх эсэх/

4.Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүлэн нарын 11 гишүүн 2025 оны 6 дугаар сарын 10-ны өдөр өргөн мэдүүлсэн /хэлэлцэх эсэх/

5.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл УИХ-ын гишүүн Х.Тэмүүжин нарын 40 гишүүн 2025 оны 6 сарын 12-ны өдөр өргөн мэдүүлсэн /хэлэлцэх эсэх/

6.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл УИХ-ын гишүүн Б.Бат-Эрдэнэ нарын 10 гишүүн 2025 оны 6 сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн /хэлэлцэх эсэх/

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл УИХ-ын гишүүн А.Ариунзаяа нарын 9 гишүүн 2025 оны 6 сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн /хэлэлцэх эсэх/

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? За Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Энэ нөгөө Тэмүүжин нарын гишүүдийн өргөн барьсан Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль байгаа. Энэ нь болохоор Тусгай хяналтын дэд хороог Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос тусад нь бас эрхлэх асуудлынх нь чиг үүргээр 2 хувааж нэг хэсгийг нь ХЗБХ-нд гэж байгаа юм байна. Зөв үү тиймээ. Энэ хуулийн концепц нь. Тэгэхээр энэ хуулийн юу гэж хэлэх гэж байна вэ гэхээр УИХ-ын тухай хуулийн 27.4 дээр энэ хуулийн 27.3-д зааснаас бусад дэд хороо байгуулах, татан буулгах, тэдгээрийг нь дагнан хариуцах асуудлыг харьяалах Байнгын хорооны саналыг үндэслэн нэгдсэн хуралдаанаар шийдвэрлэнэ ээ гэж байгаа юм.

Тэгэхээр энэ чинь бол Тусгай хяналтын дэд хороог 2 хуваах гэж байна шүү дээ. Тэгээд шинэ дэд хороо байгуулж, ХЗБХ-нд шинээр харьяалуулах гэж байна. Тэгэхээр энэ Улсын Их Хурлын тухай хуулийн 27.4-өөр хэрвээ ингэх гэж байгаа бол харьяалах Байнгын хорооны саналыг үндэслэнэ гэж байна. Тэгэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос саналыг нь авсан юм уу? Өөрийнх нь одоо салбар харьяалах асуудлынх нь дэд хорооны энэ өөрчлөх гэж байгаа асуудалтай холбогдуулж. Би ингээд үзэхээр хуулийн төсөл дээр материал дээр санал авсан юм харагдахгүй байх юм. Хэрвээ аваагүй бол энэ хуулийн бас заалт зөрчигдөх асуудал үүсэх гээд байна. Тэгэхээр юу гэж хэлэх вэ гэхээр би бас хуулийн хүрээнд Улсын Их Хурлын тухай хуулийн 27.4-ийн хүрээнд саналыг нь аваагүй бол хойшлуулж, хэлэлцэх асуудлаас хойшлуулж дараагийн тэр Байнгын хорооноос нь эрхлэх асуудлынх нь Байнгын хорооноос нь санал, дүгнэлтийг нь авч байж хэлэлцэх асуудалд оруулж өгөөч ээ гэсэн ийм горимын саналыг гаргах гэж байгаа юм.

Ж.Бат-Эрдэнэ: Тэмүүжин гишүүн.

Х.Тэмүүжин: Улсын Их Хурлын тухай хууль дээр байгаа энэ заалт юуг илэрхийлж байгаа вэ гэхээр дэд хороо байгуулах 2 зам байгаа юм. Нэгийг нь хуулиар, нэгийг нь хуульгүйгээр байгуулах. Хуулиар байгуулах нь болохоор өмнөх заалт нь байхгүй юу. Тэгэхээр хуулиар байгуулахаас бусад дэд хороо байгуулах юм бол тухайн Байнгын хорооны саналыг авна гэж хэлж байгаа юм. Одоо энэ бидний өргөн барьсан бол хуулиар байгуулах дэд хорооны асуудал. Хуулийн төсөл өргөн барьчихсан байгаа хэлэлцэх гэж байгаа юм. Тийм учраас энэ дэд хороо бол хуулиар байгуулагдаж байгаа учраас ямар нэгэн Байнгын хорооноос санал авах тухай огт байхгүй. Хууль санаачлагчийн бүрэн эрх, Улсын Их Хурлын өөрийнх нь бүрэн эрх. Ямар нэгэн Байнгын хороо өөрийнхөө эрхлэх асуудлын хүрээнд хуульгүйгээр дэд хороо байгуулж болно. Хэрвээ тэгэх бол тэр Байнгын хороо саналаа оруулаад нэгдсэн чуулганаар дэд хороогоо байгуулна гэдэг ийм зарчимтай.

Тэгэхлээр дахиад Сандаг-Очир гишүүн наад зүйл заалтаа дахиад нэг унш даа. Өмнөх заалтад дурдсанаас бусад дэд хороо гэж байгаа биз. Дахиад наад яг заалтаа уншаадаа даа. Тэгэхээр өмнөх заалт чинь бол юу вэ гэхээр хуульд заасан дэд хороонуудын тухай яриа байхгүй юу. Тэгэхээр хуульд заасан дэд хороог байгуулахын тулд хуулийн төсөл өргөн барьж байгаа юм. Хуулийн төсөл дээр ийм

дэд хороо байгуулъя аа гэж. Хэрвээ хуульд заагаагүй дэд хороо хууль батлахгүйгээр байгуулах гэж байгаа бол Байнгын хороо тогтоолын төсөл өргөн барих байхгүй юу. Ялгаа нь энэ ерөөсөө. Тэгэхээр энэ ялгааг гаргаж хуулиа унших хэрэгтэй. Та дахиад наад заалтаа уншаадах. Яагаад гэвэл Энхбаяр өмнө нь бас яг энэ заалтыг ашиглаад хойшлуулсан. Тэгээд Энхбаяртай би орж уулзсан. Чи хуульд заасан дэд хороо байгуулах гэж байхад хуульд заагаагүй хуульгүйгээр Дэд хороо байгуулах заалтыг ашиглаж хойшлууллаа. Энэ удаад би дуугүй орхилоо. Дахиад ийм алдаа гаргах юм бол Үндсэн хуульд заасан хууль санаачлагчийн эрхийг бүдүүлгээр зөрчиж байна гээд Үндсэн хуулийн цэцэд өгнө шүү. Энхбаярт бол маш тодорхой би хэлсэн шүү.

Тэгэхээр энэ заалтаа зөв унших хэрэгтэй. Та наадах чинь бусад гэж байгаа биз дээ бусад гэж үг байгаа биз. Энэ зүйл заалтад зааснаас бусад дэд хороог байгуулахдаа гэж байгаа биз. Тийм үг байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Би наад уншаад өг гэснийг чинь би уншаад өгчих үү. За ийм байгаа юм. Таны тайлбарыг би ч түрүүний хурал дээр бас сонссон шүү дээ. Тэгээд Цэцэд өгнө гэдгийг ч би мэдэж байгаа юм. Ийм байгаад байгаа юм. 27.3 дээр дэд хороо байгуулах асуудал шүү дээ гишүүд ээ. Дэд хороо байгуулах асуудал. 27.3 дээр Улсын Их Хурал Байнгын хорооны бүрэлдэхүүнд дараах дэд хороог байгуулна аа. Дараах дэд хороог байгуулна аа. Энэ бол хуульд заасан, хуульд заасан. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд Тусгай хяналтын, Төрийн байгуулалтын байнгын хороонд Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын, Төсвийн байнгын хороонд Төсвийн зарлагын хяналтын, Хууль зүйн байнгын хороонд Хүний эрхийн, Эдийн засгийн байнгын хороонд Тогтвортой хөгжлийн зорилтын гээд. Энэ бол таны хэлдгээр хуульд заасан Байнгын хороо, хуульд заасан Байнгын хороо. Үүнээс гадна 27.4 дээр энэ хуулийн 27.3 дээр заасан зааснаас бусад гэж байгаа юм. Өөрөөр хэлбэл саяын 5 дэд хорооноос бусад дэд хороо байгуулах, татан буулгах, тэдгээрийн дагнан хариуцах асуудлыг харьяалах Байнгын хорооны саналыг үндэслэн нэгдсэн хуралдаанаар шийдвэрлэнэ гэж байгаа юм. Энэнээс гаднахыг тийм үү энэ 5-аас гаднахыг.

Х.Тэмүүжин: Одоо тэр 5 дээр чинь нэмчихвэл дахиад юу болох вэ гэхээр энэ 6 Байнгын хорооноос бусад Байнгын хороо гээд...

Ж.Бат-Эрдэнэ: Та микрофондоо хэлчих. Тэмүүжин гишүүний микрофоныг сонсчихье.

Х.Тэмүүжин: Тэгэхээр нөгөө хуульд заасан дэд хороог байгуулахын тулд хууль өргөн барьж байж л байгуулна. Тэр эрхийнхээ дагуу Улсын Их Хурлын гишүүн өргөн барьж байгаа байхгүй юу. Хууль тэнд хуулиар дэд хороо байгуулахгүй гэх юм бол Байнгын хороо асуудал шийднэ. Одоо жишээ нь дахиад бид хэд хамтаараа Улсын Их Хурлын тухай хууль өргөн бариад юу хийж байна вэ гэхээр Байнгын хороог цөөлөөд дэд хороо байгуулах гэж байгаа юм. Дахиад хууль өргөн барьж байгаа байхгүй юу. Тэгээд энэ хууль хэлэлцэгдэнгүүт юу батлагдах вэ гэхээр хуульд заасан дэд хороонууд маань 6 биш, 5 биш, 8 болно. Байнгын хороо нь цөөрөөд.

Тэгэхээр энэ чинь юу болох юм гэхээр хууль санаачлагчийн бүрэн эрх Улсын Их Хурлын бүрэн эрхийг нэг Байнгын хороо нь булааж авч ерөөсөө болохгүй шүү дээ. Тэгэхлээр хуульгүйгээр байгуулагддаг дэд хороо, хуулиар байгуулагддаг дэд хороо гэж Улсын Их Хурлын тухай хууль дээр зааж өгсөн байна аа. Хуулиар

байгуулагддаг дэд хороогоо нэмэх гэж байгаа бол хуулиа өргөн барь. Хуульгүйгээр байгуулах дэд хороо байгуулах гэж байгаа бол Байнгын хорооныхоо саналаар чуулган шийднэ ийм л 2 гарц тавьж өгсөн байгаа байхгүй юу. Энийг хооронд нь мөргөлдүүлж нэг нэгийг нь үгүйсгэж ерөөсөө болохгүй. Жишээ нь Байгаль орчны байнгын хороон дээр магадгүй хуульгүйгээр хэдүүлээ энэ агаарын бохирдлоо шийдэх дэд хороо байгуулъя гэх юм бол байгуулна шүү дээ. Түр хороо байгуулъя гэвэл байгуулна шүү дээ. Хууль өргөн барихгүйгээр.

Тэгэхлээр хууль өргөн барьж байгаа асуудал дээр өө байж байгаарай гээд хуульгүйгээр байгуулах дэд хорооны заалт ашиглангуутаа Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг хязгаарлаж болохгүй. Улсын Их Хурлын бүрэн эрхийг хязгаарлаж болохгүй. Энэ Үндсэн хуулийн зөрчил болох байхгүй юу. Тийм учраас би тэгж сануулж хэлээд байгаа юм. Одоо бид хэдийн өргөн барьсан хууль дээр чинь дэд хороо нэмэгдэж байгаа шүү дээ.

Ж.Бат-Эрдэнэ: За юу яая. Санал гарсан. Сандаг-Очир гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад бэлтгэе. Санал хураалтдаа бэлдье тийм. Горимын санал гарсан тул санал хураалтад бэлдье. Бэлдсэн үү. За санал хураалт.

Сандаг-Очир гишүүний гаргасан горимын саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 17 гишүүн оролцож, 6 гишүүн дэмжиж, 35.3 хувиар санал дэмжигдсэнгүй ээ.

Би нэг санал бас гаргаадахъя аа. Энэ ер нь одоо бас нэлээн Байнгын хороотой холбоотой асуудал, бүтэцтэй холбоотой асуудлууд нэлээн яригдах юм байна. Энэ 7 дээр байж байгаа Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нарын 9 гишүүн 2025 оны 6 сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэх гэсэн. Энийг 2 дахь асуудал болгож хэлэлцье ээ. Бүтэцтэй холбоотой асуудлууд. Тэгээд энэний ар дээр сая Тэмүүжин гишүүн болон бусад ингээд бас бүтэцтэй холбоотой асуудлууд гарч байгаа учир ингээд уялдуулаад явчихвал яасан юм. 2 дугаар асуудал руу оруулж хэлэлцье гэсэн ийм горимын санал гаргаж байгаа юм.

Саяын гаргасан горимын саналаар дэмжье гэсэн саналын томьёоллыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт. За санал хураалтад.

7-д байгаа, 7 дээр байгаа хуулийн төслийг Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөл мэдүүлсэн хуулийн төсөл Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяагийн болон 9 гишүүний өргөн мэдүүлсэн хуулийг. Үгүй ээ би сая горимын санал гаргачихлаа. Горимын саналтай холбоотой Пүрэвдорж гишүүн үг хэлье.

Б.Пүрэвдорж: Улсын Их Хурлын гишүүд аливаа хууль санаачлахад бол хуулийн өргөн барьсан огноогоор асуудал шийддэг. Энэ дагуу энэ Ариунзаяагийн одоо өмнүүр бол 3 ч хуулийн төсөл байгаа. Тэмүүжин нарын өргөн барьсан 3 хууль. Тэгээд бас хэн нь ч байна уу ингээд бас нэг танай намын нэг хүн байгаа. Тэгээд энэ хуулиудын урдуур ингэж оруулж ирж болохгүй. Энэ хуулийг өргөн барьсан

дарааллын дагуу хэлэлцэх ёстой. Тийм учраас ингэж урдуур оруулж ирж хэлэлцэх боломжгүй. Өөрөөр хэлбэл тодорхой яг энэ Их Хурлын тухай болон Их Хурлын дэгийн тухай хуулиудад өөрчлөлт оруулах тухай асуудлаар өнөөдөр энэ олон хуулиуд орж ирж байгаа. Энэ бол хуулиуд бол зөвхөн дэгийн дагуу л дэгийн дагуу хууль нь өргөн баригдсан огноогоороо хэлэлцэгдэх ёстой.

Тийм учраас даргын зөвлөлийн хурлаар энэ хуулийг яг тэр өргөн барьсан дарааллын дагуу юу нь одоо Тамгын газраас оруулж ирж, тэрнийгээ одоо хэлэлцэж шийдвэрлэсэн байгаа. Тийм учраас энэ дарааллын дагуу хэлэлцэхийг хүсье ээ. Санал хураалт. Горимын саналыг дэмжихгүй байна.

Ж.Бат-Эрдэнэ: Миний гаргасан горимын саналтай холбоотойгоор санал хэлсэн Пүрэвдорж гишүүн санал хэллээ. Гаргасан горимын саналынхаа дагуу санал хураалт явуулъя. Энэ чинь санал хураалтад дахиж бэлдэх билүү. Санал хураалтад бэлдье. Миний бие гаргасан саналын томьёолол байж байгаад өөрөөр хэлбэл 7 дээр байгааг 2 луу шилжүүлбэ гэсэн горимын саналаар санал хураалт явуулъя. Дэмжбэ гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

За ойлголоо саналыг хүлээж авлаа. 17 гишүүнээс 6 гишүүн дэмжиж 35.3 хувиар санал дэмжигдсэнгүй ээ.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Санал, дүгнэлт уншихаас өмнө ажлын хэсгийг урьж оруулъя. Ажлын хэсгийг танилцуулъя. Г.Занданшатар Монгол Улсын Ерөнхий сайд, С.Бямбацогт Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Б.Жавхлан Сангийн сайд, Д.Мөнх-Эрдэнэ Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга, Д.Саруул Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль эрх зүйн газрын дарга, Б.Төрбат Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль эрх зүйн газрын референт, Л.Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, М.Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, З.Энхболд Сангийн яамны Хууль зүйн газрын дарга.

Хэлэлцэх асуудалд Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг.

Өргөн мэдүүлсэн холбогдох хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Мөнхсоёл уншиж танилцуулна. Мөнхсоёл гишүүний микрофоныг нээе.

Б.Мөнхсоёл: Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Зараас 2025 оны 6 дугаар сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг яаралтай хэлэлцэхээр Улсын Их Хуралд 2025 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн чуулганы хуралдаанаараа хэлэлцэн шийдвэрлэж, хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг 2025 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар явуулж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр

Төрийн байгуулалтын байнгын хороо болон бусад Байнгын хороодод шилжүүлсэн билээ.

Төсвийн байнгын хороо 2025 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаараа Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу явуулж, хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн өмнөх сайд нарын эрхлэх асуудлын чиг үүргийг шинээр томилогдож байгаа Засгийн газрын гишүүдэд шилжүүлэх зохицуулалтын талаар, Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа хуулийн төсөлд тусгагдсан боомтын сэргэлтийн асуудлыг Сангийн сайдын чиг үүрэгт хамааруулсан нь оновчтой эсэх, мөн төсвийн тодотголыг боловсруулахдаа Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд тусгагдсан төсвийн тусгай шаардлагад өөрчлөлт оруулахгүйгээр Төсвийн тухай хуульд тусгагдсан төсвийн тодотголыг боловсруулах нөхцөлүүдийг харгалзан үзэж болох эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Пүрэвдаваа яаралтай горимоор Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх хуулийн төсөлд агентлагийн тоо болон төрийн албанаас чөлөөлөгдөх албан хаагчдын тооны талаар олон нийтийн санал авсан эсэх талаар асуулт асууж хариулт авлаа.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний асуудлыг хэлэлцэх дарааллыг анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулан, сайд нарыг томилох дарааллыг баримталж, хуулийн төслүүдийг өргөн мэдүүлэх нь зүйтэй талаар саналаа илэрхийлсэн болно.

Хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Хуулийн тайлбар танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10.Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ. Хэрэв төслийн зүйлээр хуульд шинээр бүлэг, дэд бүлэг, нэмэх, бүлэг, дэд бүлгийг бүхэлд нь өөрчлөх бол тухайн бүлгийн зүйл бүрээр хэлэлцэнэ. 39.11.Гишүүн хуулийн төслийн тухайн зүйлтэй холбогдуулан хууль санаачлагчаас болон бусад оролцогчоос асуулт асууж болно гэсэн байгаа шүү.

Ингээд хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэнэ.

1.Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулттай саналтай гишүүд байна уу. Алга байна.

Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүд байна уу? Алга байна.

Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

2.Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүд байна уу? Гишүүд байна уу? Алга. Бичгээр гаргасан юм уу? Пүрэвдорж гишүүн бичгээр санал гаргасан юм уу? Та саналаа танилцуулахгүй юм уу. Татаж байгаа юм уу. За Пүрэвдорж гишүүн. Пүрэвдорж гишүүний микрофоныг өгье.

Б.Пүрэвдорж: 2023 оны 1 сарын 1-нээс Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрыг байгуулж, энэ хүрээндээ ялангуяа одоо Засгийн газрын яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга, түүний албан тушаалтнууд, төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн газруудын албан тушаалтнуудтай холбоотой хяналт шалгалтыг, ялангуяа одоо дарга нарт л зориулсан, дарга нарыг л шалгадаг ийм одоо агентлагийг байгуулсан. Тэгээд энэ бол одоо бүр тусгайлан хууль болж орж ирсэн байгаа. Тэгээд энэ одоо Засгийн газар дахь хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах замаар энийг хийсэн. Гэвч одоо энэ хяналтын газрыг Засгийн газрын хоорондын уялдаа холбоог хангадаг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар дээр байсан энэ албыг эдийн засгийн хариуцсан Тэргүүн шадар сайд руу шилжүүлж байгаа нь буруу байна аа. Эндээс шилжүүлж аваачиж байгаад буцаад яах вэ Засгийн газрын хоорондын уялдааг шалгадаг тэр хяналт шалгалт нь байна гэж яриад байгаа юм.

Тэгэхээр энийг ингээд шилжүүлж аваачаад Тэргүүн шадар сайд дээр аваачна гэдэг бол цаашдаа мэргэжлийн хяналт гээд одоо манай ард иргэдийн бүүр ясыг нь янгинуулдаг, иргэд аж ахуйн нэгжүүдийн бүүр ёстой нэг бүүр зовлонг нь юу яадаг байсан тэр мэргэжлийн хяналтыг л байгуулах гэж байгаа юм байна. Тэгээд энэ дээр бол Учрал, энэ бол хэрэггүй танд. Учрал дээр очих юм байна лээ. Тийм чам дээр бол арандаг болж ирнэ.

Тийм учраас энэ одоо энэ юуг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар дээр хэвээр нь үлдээлгэх зарчмын зөрүүтэй санал гаргасан. Тэгэхээр энэ асуудлыг энэ миний гаргасан саналыг яг хуучнаар нь буюу одоо Засгийн газрын хяналтын тухай хуульд хуулийн дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газар дээр нь байлгах талаар саналыг дэмжиж өгнө үү гэсэн ийм одоо хүсэлттэй байна.

Ж.Бат-Эрдэнэ: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Бямбацогт.

С.Бямбацогт: Пүрэвдорж гишүүний гаргасан санал дээр бас нэг тайлбар хэлчихье. Мэргэжлийн хяналтын ерөнхий газар гээд үндсэндээ бүх салбарын үйл ажиллагаанд хяналт тавьдаг нэгдсэн бүтэцтэй зохион байгуулалттай байгууллага 20 жил үйл ажиллагаа явуулж ирсэн. Үүнийг татан буулгаад одоо салбар салбарын яамдад одоо бас хяналтуудыг өгсөн байгаа. Үүнийг одоо бас зөв байсан уу, буруу

байсан уу, үр дүн гарч байна уу, гарахгүй байна уу гэдгээ бас эргэж нэг мониторинг хийж дахиж нэг ярих шаардлагатай. Энэ бол зайлшгүй ярих шаардлагатай нэг асуудал байгаа.

Одоо энэ хяналт хэрэгжүүлэх ерөнхий газрын чиг үүрэг бол Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын чиг үүрэгтэй огт холбоогүй, огт холбоогүй. Энэ бол Засгийн газрын бодлого шийдвэр Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомжийн шийдвэр. Энэ бүгдийг л одоо бас хэрэгжүүлэхэд шаардлагатай юмаа. Тэгээд энэ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг Монгол Улсын Их Хурал баталсан. Үүний дагуу бас ингээд Улсын Их Хурлаар баталдаг бодлогын бичиг баримтууд, хуулиуд, үүнийг өөрөөр хэлэх юм бол Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, 5 жилийн үндсэн чиглэл, жилийн төлөвлөгөө, жилийн төсөв гээд одоо энэ бодлогын бичиг баримтуудыг Улсын Их Хурал баталдаг. Үүнийг боловсруулах ажлыг Эдийн засгийн хөгжлийн яам хариуцдаг юм. Бодлого тодорхойлох, боловсруулах.

Энэ хүрээндээ Эдийн засгийн хөгжлийн яам өөрөө бодлогоо төлөвлөж тодорхойлчихоод түүнийхээ хэрэгжилт дээр хяналт тавих функцийг нь Эдийн засгийн хөгжлийн яам руу шилжүүлж байгаа юм. Одоо Хяналт хэрэгжүүлэх үндэсний хороо татан буугдсантай холбоотойгоор. Хууль тогтоомж Засгийн газрын шийдвэрийн биелэлт гээд хуучин Засгийн газрын Хэрэг эрхлэх газар дээр байсан энэ одоо Засаг даргатай холбоотой, яамдын дотоод үйл ажиллагаатай холбоотой энэ хяналтыг хэрэгжүүлэх чиг үүргийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар руу шилжүүлж байгаа юмаа. Яг ийм байдлаар явах нь одоо өнөөдөр мөрдөгдөж байгаа Засгийн газрын тухай хууль, мөн Хяналтын хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль энэндээ нийцэж байгаа. Энэ талаар одоо бас бид нар Ерөнхий сайд дээр Тэргүүн шадар сайд бид бүхэн бас ярилцаж байгаад яг энэ чиг үүргийн хийдэл гарчих гээд байна, чиг үүргийн хийдэл гаргахгүйгээр ингэж зохицуулъя гэж л оруулж ирж байгаа юмаа гэдгийг бас тайлбарлаж хэлье ээ. Тийм болохоор бас энийг зөв ойлгож, зөв мэдээлэлтэй байхгүй бол ойлголтын зөрүү гарчих вий. Гишүүд анхааралдаа авна уу.

Ж.Бат-Эрдэнэ: Пүрэвдорж гишүүн дахиад тодруулъя.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр одоо 2020 онд Тэргүүн шадар сайд нь байгаагүй юм. Тэргүүн шадар сайд гэж урьд нь ч байгаагүй. Тийм учраас одоо юу байдаг юм. Хяналт хэрэгжүүлэх газар тийшээ очих тийм туршлага бид нарт байгаагүй. 2024 онд шинэ Засгийн газар байгуулагдсан Ардчилсан намын хүн байсан учраас хяналт шалгалтыг тийшээ аваачих тухай огт асуудал байгаагүй. Тэгэхээр одоо ингээд та нар хяналт шалгалтыг 2 хувааж байгаад 2 жижигхэн тийм нэг агентлаг ч юм уу, тийм юм байгуулж аваад л баахан хүний орон тоо нэмэгдэж байгаа юм байна. Тэгээд л ийм байдлаар нэг тийм нэг талдаа болохлоор жирийн иргэд албан хаагч 14400 хүнийг хална гэххээд нөгөө талдаа ингээд хүнд харуулаад л, юм бариад л, тийм нэг тийм хачин нөгөө хөгжил ярих гэж байгаа бол тэр хөгжлөө ярь.

Тэр хөгжлөө ярихдаа биш тийм ээ тэрийг чинь өөр газар одоо таны тэр хөгжлийн чинь юу үйл ажиллагаа зөв байна уу, буруу байна уу гэдгийг чинь яг яамдын хоорондын уялдаа холбоог хангадаг Засгийн газрын Хэрэг хэрэг эрхлэх газар чинь шийддэг урьдын уламжлалтай одоо хүртэл байж байгаа, тэр юмнуудаа одоо тэгээд хийгээд явъя аа гэсэн ийм саналтай байна. Тэгээд санал хураалтаараа шийдье дээ. За одоо Учрал аа.

Ж.Бат-Эрдэнэ: За тайлбараа больё. Энэ хөгжлийн бодлого ярих гэж байгаа болбол Хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгийг ийш нь өгсөн нь зөв юм байна аа л гэж харагдаад байна.

Санал хураалт явуулъя. Саналын томъёоллыг уншиж танилцуулъя та бүхэнд.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичиг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих асуудал гэснийг хасах гэсэн саналын томъёоллыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. За санал хураалтад бэлдье. Санал хураалтад бэлдье. Санал хураалтад бэлдсэн үү?

Пүрэвдорж гишүүний гаргасан саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 17 гишүүнээс 9 гишүүн оролцож, 52.9 хувиар санал дэмжигдлээ.

Дараагийн санал. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын Пүрэвдорж гишүүний гаргасан 2 дахь санал шүү.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын хууль тогтоомж Засгийн газрын шийдвэрийн биелэлтэд хяналт тавих асуудал гэснийг хууль тогтоомж, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг Засгийн газрын шийдвэрийн биелэлтэд хяналт тавих асуудал гэж өөрчлөх. Учрал гишүүн Учрал сайд.

Н.Учрал: Засгийн газрын тухай хууль Хөгжлийн нэгдсэн бодлого төлөвлөлт түүний удирдлагын хуулиар хөгжлийн нэгдсэн бодлого төлөвлөлтийн асуудал нь Эдийн засгийн хөгжлийн сайдад хамаардаг. Нэг ёсондоо 5 жилийн үндсэн чиглэл, нэг жилийн хөгжлийн төлөвлөгөө, Засгийн газрын 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулдаг. Ингээд Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороон дээр жилийн төлөвлөгөө хөгжлийн бодлогын баримт бичгээ хамгаалдаг. Өмнө нь яг Сандагаа гишүүн хурал удирдаж байхад хэн бодлогын баримт бичгүүдийн тайланг тавих вэ гэхэд Одбаяр, Учрал, Гантөмөр сайд тухайн үед Евро Азийн хэлэлцээрт явчихсан байсан. Тэгээд Гантөмөр сайд аа та бодлогын баримт бичгийг хийсэн хүн тайлбарла аа гэхээр Гантөмөр сайд байхгүй. Тэгээд Одбаяр сайд бид 2 дундаа хийгээд ингээд эзэнгүй болдог. Тэгэхээр энэ юу юм бэ гэхээр дэлхий дахинд бүх л улсад дизайн хийгээд, мониторинг хийгээд эволюшн хийгээд байгаа нэг ёсондоо төлөвлөлт, төсөвлөлт, хяналт үнэлгээ буюу хөгжлийн бодлогын баримт бичиг, жилийн төлөвлөгөө өөрөө аймгийн дарга нарын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдаж байна уу гэдгийг нийцлийг хангахгүй бол өнөөдөр нэг жилийн хөгжлийн төлөвлөгөөнд ТЭЗҮ байхгүй, зураг төсөв байхгүй, урт хугацааны бодлогод нийцэхгүй олон зүйлүүд орж ирээд, ингээд төсөвт суулгая гэхээр зураггүй, ТЭЗҮ-гүй баахан ийм ажлууд төсөвт суугаад ороод ирдэг. Ингээд 5 дугаар сарын 31 гэхэд Сангийн яаман дээр 500 тэрбум төгрөгийн төсөл зогсож байна шүү дээ. Зарлагдаж чадахгүй, жилийн төлөвлөгөөнд сууцхсан гээд. Ингээд бүсийн хөгжлийн форум болдог. Бүсийн хөгжлийн форум дээр бүсүүд аймгууд өөр өөрсдийнхөө саналыг тусгадаг. Гэтэл тэр нь жилийн төлөвлөгөөнд тусаагүй байдаг. Гантөмөр сайд жилийн төлөвлөгөөгөө хийчихсэн байгаа шүү дээ. Гэтэл жилийн төлөвлөгөөнд тусаагүй бүсчилсэн хөгжлөөс баахан зорилт оруулж ирээд одоо болно гээд суугаад байдаг.

Түүнийг нь бодлогын баримт бичигт нийцэхгүй байна аа гэдэг Шадар сайдын хэмжээнд шахалт үзүүлж манлайлал үзүүлж байгаа л болохоос биш үүн дээр бодлогын баримт бичигтэй нийцэж байгаа юу гэдэг дээр нь хяналт тавих, үнэлгээ хийх механизм байхгүй юу. Засгийн газрын тогтоол шийдвэр тэр хууль тогтоомжийн хэрэгжилтийг угаасаа Засгийн газрын Хэрэг эрхлэх газар аваад хариуцаад ингээд явах ёстой. Зөвхөн цаашдаа энэ хяналт хэрэгжүүлэх газар гэдэг чинь ерөөсөө хөгжлийн бодлогын баримт бичгүүдээ хянадаг нь Хөгжлийн яам руугаа байгаад тэр Засгийн газрын тогтоол, шийдвэр, элдэв дотоод үнэлгээ, яам болгонд байгаа үнэлгээ мониторингийн тэр газрууд тэрийгээ өөрөө хариуцах чиг үүрэг рүү явахгүй бол энэ хэсгийг нь салгаад Үндэсний хороо болгочихсон чинь яг үнэндээ Одбаяр сайд бид 2 бол нөхөрсөг байдлаар л ажиллалаа шүү дээ. Ажиллалаа шүү дээ. Нөгөө хуулиар олгогдсон эрх юм биш. Одбаяр аа, найз аа, яах вэ л гэдэг байдлаар ажиллалаа шүү дээ. Тэрнээс биш Одбаяр бид 2-оос өөр хүн бол аягүй хүнд юм байна лээ. Гантөмөр сайд бид 2 ойлголцож байгаа учраас бид нар ажиллаж чадсан. Тэрнээс биш хууль тогтоомжийн хүрээнд энэ 3 хүн хоорондоо ойлголцдоггүй хүн байх юм бол маш хүндрэлтэй байна. Тийм учраас зүгээр ер нь цаашдаа ингэж явна. Мэргэжлийн хяналт бол энэ...

Ж.Бат-Эрдэнэ: Пүрэвдорж гишүүний гаргасан саналын томьёололтой холбогдуулан гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалт явуулъя. Энэ чинь одоо бэлдээд байна уу, дахиж бэлдэхгүй шууд санал хураалт болчхож болохгүй юу. Санал хураалт явуулъя. Шууд ингээд үзье. Санал хураалт.

Пүрэвдорж гишүүний гаргасан саналын 2 дахь саналын томьёоллыг дэмжье гэсэн. Сая би уншихсан шүү дээ. Дахиад унших юм уу. За дахиад уншъя.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын хууль тогтоомж Засгийн газрын шийдвэрийн биелэлтэд хяналт тавих асуудал гэснийг хууль тогтоомж, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг Засгийн газрын шийдвэрийн хяналтын биелэлтэд хяналт тавих асуудал гэж өөрчлөх.

Саналын томьёололтой холбогдуулан саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

18 гишүүнээс 8 гишүүн дэмжиж 44.4 хувиар санал дэмжигдсэнгүй ээ.

Б.Пүрэвдорж: Энийг нь засаад өгчихье. Засгийн газрын тухай хууль.

Ж.Бат-Эрдэнэ: Наадах чинь угаасаа хөгжлийн асуудал ярьж байгаа болбол энэ хөгжлийн бодлогын бичиг баримтдаа өөрөө хяналт тавиад явъя гэдэг чинь зөв биш юм уу уг нь бол. Дэгийнхээ дагуу 2 асуудал 2 санал гаргасан, 2 саналыг санал хураалт явуулсан. Нэг нь дэмжигдлээ, нэг нь дэмжигдсэнгүй. Өөр одоо буцаж ирэх ийм заалт болбол байхгүй, дэг байхгүй. Энэ дээр юм уу. Зөв л юм байна шүү дээ тэгвэл. Аль юм саналын томьёолол.

Рэгдэл гишүүн санал гаргасан байна. Саналын томьёоллыг уншиж танилцуулъя. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 3 дахь заалт шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого төлөвлөлт

гэснийг Шинжлэх ухаан, технологи, инновацын нэгдсэн бодлого, төлөвлөлт гэж өөрчлөх. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20 дахь хэсгийн 3 дахь заалт Өндөр технологи, үндэсний инновацын тогтолцооны бодлого төлөвлөлт хөгжүүлэх асуудал гэснийг хасах, мөн энэ хэсгийн 20.Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд гэснийг 20.Цахим хөгжил харилцаа холбооны сайд гэж өөрчлөх, мөн энэ хуулийн 18 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 14 дэх заалт 14.Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам гэснийг Цахим хөгжил, харилцаа холбооны яам гэж өөрчлөх. Саналаа танилцуулах уу? Рэгдэл гишүүний микрофон өгье.

Д.Рэгдэл: За баярлалаа. Тэгэхээр энэ бол шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын асуудал Эдийн засаг, хөгжлийн яаманд очсонтой холбогдуулаад өнгөрсөн жил Засгийн газар байгуулахдаа инновацын хэсгийг нь ямар ч үндэслэлгүйгээр цахим хөгжил харилцаа холбоон дээр тавиад тэгээд Засгийн газрын бүрэлдэхүүн бүтэц Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт орчихсон. Өнөөдөр дэлхий дахинд ерөөсөө шинжлэх ухаан, технологи, инновац гэдэг энэ 3 үйл ажиллагаа маань мэдлэгийг үйлдвэрлэлд шилжүүлэх тэр гинжин хэлхээний 3 үндсэн элемент. Энэ бол нэг газар нэг бодлогоор зангидаж байхгүй бол 2 өөр яаман дээр, шинжлэх ухаан технологи нь эдийн засаг, хөгжилдөө, инновац нь цахим хөгжил дээр яваад байх дээр зэрэг хоорондоо ерөөсөө уялдахгүй байгаа.

Өнгөрсөн жил эд нар ерөөсөө уялдаагаа хоорондоо огт мэдээлээ ч үгүй, ямар ч холбоогүй явж байгаа. Тийм учраас инновацыг нь энэ шинжлэх ухаан технологийн асуудал хариуцсан эдийн засаг, хөгжлөөрөө авчирч нийлүүлж байж шинжлэх ухаан технологийн нэгдсэн бодлого сая зангидагдана. Энийг бол Гантөмөр сайд маш сайн мэдэж байгаа. Энэ ингэхгүй болбол Үндсэн хуулийн 38 дугаар зүйлд заасан Засгийн газрын чиг үүрэгт зааж өгсөн тэр шинжлэх ухаан технологийн нэгдсэн бодлогыг боловсруулж хэрэгжүүлнэ гэдэг энэ чиг үүрэг завсар дундаа завсартай болчихоод байгаа 2 яаман дээр очихоор. Тэгэхээр инновацыг цахим хөгжлөөс нь салгаад Эдийн засаг, хөгжлийн яаманд авчирч ирье ээ инновацыг. Тэгэхээр шинжлэх ухаан, технологи, инновацын нэгдсэн бодлого төлөвлөлт гэдэг энэ чиг үүрэг нь Эдийн засаг, хөгжлийн яаман дээр очсоны үр дүнд энэ бодлого бол нэгдсэн бодлого болж сая чадна. Үүнтэй холбогдуулаад зүгээр дагалдах хуулиудад тэр нэрийг нь жаахан жаахан өөрчлөлт орж байгаа шүү дээ нэг. Ингэхгүй бол энэ алдаа улам удаашраад даамжраад зөндөө асуудал үүсгээд нэгдсэн бодлого дээрээ зангидахгүй явна шүү. Энийг би ер нь дахин дахин хөндөхгүй бол болохгүй байгаа. Бид нар дэлхийн чиг хандлагыг бас харах ёстой шүү дээ.

Ж.Бат-Эрдэнэ: Рэгдэл гишүүнээ, энэ Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд хөндөгдөөгүй заалт юм байна шүү. Хөндөгдөөгүй заалт юм бол энийг санал хураалтад оруулахгүй тийм. Оруулах боломжгүй, хөндөгдөөгүй заалт байна. Санал гаргах гээд байгаа юм уу? Хурдлаач.

Пүрэвдорж гишүүнээс зарчмын зөрүүтэй санал гарч байна лээ. Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай. 1 дүгээр зүйлд эдийн засгийн хөгжлийн асуудал, эдийн засаг, хөгжил, харилцаа хариуцсан Тэргүүн шадар сайд хариуцах ёстой гэж. Яах вэ энэ үндэслэл юм байна. Санал бол саналын томъёолол наадах чинь хэддүгээр хууль юм. За бууруулах асуудал. Наадах чинь 1 дүгээр зүйл юм уу. 1 дүгээр зүйлийн бууруулах асуудал гэсний дараа Бүсчилсэн хөгжлийн үндэсний хороог Эдийн засаг хөгжил хариуцсан тэргүүн Шадар сайдын эрхлэх

хүрээнд шилжүүлэх гэж нэмэх. Санал хураалт явуулах уу. Пүрэвдорж гишүүн тайлбар хэлье.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр 2024 оны 7 сарын 9-ний өдөр Засгийн газрын бүтцийн тухай хууль орж ирсэн. Тэр бүтцийн тухай хуулиар яригдаж байхад энэ асуудлыг Байнгын хороон дээр хэлсэн боловч Байнгын хороо дэмжээд, Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжээд явуулсан. Гэвч би одоо Их Хурал дээр ороод энэ бүсчилсэн хөгжлийн асуудал бол эдийн засгийн хариуцсан тэр одоо Тэргүүн шадар сайдын мэдэл дээр байх ёстой, юун тэр онцгой ямар ч хамаагүй одоо сайдын мэдэлд байж байх ёсгүй ээ гэж үзээд энэ асуудлаар эсэргүүцэл илэрхийлсэн. Гэвч яг тэр үеэр Амарсайхан сайд өөрөө би энэ саналаа татаж авлаа гэж хэлсэн.

Ер нь бол яг тэр чинь Амарсайхан сайдын зарчмын зөрүүтэй саналаар орж ирээд тэгээд Амарсайхан сайд өөрөө би энэ саналаа татаж авлаа гэж хэлж байхад яагаад бүтцийн тухай хуульд тэр бүсчилсэн хөгжлийн үндэсний хороо яагаад үлдчихсэн юм бэ? Тэрийг одоо энэ хуулийн хулгай л гэж би хэлээд байгаа юм. Энэ бол ерөөсөө би дахиад одоо энэ Туул референт бол маш сайн мэдэж байгаа ахлах референт. Энэ бол яг цэвэр хуулийн хулгай болсон. Би одоо энийг нарийвчлан гаргах гээд бичиг өгчихсөн байгаа. Тэгээд энэ ийм хурдан бас Засгийн газрын бүтцийн асуудал орж ирэхийг одоо мэдсэнгүй.

Тийм учраас ерөөсөө энэ хөгжлийн асуудал бол эдийн засгийн хариуцсан эдийн засаг хөгжил хариуцсан тэргүүн шадар сайд л ярих ёстой, хариуцаж байгаа. Тэгэх дээр тэнд хороо нөгөө бүсчилсэн хөгжлийн үндэсний хороо нь байхгүй тээр тэнд нэг юу стандартчилал хариуцдаг, аль эсвэл юу хариуцдаг тийм ээ, тийм стандартчилал хариуцдаг, онцгой хариуцдаг тэр шадар сайд дээр оччихсон тэр нь зүгээр нэг ийм тойруулж нэг юу нь уулзалт хийснээс өөр монголын хөгжилд нэг ширхэг ч хувь нэмэр өнгөрсөн жилийн хугацаанд оруулсангүй ээ. Тийм учраас энэ саналыг та нар нэг дэмжээд өгөөч ээ. Ер нь харьяалдаг газраа л харьяалъя. Учрал аа чамд тэр хяналт шалгалт очиж байхаар энэ очсон нь хамаагүй дээр.

Ж.Бат-Эрдэнэ: Пүрэвдорж гишүүний гаргасан саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

18 гишүүнээс 10 гишүүн санал хураалтад оролцож 55.6 хувиар санал дэмжигдлээ. Одоо ингээд ийшээ явж байна.

2 дугаар заалт Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр санал асуулт, саналтай гишүүд байна уу, алга байна.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйл дээр асуулт саналтай гишүүд байна уу? алга байна.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүд байна уу? алга байна.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 5 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүд байна уу? алга байна.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

3.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт саналтай гишүүд байна уу? Алга байна.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүд байна уу? алга байна.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйл дээр асуулт саналтай гишүүд байна уу? алга байна.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүд байна уу? Алга байна.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

4.Засгийн газар дахь хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр саналтай гишүүд байна уу? Асуулт, саналтай гишүүд байна уу? За Пүрэвдорж гишүүнээс санал гаргасан байна. За саналын томъёоллыг уншиж танилцуулъя.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах

1. 1 дүгээр зүйл.Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

3.4.Энэ хуулийн 3.1-д заасан этгээдээс хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, захирамж, хурлын тэмдэглэл. Цаашид хууль тогтоомж, бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэхэд хяналт тавих ажиллагаанд энэ хууль үйлчилнэ. Санал гаргасан УИХ-ын гишүүн Б.Пүрэвдорж. Саналын томъёоллыг Пүрэвдорж гишүүний гаргасан саналын томъёоллыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 18 гишүүнээс 10 гишүүн оролцож 55.6 хувиар санал дэмжигдлээ.

2.Хуулийн төслийн Засгийн газар дахь хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр саналтай санал, асуулт, саналтай гишүүд байна уу? За Пүрэвдорж гишүүний гаргасан санал байгаа юм байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

2. 2 дугаар зүйл. Засгийн газар дахь Хяналтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтын Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны даргаас гэснийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаас гэж, 11 дүгээр зүйлийн гарчиг, мөн зүйлийн 11.1, 11.3 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн Монгол Улсын

Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Хяналт үнэлгээний Үндэсний хорооны даргын гэснийг Монгол Улсын сайд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын гэж, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 17.1.7 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.1, 19.3 дахь хэсгийн Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний үндэсний хорооны даргад гэснийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад гэж, 18 дугаар зүйлийн 18.6 дахь хэсгийн Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Хяналт үнэлгээний Үндэсний хорооны дарга гэснийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга гэж тус тус өөрчилсүгэй.

За саналтай холбоотойгоор Пүрэвдорж гишүүний гаргасан саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

18-аас 10 гишүүн санал хураалтад оролцож 55.6 хувиар санал дэмжигдлээ.

3.Засгийн газар дахь хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүд байна уу? Алга байна.

Засгийн газар дахь хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүд байна уу? Алга байна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүд байна уу? алга байна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын хууль. Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүд байна уу? Алтангэрэл гишүүн асуулт.

О.Алтангэрэл: Энэ Хилийн боомтын үндэсний зөвлөл гээд их чухал бүтэц байгаад байгаа юмаа. Тэгээд энэ үндэсний зөвлөлийн дарга нь санхүү төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна гэж өөрчилж байгаа юм байна. Нөгөө боомтын асуудал шилжсэнтэй холбоотойгоор л орж байгаа өөрчлөлт байх л даа. Тэгэхдээ ер нь энэ Хилийн боомтын үндэсний зөвлөл чинь тэгээд яг хуучнаараа энэ бүтцэд очоод ажиллаж чадах юм уу? Ер нь энэ Хилийн боомтын үндэсний зөвлөлтэй холбоотой асуудлыг зөвхөн нэг дарга нь өөрчлөгдсөн бол тэр даргын нэг нэрээр нь сольчихъё, чиг үүрэг нь шилжсэн бол тэр сольчихъё гэдгээс өөрөөр энэ үндэсний зөвлөлийн үйл ажиллагаатай нь холбогдуулж энд үйл ажиллагаа явуулах боломж бололцоо байна уу гэдэг дээр хийсэн судалгаа байна уу. Эсвэл зүгээр л нэр солигдож байгаа учраас оруулчихсан юм уу гэдэг ийм асуулт байна ажлын хэсгээс.

Ж.Бат-Эрдэнэ: Хэн хариулах вэ? Ажлын хэсэг хариулах хүн байна уу? Хэн хариулах юм? За Жавхлан сайд.

Б.Жавхлан: Алтангэрэл сайдын асуултад хариулъя аа. Боомтын зөвлөл 2022 он хүртэл Сангийн яаман дээр байсан юмаа тийм. Би бас хэрэглэж байсан юм.

Тэгээд 2022 онд орсон бүрэлдэхүүний өөрчлөлтөөр ингээд сайдтай болох нь зүйтэй, тэгэхгүй бол нөгөө гадаад худалдааны том эдийн засагтай улс эдийн засаг маань гадаад худалдаанаас хамаардаг улсын хувьд тусдаа сайдтай байхгүй бол болохгүй ээ гээд ингээд санал оруулж байсан юм.

Одоо ингээд энэ удаад төсөвт орлоготой холбоотойгоор яах аргагүй одоо үйл ажиллагаанууд хумигдаж байгаа учраас ингээд 3 сайдын эрхлэх үйл ажиллагаа нь яамдууд руу шингэж байгаа юм. Тэгэхээр энэ боомтын одоо яг тулгамдчихсан байгаа асуудал бол одоо 7 боомт дээр төсөл хэрэгжиж байгаа, Азийн хөгжлийн банк, Хятадын буцалтгүй тусламжаар та сайн мэдэж байгаа. Тэгээд энэ ажлуудыг яаралтай дуусгах нь маш чухал байгаа. За Хэрэг эрхлэх дээр, би энийг өөрөө авъя гээд гүйгээд байгаа юм байхгүй шүү ийм байгаа. Тэгээд ингээд ярилцаж байгаад энэ ажлуудыг яаралтай явуулъя аа гэдгийг ингээд шийдсэн.

Дээрээс нь Ерөнхий сайдын санал болбол бас бид нар ярилцсан зүйл гэвэл юу вэ гэхээр цаашдаа Засгийн газар дээр энэ боомтын зөвлөл гэж байгуулагдана аа зөвлөл шүү. Тийм нөгөө нэг орон тоотой тийм хороо биш зөвлөл байгуулагдана. Сайдын хэмжээнд байна уу, эсвэл дэд сайд нарын хэмжээнд бас ийм бүтэц хийгээд үйл ажиллагаа хоорондоо уялдуулаад ингээд л явах юм байгаа юм. Орон тооны бүс шүү тийм. Ер нь болбол энэ боомтын асуудал бол салбар хоорондын ийм зохицуулалтын асуудал цаашаагаа улам л тэлнэ. Тийм оролцоонууд бас нэлээн сайн хангаж ажиллах шаардлагатай болж ирнэ. Тэгэхдээ төслүүд маш чухал байгаа. 2 том төсөл явж байгаа. Азийн хөгжлийн банкны рефс төсөл Хятадын буцалтгүй тусламжаар.

Бид ноднинхон юуныхаа, Замын-Үүд орсон, Боршо орчихсон байгаа. Хойд талын боомтууд бол Азийн хөгжлийн банкаар, урд талын боомтууд бол одоо Бичигт одоо эхлэх ёстой, Ханги Мандал гээд энэ боомтууд, Гашуунсухайт гээд эдгээр боомтууд дээр одоо төслүүд хэрэгжиж байгаа. Энийг яаралтай дуусгах нь хамгийн түрүүнд тулчихсан ажлууд байгаа шүү.

Ж.Бат-Эрдэнэ: Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүд байна уу? алга байна.

Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйл дээр асуух асуулт, саналтай гишүүд байна уу? Алга байна.

Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүд байна уу? Алга байна.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүд байна уу? алга байна.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай хуулийн Улсын Их Хурлын тогтоолын төсөл дээр асуулт, саналтай гишүүд байна уу? Алга байна.

Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг хийж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн хэн танилцуулах вэ? За Баярбаатар гишүүн танилцуулъя.

12:31

Ж.Бат-Эрдэнэ: Дараагийн асуудалд орёе.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 3 гишүүн. 2025 оны 3 сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэх.

Хуулийн хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин хийнэ. Тэмүүжин гишүүний микрофоныг нээе.

Х.Тэмүүжин: Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 20 дугаар зүйлд Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална. 25 дугаар зүйлийн 1-д Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ. Мөн зүйлийн 1.8-д Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах онцгой бүрэн эрхтэй гэж заасан.

Өнөөдөр Улсын Их Хурлын энэ бүрэн эрхүүдийн нэг хамгийн чухал байгаа нэг эрх бол хүний эрхийн талаас хуулийн засаглалын талаас хууль сахиулах гэмт хэрэгтэй тэмцэж байгаа, ял эдлүүлж байгаа байгууллагуудын гүйцэтгэх ажил гэж нэрлэгддэг нууц мөрдөн шалгах ажиллагаатай холбоотой нууц далд аргаар мэдээлэл цуглуулдаг, тэр мэдээлэл дээрээ дүн шинжилгээ хийх замаар хууль сахиулдаг, гэмт хэрэгтэй тэмцдэг, ял эдлүүлэх ажиллагааныхаа аюулгүй байдлыг хангадаг энэ байгууллагуудын энэ чиг үүрэгтэй холбоотой хяналт бол парламент дээр бол байхгүйтэй адилхан байгаа .

Улсын Их Хурал дээр Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хороон дээр Тусгай хяналтын дэд хороо байгаа боловч өнгөрсөн байгуулагдсанаасаа хойших энэ гучаад гаран жилийн хугацаанд зөвхөн төсөв хэлэлцэх үед энэ байгууллагуудын гүйцэтгэх ажилтай холбоотой төсвийг л оруулж ирдгээс өөрөөр чиг үүрэг огт хэрэгжүүлдэггүй тусгай хяналт байгаад байгаа. Гэтэл Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хуулиас гадуур гүйцэтгэх ажил явагддаг, гүйцэтгэх ажил явагдаж байгаа төсөв мөнгө болон үйл ажиллагаа хуульд хэрхэн нийцэж байгаа хүний эрхийг

хэрхэн одоо хөндөж зөрчиж байгаа талаарх баримт мэдээ, хардалт бол газар хавтгайрсан байгаа.

Тийм учраас парламент өөрөө төрийн эрх барих дээд байгууллагын хувьд хуулийн биелэлтийг хянадаг одоо энэ чиг үүрэгтэйн хувьд энэ чиг үүргээ оновчлох шаардлага бол үнэхээр бодитойгоор тулгарсан. Бусад улс орнуудыг харахад бол хууль сахиулах гэмт хэрэгтэй тэмцэх энэ ял эдлүүлэх чиг үүргийг эрхлэх асуудлынхаа хүрээнд бол Хууль зүйн байнгын хороонд хэрэгжүүлдэг. Хууль зүйн байнгын хороо энэ эрхлэх асуудлынхаа хүрээнд 2 чиглэлээр хяналтаа маш тодорхой явуулдаг юм байна лээ.

Нэгдүгээрт, иргэний үндсэн эрхтэй холбоотой хүний эрхийн зөрчил байна уу, үгүй юу, хоёрдугаарт хуулийн засаглал буюу хууль дээдлэх зарчим мөрдөгдөж байна уу, үгүй юу гэдэг талаараа хянадаг. Манай Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороон дээр байгаа Тусгай хяналтын дэд хорооны чиг үүрэг нь болохоор аюулгүй байдал талаасаа хянадаг. Тэгэхээр энэ 2 нөгөө чиглэлийн хяналтын иргэний эрх хуулийн засаглалтай холбоотой хяналт нь алга болчихоод, аюулгүй байдлын хяналт нь огт хэрэгждэггүй, зөвхөн төсөв хэлэлцэх явцад чиг үүргээ хэрэгжүүлэх гэж оролддог энэ байдлаасаа болоод Монгол Улсад хаа сайгүй одоо бол чагнаад байна, тагнаад байна, хувийн мэдээллийг төрийн байгууллага хууль бусаар цуглуулаад, түүнийгээ хэвлэл рүү гаргаад, одоо өрсөлдөгчөө намнах улс төрийн арга хэрэгсэл болоод байна гэх мэтчилэн. Сүүлдээ бүр юу болж хувирсан гэхээр шүүхэд хянагддаггүй маш их хэмжээний хяналтууд, гүйцэтгэх ажлууд бий болж эхэлсэн.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хууль шинэчлэн батлагдсантай холбоотой нууц мөрдөн шалгах ажиллагаа гэдэг ойлголт хуульчлагдсан. Гэтэл нууц мөрдөн шалгах ажиллагаатай холбоотой парламентын хяналт огт байхгүй байгаа Монгол Улсад. Тэгээд энэ нөхцөл байдлуудыг хараад Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хууль сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх, ял эдлүүлэх үйл ажиллагаанд тусгай хяналтын дэд хороо байгуулаад, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороон дээр Тагнуул, армитай холбоотой аюулгүй байдлын хяналт нь тэндээ үлдээд, чиг үүргээ ингэж оновчлох хэрэгцээ байгаа учраас Тусгай хяналтын дэд хороо байгуулах хуулийн төслийг нэр бүхий гишүүд өргөн барьсан. Тусгай хяналтын дэд хороо буюу энэ дэд хороо байгуулах нь бол хуульд заасан дэд хороо гэдэг статустай байгаа учраас хуулийн төсөл өргөн барьж, хуулийн өөрчлөлтөөр оруулахаар өргөн баригдсан байгаа.

Зүгээр мэдээлэл болгоод хэлэхэд үнэхээр манай энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын алдаа дутагдал юун дээр илүү тод гарсан бэ гэхээр эрүү шүүлт. Монгол Улсад гарч байгаа эрүү шүүлтийн гэмт хэргийн болон эрүү шүүлттэй холбоотой асуудлын бараг 60, 70 хувь нь гүйцэтгэх ажил буюу нууц мөрдөн шалгах ажиллагааны ард явагдаж байна. Энийгээ юугаар хааж одоо парламентын хяналт болон шүүхийн хяналтаас гадуур байлгаж байна вэ гэхээр энэ өөрөө нууц аргаар гэмт хэрэг илрүүлэх гэж байгаа учраас та нарт хянагдах албагүй гэдэг зарчим ер нь бол хавтгайдаа тогтсон байна. Сүүлдээ зөвхөн шүүгчид ийм юм байгаа учраас та ийм шийдвэр гарга гэж Шүүх хуралдаанаас гадуур, хавтаст хэргээс гадуур, шүүхийн хэлэлцүүлгээс гадуур мэдээ баримт үзүүлэх замаар бүр ял шүүхийн шийдвэр гаргуулдаг тийм одоо тогтолцоо үүссэн байна. Тэгээд энэ бүгдийг таслан зогсоохын тулд Улсын Их Хурал дээр юу хэрэгтэй вэ гэхээр энэ цаана юу

болоод байгааг мэдэхгүйгээр хууль сайжрахгүй. Энэ мэдээллүүдийг Улсын Их Хурал авахгүйгээр бодлогын өөрчлөлт гаргаж чадахгүй. Энэ мэдээллүүд дээр парламент хяналтаа оновчлохгүйгээр ямар ч практик өөрчлөгдөхгүй.

Тийм учраас Монгол Улс ардчилсан улс, хүний эрхийг эрхэмлэдэг Үндсэн хуулийн байгуулалтай хуулийн засаглалын төлөө явж л байгаа бол парламент энэ чиглэл дээр хуулийн биелэлтийг хянах Тусгай хяналтын дэд хороогоо оновчлох хэрэгцээ шаардлага үнэхээр байна аа. 30 жил гацсан байна, 30 жилийн энэ гацсан гацааг гаргахгүйгээр парламент хүний эрхийн талд зогсож чадахгүй. Тэгээд бид чинь одоо Улсын Их Хурлын стратеги төлөвлөгөө баталчихсан. Стратеги төлөвлөгөөний нэг том зорилт бол хүний эрхэд суурилсан хүн төвтэй хууль зүйн бодлого хэрэгжүүлнэ гээд зарлачихсан. Энэ Тусгай хяналтын дэд хороо бол яг энэ зорилгын төлөөх дэд хороо. Хүний эрхийн хяналт, хуулийн засаглалын хяналтыг оновчлох байдлаар Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Тусгай хяналтын дэд хороо байгуулах гэж байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Хууль санаачлагчийн илтгэл болон төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алтангэрэл гишүүнээр тасаллаа. Баярмаа гишүүнээр тасаллаа. Болормаа харсангүй уучлаарай. Харин ёстой харагдсангүй, дөхүүлээд л дөхүүлээд л уншихлаа. Уучлаарай. Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Сая Тэмүүжин гишүүний хууль санаачлагчийн тайлбарыг сонслоо. Зарчмын хувьд бас болохгүй юм байхгүй гэж бодож байна. Гэхдээ одоо бид нар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос Тусгай хяналтын дэд хорооны чиг үүрэг бүхий 2 агентлагийн эрхлэх асуудлыг Хууль зүйн байнгын хороондоо авчирч байгаа юм байна аа хуулийн төслөөр. Тэгээд та сая тайлбартаа хэллээ. Тусгай хяналтын хороо ерөнхийдөө нэг төсөв хэлэлцэх үеэр л асуудлыг ярьдаг. Үндсэндээ хяналтын чиг үүрэг бол одоо бараг үндсэндээ байхгүйтэй адил болсон гэж хэлж байна. Тэгэхээр энэ Тусгай хяналтын дэд хороо өнгөрсөн хугацаанд яг хэрхэн яаж ажилласан юм, юу хийсэн юм. Энийг бас одоо практик хэрэгцээ шаардлагын үүднээс хууль санаачлагч нар ярилцсан уу, танилцсан уу, мэдээлэл авсан уу? Тусгай хяналтын дэд хороо тэнд юу хийж байна. Хүний эрх, эрх чөлөө, ял эдлүүлэх үйл ажиллагаа, хууль сахиулах үйл ажиллагаа энэ чиглэлээрээ одоо тэнд нь хяналт тавьж байна уу, үгүй юу.

Энэ чинь одоо Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооныхоо эрхлэх асуудлын хүрээнд ч байсан Хууль зүйн байнгын хороонд ч ирсэн гэсэн тэртээ тэргүй хаалттай хуралддагаараа хуралдаад л явна асуудал. Нэг их олон нийтэд одоо тэндээс авчраад Хууль зүйн байнгын хороонд асуудал тавилаа гэхэд үйл ажиллагаа нь нэг их ил тод нээлттэй байгаад байх боломжгүй. Яагаад гэхээр дандаа нууц ажиллагаанууд энд яригдах учраас Хууль зүйн байнгын хорооны, Аюулгүй байдлын байнгын хорооны хэдэн гишүүдийн хүрээнд яригддаг байсан бол одоо Хууль зүйн байнгын хорооны хэдэн гишүүдийн хүрээнд л яригдах асуудал болох нь тэр.

Тэгээд өнгөрсөн хугацаанд Аюулгүй байдал, байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээндээ Тусгай хяналтын дэд хорооны тайланг тавиулсан уу, сонссон уу, энэ талаар мэдээлэл байна уу, хэрхэн яаж ажилласан юм. Улсын Их Хурал хяналт шалгалтынхаа чиг үүргийг энд одоо хэрхэн яаж тавьсан юм гэдэг нэг асуудлыг та бүхэн тодруулж өгөөч. Нөгөө талаар одоо Аюулгүй байдлын байнгын

хороо чинь өөрөө юу гэж үзэж байгаа юм энэ асуудал дээр, юу гэж үзэж байгаа юм. Улсын Их Хурлын тухай хуулийн 27.4 дээр үндсэндээ энэ чинь шинэ байнгын дэд хороо байгуулах гэж байна аа, Хууль зүйн байнгын хорооны дэргэд. Манай Хууль зүйн байнгын хорооны дэргэд Хүний эрхийн дэд хороо л гэж хороо байгаа одоо бичигдсэн хуулин дээр.

Тэгээд цаашдаа хүний эрхийн дэд хорооны ард дээр хууль сахиулах чиг үүрэг хяналтын дэд хороо гэж орж ирэх нь л дээ. Тэгэхээр дэд шинэ хороо байгуулагдах нь байна шүү дээ. Тэгэхээр Аюулгүй байдал байнгын хорооноос нь саналыг нь авсан юм уу албан ёсоор, ярилцсан юм уу? Үндсэндээ бараг бид нар дээрэмдэх гэж байна шүү дээ. Хууль зүйн байнгын хороонд шууд өгөх гэж байна. Тэгээд энэ тал дээр та одоо бас Аюулгүй байдлын байнгын хорооны дарга чинь хэн билээ дээ. Тэмүүлэн дарга байгаа юу? Тэмүүлэн дарга мэдэж байгаа юу?

Ж.Бат-Эрдэнэ: За Тэмүүжин гишүүн хариулъя.

Х.Тэмүүжин: За сүүлийнх нь асуултаас эхэлье. Ер нь бол санал авах гэдэг ойлголт хууль тогтоогч хэрвээ санал авах бол Улсын Их Хурал буюу хууль тогтоох байгууллагаас гадна байгаа чиг үүрэг бүхий институцүүдээс хуулийн саналыг бол авдаг. Дээд шүүхээс, Засгийн газраас гэх мэтчилэн. Хууль тогтоох байгууллагын дотоод бүтцээс бол санал авна гэдэг ойлголт байхгүй. Яагаад гэвэл хууль тогтоох байгууллага чинь өөрөө Байнгын хороод болон нэгдсэн чуулганд хуваагддаг учраас тэд өөрсдөө кнопоороо саналаараа Улсын Их Хурлын гишүүд дэмжинэ, дэмжихгүйгээ илэрхийлээд асуудлаа шийддэг. Үндсэн хууль дээр маш тодорхой заасан байгаа. Монгол Улсын Их Хурал 126 гишүүнээс бүрдэнэ ээ, 126 гишүүн ажлаа явуулахдаа нэгдсэн чуулган болон байнгын хороодод хуваагдана. Энэ зохион байгуулалтын хэлбэр болохоос биш нөгөө бүрэн эрхтэй статустай субъект биш байхгүй юу. Бүрэн эрхтэй статустай субъект чинь гүйцэтгэх эрх мэдэл байна, шүүх эрх мэдэл байна, Ерөнхийлөгчийн институц байна, Тэгэхээр бид нөгөө санал авах гэдэг энэ ойлголтыг хавтгайруулан ерөнхий ийм байдлаар томоор Үндсэн хуультай зөрчилдөж ашиглаж ерөөсөө болохгүй.

Хоёрт нь таны дурдаад байгаа зүйл заалт бол хуулиар байгуулагддаг дэд хороотой холбоотой, хуулиар байгуулагдахгүй Улсын Их Хурлын тогтоолоор байгуулагдах дэд хороотой холбоотой асуудал. Өнөөдөр бидний өргөн бариад байгаа асуудал чинь хуульд өөрчлөлт оруулах гэж байгаа юм. Хууль санаачлах эрхийнхээ хүрээнд хууль тогтоох байгууллага үйл ажиллагаа руу оруулж ирж байгаа юм. Хууль тогтоох байгууллагын үйл ажиллагаа эхлэх гэж байхад түүний дотоод нэг бүтэц хууль тогтоох байгууллагын юуг зогсоож болохгүй шүү дээ. Эрхлэх байнгын хороонууд нь хэлэлцэх эсэхээ шийдээд, чуулганаар эцэслэн шийдээд л явдаг тийм л парламентын жишиг байгаа.

За 1 дүгээр асуулт дээр анх энэ Тусгай хяналтын дэд хороо байгуулагдахдаа Энхбаатар гэдэг нэг генерал байсан. Ардчилсан хүчний холбооноос сонгогдсон. Тухайн үедээ тагнуулын байгууллага дээр парламентын хяналтыг хэрэгжүүлэхийн тулд анх Тусгай хяналтын дэд хороо байгуулагдсан юм байна лээ. Тэнд одоо тагнуулын байгууллагын үйл ажиллагаа болон тухайн үеийн удирдлагуудад хариуцлага тооцохтой холбоотой нэлээн маргаантай хяналтууд яваад, тэр хяналтаасаа хойш энэ Тусгай хяналтын дэд хороо үнэндээ энэ хяналт шалгалт явуулаагүй. Яагаад явуулаагүй гэхээр энэ Тусгай хяналтын дэд хороо хэрхэн яаж ажиллах тухай дүрэм журам гараагүй.

Бусад улс орнуудад ингээд харьцуулаад харахад Байнгын хороод өөрсдөө яаж ажиллах дүрмээ, дэд хороод өөрсдөө яаж ажиллах дүрмээ баталж болдог ч гэсэн Тусгай хяналтын дэд хороог нь парламент нь өөрөө баталж өгдөг юм байна лээ. Парламент нь тусгай хяналтаа яаж хэрэгжүүлэх юм, ямар журмаар явах юм, ямар зарчмууд баримтлах юм гэдгээ парламент нь өөрөө баталж өгөөд тэр баталсан дүрэм журмынх нь дагуу тэр тусгай хяналт нь хэрэгждэг юм байна лээ. Монгол Улсад энэ ерөөсөө хэрэгжээгүй, хийгдээгүй. Тийм учраас огт дүрэм журамгүй байгаа, огт дүрэм журамгүй байгаа учраас байгаа учраас ажилладаггүй үндсэндээ. Тусгай хяналтын дэд хорооны өмнөх даргууд та бүхэн бүгдээрээ мэдэж байгаа. Сү.Батболд дарга байсан. Тэрний өмнө бас гээд ингээд явахаар ер нь бол зүгээр практикаараа шүү. Практикаараа хамгийн мөнгөтэй хуулийн байгууллагуудад ашиг сонирхолтой байж болох хүмүүс Тусгай хяналтын дэд хорооны даргын ажлыг аваад зүгээр унтуулдаг байсан түүхтэй юм байна лээ.

Тийм учраас бид энэ одоо тусгай хяналтын чиг үүрэг яагаад манайд хэрэгжээгүй гэдэг бол нөгөө нийтийн ашиг сонирхол, ард түмний төлөөллийнхөө хувьд парламент хууль тогтоох байгууллагын хувьд яаж ажиллах вэ гэхээс илүүтэйгээр энэ Тусгай хяналтын дэд хороогоор дамжуулаад хуулийн байгууллагуудтай хэн хэлхээ холбоотой байх вэ гэдэг зарчим ажилласан учраас энэ Тусгай хяналтын дэд хороо мухар олгой шиг ажиллагаагүй болчихсон юм байна лээ. Тэгэхээр бид бол Тусгай хяналтын дэд хороонуудаа ингээд шийдлээ гэхэд хаана байсан ч гэсэн энэ Тусгай хяналтын дэд...

Ж.Бат-Эрдэнэ: Болормаа гишүүн асуултаа асууя. Гишүүд танхимдаа орж ирнэ шүү.

Э.Болормаа: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе ээ. Ингээд Тэмүүжин гишүүний оруулж ирсэн энэ Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, энэний ач холбогдлыг би одоо илүү их ойлгож эхэлж байна. Анх энэ хуулийг өргөн барихад бол илүү нэг тийм улс төрийн талтай ч юм уу ийм байх үед нь би хуульчидтай бас ярьж үзсэн юм. Энэ онолын хувьд зөв өө гэдэг одоо онолын талаас нь мэдээлэл аваад, би өөрөө хуульч биш учир тэр талаас нь судалж үзлээ. Энэ нь бас өнгөрсөн жилийн хугацаанд нөгөө яриад байдаг хонгил гэдгийнх нь бас зах зухаас нь харж үзлээ. Улсын Их Хурлын гишүүн болоод, гишүүн бус байх үед ингээд нэг алс холын юм яриад л эндээс нэг наана цаанаас нь зүгээр сонссон төдий байдаг. Тэгээд олон улс төрчид энэ нөгөө нэг хонгил гэдэг зүйлийг яриад байдаг мөртөө гишүүн болчихоод тэрийг буулгахын төлөө юу ч хийдэггүй юмаа гэдгийг би аягүй олон хүнээс сонсож байсан юм.

Тэгэхээр магадгүй энд одоо өнөөдөр өргөн барьж байгаа зүйл энэтэй холбоотой юм болов уу ч гэдэг ийм мэдрэмж шинэхэн сонгогдсон гишүүний хувьд бас хэлж байгаа юм. Сая би олонхын бүлгийн төлөөлөл гишүүн. Дотроо зарчим яриад олон гишүүнтэй ингээд нийлээд явж байхад гарын үсэг зуруулах гээд явж байхад бүр нэг гишүүнээс би энийг зурахаас айж байна гэдэг үг сонсоод гайхсан. Юу гэсэн үг вэ энэ чинь одоо зарчмын асуудал бид нар ярьж байна шүү дээ гэдэг. Энэний цаана одоо олон юм явдаг юм байна. Энэ хувь хүний асуудлууд биш юм байна, энэ тогтолцооны асуудал юм болов уу гэдэг ийм мэдрэмж төрсөн. Тэгээд өнөөдөр бид энэ дээр тогтолцооны шийдэл гаргах гээд байгаа юм болов уу гэдэг ийм бас надад бол ийм дүгнэлт гарч ирж байна.

Тэгэхээр Тэмүүжин гишүүний хувьд одоо маш туршлагатай улс төрчийн хувьд би яг танаас асуумаар байна л даа. Энэ одоо нөгөө хонгил гэгч зүйлтэй холбоотой юу? Тэр хонгил гэгч зүйлийг нураахад энэ тогтолцооны өөрчлөлт оруулах ийм хуулийн төсөл үү гэж асууя.

Ж.Бат-Эрдэнэ: Алтангэрэл гишүүн, Тэмүүжин гишүүн.

Х.Тэмүүжин: Болормаа гишүүний асуултад хариулъя. Үнэхээр тийм. Ер нь бол шударга бусын хонгил гэдэг гарчиг бүхий хуулийн байгууллагуудаар дамжуулж улс төрчид одоо захиа даалгавар өгдөг, хуулийн байгууллага нь онилсон мөрдлөг зохион байгуулдаг. Тэгээд энэ нэг өш авах юм уу, эс үгүй бол айлган сүрдүүлэх юм уу ямар нэгэн байдлаар улс төрчдийг баримталж байгаа байр суурь, зарчим, үзэл бодлоос нь няцаах, буцаах эс үгүй бол юу гэдэг юм энэ айдас дээр нь дөрөөлөөд өөрийнхөө бригадад авах гэдэг ч юм уу нэг ийм ажил бол эхлээд бараг нэг 20-иод жил болж байна ний нуугүй хэлэхэд. Харамсалтай нь энэ хонгилыг нураана. Энэ хонгил ямар муухай юм, аймшигтай юм гэж ярьж гарч ирсэн хүмүүс хонгилоо өөрийн болгож л хувиргаад байгаа болохоос биш энэ хуулийн байгууллага дотор угсрагдчихсан байгаа энэ зүй бус хуульд захирагддаггүй энэ тогтолцоог бол нураах гэж ерөөсөө оролдохгүй байгаа юм. Хэн одоо Монголын нэг үлгэр байдаг шүү дээ. Мангас дарах гэж явсан баатрууд буцаад өөрсдөө мангас болдог гэдэг шиг. Тэгээд энэ байдлыг зогсоох дэлхийд бол ерөөсөө гуравхан л арга байгаа.

Нэгдүгээрт, прокурорын буюу одоо Засгийн газрын дотоод хяналт яаж явах юм гэдгээс. Монгол Улсад харамсалтай нь прокурорт Засгийн газрын дотоод байдаггүй учраас энэ өөрөө гадна гарчихсан.

Хоёрдугаарт нь шүүхийн хяналт. Гэтэл бид одоо шүүхийн хяналтыг бэхжүүлэх зорилготой урьдчилсан хэлэлцүүлэг гэх мэтчилэн процессыг анх удаа арай гэж ядан хийж байна. Гэхдээ шүүхэд бүрэн энэ хяналтын эрх мэдлүүд очоогүй байгаа.

Гуравт нь ямар хяналт вэ гэхээр ерөөсөө л ард түмний буюу парламентын хяналт. Парламентын хяналтыг хэдий чинээ зөв оновчилно тэрэнд тэнд төдий чинээ одоо янз бүрийн сонирхолтой улс төрийн хүчин байдаг учраас нэг нэгэндээ барьцаалагдахгүйгээр хуулиас гадуур даварч байгаа, энэ хууль сахиулах гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагуудын үйл ажиллагааг зогсоох маш хүчтэй механизм ажиллаад эхэлдэг юм байна лээ. Тэрний нэгийг л ингээд одоо хуульчлах гэж оролдож байгаа. Өмнө нь бол парламент энэ чиглэлээр зоригтой алхам хийж чаддаггүй байсан нь юу вэ гэхээр зэмсэггүй байсан, учраа олдоггүй байсан, яаж ажиллахаа мэдэхгүй байсан. Тусгай хяналтаа оновчлохоор яаж ажиллахаа мэдэж эхэлнэ гэсэн үг.

Парламентын чинь нэг давуу тал түрүүн Сандаг-Очир гишүүний асуултад бас гарна лээ. Парламент хяналтынхаа туслалцаатайгаар хуулиас давсан гэмт хэргийн шинжтэй болохгүй байгаа үйлдлүүдийг ард иргэдийн мэдэх эрхийн хүрээнд оруулж ирж байгаа. Сонсгол зохион байгуулна, зарим нь хаалттай зохион байгуулж болно. Гэхдээ гэмт хэргийн шинжтэй, эрүү шүүлтийн шинжтэй, хуулиас давсан байх юм бол гэмт хэргийг нуух нь парламентад ч хүртэл хориотой байх ёстой. Монгол Улсад гэмт хэргийг нуусан бол иргэн шоронд орж байгаа, ял эдэлж байгаа. Энэ гэмт хэрэг гараад байна аа гэдгийг мэдэж байгаа мөртөө парламент нуух юм бол энэ өөрөө Үндсэн хуулийн бус зүйл болж хувирах ёстой байхгүй юу. Тийм учраас үнэхээр

төрийн эрх мэдлээр парламентаас шилжүүлсэн хууль тогтоомжийг буруу хэрэглээд эсвэл хууль тогтоомжоос нь гадуур гэмт хэрэг хийж байгаа бол тэр гэмт хэргийг таслан зогсоох, ард иргэдийн мэдэх эрхийг хангах, тэр бодлого дээр ямар бодлого байх ёстой вэ гэдгийг одоо чиглэлээ гаргах нь бол Улсын Их Хурлын бүрэн эрх нь. Тэгээд энэ агуулгаар хонгилыг нураах нэг арга бол парламентын хяналтыг оновчилж сайжруулах.

Хоёр дахь арга бол шүүхийн хяналт буюу шүүн таслах үйл ажиллагаан дахь шүүхийн зөвшөөрөлтэй системийг сайжруулах.

Гурав дахь нь бол ер нь бол Үндсэн хуулийн түвшинд нэг том өөрчлөлт хийх ёстой. Энэ прокурор гээд гүйцэтгэх эрх мэдлээс гадна байгаа институцийг яаж одоо Засгийн газрын юм уу гүйцэтгэх эрх мэдэлд оруулах юм. Яагаад гэвэл Үндсэн хуульд гэмт хэрэгтэй тэмцэх үүрэг бол Засгийн газрын чиг үүрэг байгаа. Гэтэл гэмт хэрэгтэй тэмцэх чинь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, мөрдөн шалгах яллах гэдэг 4 чиг үүргээс бүрдэж байдаг. Гэтэл хамгийн чухал...

Ж.Бат-Эрдэнэ: За Алтангэрэл гишүүн асуултаа асууя.

О.Алтангэрэл: Энэ хуулийн төсөлтэй холбоотойгоор нэг асуулт байгаа юм. Энэ гүйцэтгэх ажил нууц мөрдөн шалгах ажиллагаа гэдэг чинь асар их төсөвтэй эд л дээ, маш их мөнгө зарцуулагддаг. Тэгээд энэ одоо байгаа Тусгай хяналтын дэд хороон дээр төсөвтэй холбоотой асуудлыг нь хянаж байгаа гэж ойлгож байгаа. Ер нь бол энэ гүйцэтгэх ажил нууц мөрдөн шалгах ажиллагааны явцад ямар үйл ажиллагаа явж байна, хүний эрхийн зөрчил байна уу, хуульд нийцэж явж байна уу, үгүй юу гэдэг хяналтын асуудал нэг өөр. Төсөв мөнгөтэй холбоотой асуудал нь бас нэг өөр болчихоод байх шиг. Энэний зааг ялгааг яаж үзэж байгаа вэ?

Дээрээс нь Монгол Улсын тагнуулын байгууллага бол үндэсний аюулгүй байдлыг сахин хамгаалах чиг үүрэг бүхий байгууллага. Тэгэхдээ мөрдөн шалгах ажиллагаа бас явуулж байгаа юм. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар Эрүүгийн хуулийн зарим төрлийн гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа. Тэгэхээр одоо жишээлбэл энэ төсөл маань батлагдаад ирэхээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон гэмт хэрэгтэй тэмцэж байгаа, гэмт хэрэг илрүүлж байгаа энэ чиглэлийн үйл ажиллагаа нь одоо энэ Хууль зүйн байнгын хорооны харьяанд байгуулагдах хороонд харьяалагдаад бусад чиг үүрэг нь одоо байгаа байнгын хороонд харьяалагдана гэж ойлгож болох уу гэсэн ийм 2 асуулт байна.

Ж.Бат-Эрдэнэ: За Тэмүүжин гишүүн.

Х.Тэмүүжин: 2 дахь асуултаас нь эхэлж хариулъя. Алтангэрэл гишүүний асууж байгаа бид бол энэ өнгөрсөн 30 жилд нэг бодлогын зарчмын шинжтэй зоригтой алхам ерөөсөө хийгээгүй юм байна лээ. Тэр зоригтой алхам юу вэ гэхээр одоо хууль дээдэлдэг Үндсэн хуулийн байгуулал бүхий улс орнуудад нэг зарчим суучхаж. Хэрвээ тухайн улсын иргэнтэй холбоотой гэмт хэрэгтэй тэмцэж байгаа мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулж л байгаа бол тэр асуудал чинь парламентын хяналтынхаа хувьд Хууль зүйн байнгын хорооноос, парламентаас гадуур хяналтынхаа хувьд шүүхийн хяналтаас гадуур байхгүй шүү гэдэг зарчим маш тодорхой тавьдаг юм байна лээ. Гэтэл бид бол яасан бэ гэхээр ер нь Монгол Улсын иргэн рүү халдаж байгаа хуулийн байгууллагууд Засгийн газрын гүйцэтгэх эрх

мэдлийн хамгийн хүчтэй тэр арга хэрэгслийг Хууль зүйн байнгын хороон дээр огт хяналт өгөөгүй юм байна лээ. Тийм учраас Хууль зүйн байнгын хороо өөрөө ямар болоод, юу болоод хувирчихсан гэхээр нэг тийм тунхаг шинжтэй олон улсын түвшинд яригддаг хүний эрхийн тухай л ярьж байдаг тийм байгууллага болоод хувирчихсан Байнгын хорооныхоо хувьд.

Гэтэл нөгөө улс орнууд чинь бүр яг иргэн рүү халддаг одоо агентлагуудаар нь хяналтын тусгай хороонуудыг байгуулдаг юм байна лээ шүү дээ. Бүр цагдаагийн гэж нэрлэж байгаад цагдаагийн тэрний, шүүхийн шийдвэр гүйцэтгэхийн гээд нэрлэж байгаад ажилладаг юм байна лээ. Манайх болохоор тийм юм байхгүй. Тэгээд тэрнээсээ болоод одоо хүний эрхийн нөхцөл байдлаа хараад жил болгон орж ирж байгаа Хүний эрхийн үндэсний комиссын илтгэл энэ тэрд дурдагдахаар энэ эрүү шүүлт, энэ жил одоо 2024 оны Хүний эрхийн үндэсний комиссын илтгэл дотор хамгийн том байр суурь эзэлж байгаа нууц мөрдөн шалгах ажиллагаа болон гүйцэтгэх ажлын дотор хөндөгдөж байгаа хүний эрхийн асуудал чинь бүүр утгаа алдлаа шүү гэсэн дүгнэлт байна лээ шүү дээ. Тэгэхээр парламент бол энэ дээр төвлөрч ажиллахад бол энэ их чухал болно.

Үнэхээр Гадаад бодлого, аюулгүй байнгын хороон дээр бол тагнуул армитай холбоотой аюулгүй байдлын хяналт нь тэндээ үлдэх ёстой. Бид бол энэ рүү хүний эрх гэдэг нэрийн доор орж ерөөсөө болохгүй. Энэ бол үндэсний аюулгүй байдалтай холбоотой, аюулгүй байдлын чиг үүргүүд учраас. Монгол Улсын иргэн рүү гэмт хэрэгт холбогдуулаад шүүхээр ял өгөх гээд тэрэнтэйгээ холбоотой мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулж байгаа бол энэ мөрдөн шалгах үйл ажиллагаа чинь хуулийн дагуу явж байна уу, үгүй юу гэдгийг нэг талаасаа шүүх хянах ёстой. Бодлого хууль тогтоомж нь одоо Үндсэн хуулийн агуулга болон хүний эрхийн талдаа байна уу, үгүй юу гэдгийг хянах чиг үүрэг нь Хууль зүйн байнгын хороон дээр байх ёстой. Энэ хил заагийг л зөв гаргаж оновчлох тухай л яриа гарна, одоо хийгээд байгаа юм.

Төсөвтэй холбоотой дээр бол бас нэлээн асуудлууд хөндөгдөх юм байна лээ. Ер нь бол дэлхийн улс орнуудыг ингээд харахад төсвийн хяналтын тусгай, төсвийн хяналтын одоо дэд хороо байгаа шүү дээ тийм Төсвийн зардлын. Тэр хяналтын дэд хорооны хүрээн дотор тусгай нууц энэ одоо арга ажиллагаатай холбоотой төсвийг хянадаг субъект байдаг юм байна лээ дээр нь бусад улсуудад. Тэгээд Улсын Их Хурлын мандатаар ажиллаж байгаа Үндэсний аудитын нэг салбар бас яг ийм тусгай хяналтын аудит байдаг юм байна лээ.

Манайх болохоор ингээд процессын хяналт нь ч тэр, төсвийн хяналт нь ч тэр ингээд холилдоод байгаа учраас алийгаа хийхээ мэдэхгүй. Тэгээд нөгөө чиг үүргийн оновчлол нь алдагдаад, төсвөө ч хянаж чадахгүй, үйл ажиллагааг нь хуулийн биелэлтийг нь ч хянаж чадахгүй нэг ийм завхрал руу л орчихоод байгаа. Тэгээд би бол одоо ийм үгийг л дахин дахин хэлэх гэж оролдоод байгаа. Энэ бол эрх мэдлийг хааш нь ийш тийш нь зөөгөөд байгаа зүйл ерөөсөө биш. Парламентын хяналтаа яаж оновчлох вэ л гэдэг асуулт. Яаж илүү оновчтой, үр дүнтэй, нийтийн ашиг сонирхлыг хангаж чадахуйц хуулийн хэрэгжилтэд үр дүнтэй байж чадах тийм хяналттай болох вэ л гэдэг асуултыг яриад байгаа юм. Тэгэхээр төсвийн хяналттай холбоотой хэсэг дээр дахиад ярих юм бол зөндөө байгаа.

Түрүүн би Сандаг-Очир гишүүний асуултад хариулж байхдаа хэлсэн. Энэ төсвийн хяналт ч тэр, үйл ажиллагааны хяналт ч тэр, энэ тусгай хяналттай холбоотой одоо хууль тогтоомж, журам дүрмийг нь тэр Байнгын хороо буюу дэд

хороонд нь найдаж ерөөсөө орхиж болохгүй. Улсын Их Хурал өөрөө шийдэх ёстой. Улсын Их Хурал...

Ж.Бат-Эрдэнэ: Хууль санаачлагчийн илтгэл болон төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асууж, гишүүд асуулт асууж дууслаа. Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлнэ. Үг хэлэх гишүүд байна уу? Алтангэрэл, Баярмаа, Гантөмөр, Уянгахишиг, миний нэрийг оруулчхаарай. Бат-Эрдэнээр тасаллаа. Уянгахишиг гишүүн саналаа хэлье.

Г.Уянгахишиг: Сая Тэмүүжин гишүүн ерөнхийдөө бүх тайлбарыг онолын хувьд болоод практик шаардлагын хувьд тухайн үйл ажиллагаа яаж, хэрхэн хоёр талдаа хуваагдах тийм ээ, тэр талаар бүрэн тайлбарыг хэллээ. Тэгэхээр яг одоо хуульч хүний хувьд, онолын хувьд энэ хуулийн төслийг дэмжиж байна. Ер нь цааш цаашдаа Хууль зүйн байнгын хороон дээр яг энэ дэд хороон дээр болбол үнэхээр тэр одоо цагдаа дээр байна, тагнуулын ажил бол ийшээ орж ирэхгүй шүү дээ. Тэр гадагшаа чиглэсэн юм бол аюулгүй байдал дээрээ байдгаараа байна. Зөвхөн дотоодынхоо буюу дотоодын иргэд дээр явагдаж байгаа гүйцэтгэх ажиллагаа дээр хамгийн их асуудлууд үүсэж орж ирдэг. Тэгэхээр энэ асуудлыг хаалттайгаар ч гэдэг юм уу тийм ээ, ямар ч байсан Их Хурал энийг сонсдог болох ёстой, мэдээллийг авдаг болох ёстой.

Тийм учраас энэ хуулийн төслийг болбол хэлэлцэхийг дэмжиж байгаа. Ер нь энэ хуулийн төслийг дэмжиж байгаа гэдэг саналаа хэлмээр байна.

Ж.Бат-Эрдэнэ: Баярмаа гишүүн асуулт асууя.

Ж.Баярмаа: Яг Уянгахишиг гишүүнтэй санал давхцаж байна. Тэмүүжин гишүүн маш нарийн тодорхой ялгаа заагийг нь гаргаж, ач холбогдлыг нь хэлсэн учраас. Зүгээр нэмж давтаж хэлэхэд Үндсэн хуулиараа Улсын Их Хурал чинь хууль тогтоохоосоо гадна хуулийнхаа хэрэгжилтэд хяналт тавих маш том ийм чиг үүрэгтэй байгаад байдаг. Гэтэл яг үнэндээ энэ хэрэгжилтэд хяналт тавих ажиллагаа яг яаж хэрэгждэг юм, процесс нь юу юм, процедур нь юу юм гэдэг тал дээр одоо яг яаж ажиллаад байдаг юм. Би лав хараахан сайн мэдэж, мэдэрч, яг энэ чиглэлд бол ажилласангүй өнөөдрийг хүртэл. Зүй нь болбол энд ингээд хуулиа тогтоож байхад энэ талд бол ингээд хэрэгжилтэд хяналтаа тавьж байх ёстой байдаг ерөнхийд нь хэлэхэд.

Тэгэхээр яг энэ хяналт тавих энэ хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг нь жаахан дутмаг юм уу даа гэсэн бодол байнга төрж байдаг юм. Тэгэхээр яг энэнтэй холбогдоод яг энэ сая дутуу байгаад байгаа мөртөө маш чухал хүний эрхтэй холбоотой энэ асуудалд хяналт тавих боломжийг бий болгох энэ өөрчлөлтийг оруулж байна гэж харж байна. Ялангуяа одоо манай энэ Их Хурал чинь нөгөө стратеги баталсан шүү дээ. Шинэ Их Хурал. Тэр стратеги нь яг нөгөө хүний эрхийн чиглэлээр хүнийг нэгд тавина, хүний эрхийг чухалчилж бүх хууль тогтоомжуудаа энэ филтерээр цаашид авч үзнэ гэж стратеги боловсруулчихсан байгаа нөхцөлд болбол энэ бол маш чухал юмаа гэж үзэж байна.

Тэгээд ний нуугүй хэлэхэд Болормаа гишүүн бас сая ярилаа л даа. Бид нар чинь бас элдэв янзын үг хэлснээсээ болж бишгүй л элдэв хэл ам гүтгэлэг харлуулалтад өртөж байна. Тэгэхээр байнга л хүмүүс тэгээд байх юм байна лээ. За

гүйцэтгэх ажиллагаа хийж байгаа шүү, болгоомжтой байгаарай гээд. Үгүй ээ нээрээ, бүүр байнгын тэгээд би чинь бүүр гайхаж байгаа юм чинь. Энэ чинь хуулиараа хориотой юм биш үү гэхээр хуулиараа гишүүдэд хориотой боловч гэр бүлийнхэнд нь хийчихдэг юм шүү гээд. Ний нуугүй л хэлэхэд ийм асуудлууд бол бүүр өдөр тутам яригддаг юм байна лээ.

Тэгээд дахиад бас ний нуугүй юм хэлэхэд баахан гүтгэлэг яваад би чинь зүгээр ёстой очиж шалгуулдаг баатар болоод, ингээд л нөгөө өргөдлөө бэлдээд л аваачаад өгөх гэхээр зарим нэгэн хуульчид хэрэггүй гээд. Яагаад гэхээр өргөдөл өгсөн хүн болгон дээр гүйцэтгэх ажиллагаа хийх эрх нээгдчихдэг юмаа. Тийм учраас дэмий шүү гээд. Энэ чинь одоо үгүй ээ нэгэнт хийвэл хийнэ биз дээ, айх юм байхгүй гэхээрээ дэмий шүү гээд. Ерөөсөө бүхэлдээ нэг тийм хэзээ хэн нь ч угсарсан нь мэдэгдэхгүй гэр бүлийнхэн ойр тойрныхонд нь хийгээд байдаг гэнэ ээ. Тийм, тэгдэг гээд байгаа юм. Яг нөгөө өргөдлийнх нь дагуу, гомдлынх нь дагуу шалгах явцад одоо гүйцэтгэх ажиллагаа хийх шаардлага бий боллоо гээд хийдэг гэж л одоо хуульчид хэлж байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ бүх одоо явган ч гэдэг юм уу, яриатай холбоотойгоор ямар ч байсан Их Хурал өөр дээрээ энэ одоо хяналт шалгалтыг, хяналт шалгалт юу байх вэ дээ энэ ажиллагаан дээр хяналт тавьж байх нь бол маш чухал юмаа гэж үзсэний үндсэн дээр энийг бол бас дэмжиж, ингэж хамтран санаачлах дээр гарын үсэг зурсан байгаа юмаа. Энэ бол зөвхөн өнөөдөр энэ бага сага эхнээс нь амсаад байгаа гишүүд гэлтгүй ер нь цаашид үг хэлж, үзэл бодлоо хатуу илэрхийлсэн хүн бүрд учирч болзошгүй эрсдэл юм байна лээ шүү. За баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: За Алтангэрэл гишүүн үг хэлнэ.

О.Алтангэрэл: Одоо манай тэр Тусгай хяналтын дэд хороо гээд нэг олон сонгогдсон, өөрсдөө энэ мөрдөн шалгах ажиллагаа, гүйцэтгэх ажлын талаар мэдлэг байхгүй. Яг үнэндээ бол тийшээ ороод хяналтаа тавих чадвартай хүн ганц нэгхэн ийм нэг бүтэц байгаад байгаа юм. Өнөөдөр Тэмүүжин гишүүний санаачилж байгаа энэ хуулийн өөрчлөлт бол Монголын парламентын хяналтын түүхэн том алхам болно. Парламентын хяналтаар бас судалгаа хийж байсан хэд хэдэн эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлж байсан хүний хувьд би бас энэ асуудлыг нэлээн хөндөж ярьдаг хүн.

Өнөөдөр парламентын хяналт хууль сахиулах ажиллагаанд байхгүйн улмаас хүний эрхийн асар олон зөрчил гарч байгаа. Хэнийг тагнасан юм, хэнийг чагнасан юм, тэр нь хууль ёсны байсан юм уу, үгүй юу, чөлөө зөвшөөрөл нь байсан юм уу, үгүй юу гэдгийг нууц учраас хэн ч мэдэлгүй өнгөрөөж байгаа юм. Та нарын хараат бус байдалд ямар байна вэ гээд шүүгч нарын дунд судалгаа явуулж үзсэн юм. Дийлэнх нь ерөөсөө энэ гүйцэтгэх ажил мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа байгууллагын зүгээс шүүх эрх мэдэлд заналхийлж байна аа гэж үзэж байгаа юм. Тэр байтугай нэг шүүгч гэрт нь бол ингээд гүйцэтгэх ажлын техник камер тавьчихсан байсан гэсэн ийм асуудал ярьж байгаа юм. Энэ юу гэсэн үг юм. Хүн чинь гэртээ, гэр бүлтэйгээ өнгөрөөдөг орон зай. Энийг парламентад авчраад ярья гэхээр ажиллах бүтэц байхгүй, өөрсдөө яваад хянаж шалгадаг бүтэц байхгүй. Түрүүнд нь энэ чиглэлээр яах вэ Хууль зүйн байнгын хороон дээр нэг ажлын хэсэг байгуулагдаад, манай парламентын түүхийг үзэхээр анх тэр багш нарын ажил хаялтыг тагнасан гэдгээс авхуулаад нэг ганц нэгхэн удаа ажлын хэсэг яваад байгууллагууд дээр нь

очиж үзчихээд ийм байдаг юм уу гээд буцаад ирдэг л нэг ийм жишиг байсан юм байна лээ.

Өнөөдрийн ярьж байгаа асуудал бол дэлхий нийтийн жишиг ээ. Энэ гүйцэтгэх ажил нэрийн доор хэдэн тэрбум доллартай холбоотой асуудал Канадын парламент дээр дэгдэж байх жишээний. Энэ мөнгө хаашаа орчихсон юм, хэн зарцуулчихсан юм гээд, энэ гүйцэтгэх ажилтай холбоотой гэдэг юм уу, энэ нууц мөрдөн шалгах ажиллагаатай холбоотой хүний эрхийн зөрчлүүд АНУ-д ч яригдаж байдаг. Манайхаас ялгаатай нь татаж авчраад хяначхаж болдог. Чамд эрх нь байсан юм уу, ямар үндэслэл байсан, юм бичиг баримт чинь хаана байна, прокурорын зөвшөөрөл чинь хаана байна, тэмдэглэл чинь хаана байна гээд ингээд үзэж шалгачхаж болдог. Ард түмнээсээ мандат авсан Улсын Их Хуралдаа тангараг өргөсөн парламентын гишүүд Улсын Их Хурлын гишүүд энэ үйл ажиллагааг явуулах хэрэгтэй. Энэ бол парламентын хяналтын түүхэнд бол түүхэн алхам болж байгаа. Мэдээж эсэргүүцэл гарах байх. Энэ чиг үүргийг бол хуваалаа, энэ Тэмүжин нэг юм санаачиллаа, аягүй бол Тэмүүжинд өгөх гэлээ, АН-д өгөх гэлээ гэдэг чинь ерөөсөө ийм асуудал байхгүй шүү.

Энэ бол Монголын парламент гүйцэтгэх эрх мэдлээ хянаж чаддаг байх юм. Монголын парламент хүний эрхийг хангаж чаддаг, нууц мөрдөн шалгах ажиллагаанд хяналт тавьж чаддаг байхын тухайд асуудал учраас гишүүд минь ээ дээ энийг дэмжээд өгөөрэй. Өнөөдөр энд Баярмаа гишүүний ярьж байгаа, Болормаа гишүүний ярьж байгаа асуудал бодитой шүү дээ. Өнөөдөр тагнаж байгаа, чагнаж байгаа гээд дохио зангаагаар ярьдаг, 1 дүгээр хүн, 2 дугаар хүн, 3 дугаар хүн гэж ярина, тэрийгээ тоогоор үзүүлнэ, хуруугаараа үзүүлнэ, энд тэнд чанга ярихаас айна, чагнаж байгаа шүү миний утсыг ингэж байгаа шүү гэж айна, утсаа холдуулж тавина. Үгүй ээ ийм юм битүү болчихсон шүү дээ.

Тэгэхлээр одоо парламентын гишүүдийн энэ халдашгүй бүрэн эрх гэдэг бол ард түмнээс өгсөн өөрсдийн ард түмнийхээ нэрийн өмнөөс саналаа чөлөөтэй өгөх энэ эрх. Энийг хамгаалж байгаа эрх. Энэ эрхэд гүйцэтгэх ажлын шугамаар ч бай, бусад шугамаар ч бай халдах эрхгүйтэй нэгэн адил монгол хүн болгонд Үндсэн хуулиар олгогдсон халдашгүй чөлөөт байх эрх нь байгаа. Хэн нэгэн хууль сахиулагч, хэн нэгэн эрх мэдэлтэн гүйцэтгэх ажил нэрийн доор энэ эрхэд халдаж болохгүй. Халдсан тохиолдолд өмгөөлөгч нь Монголын парламент Монголын Улсын Их Хурал байх ёстой учраас та бүхнийг энэхүү төслийг дэмжихийг хүсэж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Гантөмөр гишүүн үгээ хэлье.

Л.Гантөмөр: Тэмүүжингийн оруулж ирж байгаа саналыг бол дэмжиж байгаа. Засгийн газраас бол тийм тодорхой хүлээлтгүй болчихлоо шүү дээ. Тэгэхээр одоо дараагийн довтолгоо болбол парламент руу чиглэж байна тиймээ. Зарим нэг хүмүүс одоо санал асуулга энэ тэр гээд л яриад эхэллээ шүү дээ. Миний зүгээр сэтгэл зовниж байгаа зүйл бол парламентын засаглалаа алдах ийм зүйл рүү бол парламентын гишүүд дотор үхэн хатан дурлаж байгаа хүмүүс байна. Тэгэхээр эндээс өөрийгөө хамгаалах нь бол энэ парламентын гишүүдийн одоо инспект байх ёстой. Ялангуяа Бат-Эрдэнэ дарга болбол яг энэ Тэмүүжингийн өргөн барьсан хуулийг ажил хэрэг болгоход онцгой анхаарах хэрэгтэй. Та болбол их хүнд үед бол энэ Ардын намын бүлгийн дарга болж байгаа. Одоо Ардын намаас жоохон ухаан гаргамаар байна. Мөнхбаатар сайд ч гэсэн энэ Тэмүүжингийн оруулж байгаа энэ саналыг ажил хэрэг болгох хэрэгтэй, өөрт чинь болбол маш их нэмэр болно. Ард

түмэн яг өнөөдөр хэлж байгаа зүйл нь юу вэ гэхээр зэрэг үнэхээр Монгол Улсад хүний эрхийн хямрал болчихлоо гэдгийг, шударга ёс алга болчихлоо.

Хууль болбол зөвхөн эрх мэдэлтэй нэг хүнийг тойрон эргэлдэж байна аа гэдгийг бүгд хэлээд байна шүү дээ. Нэг хүнийг шүү. Хуучин бол одоо бүлэглэл ярьдаг байлаа, олигарх гэж ярьдаг байлаа, одоо бол биш болж байна. Тийм учраас энэ үед бол бид нар энэ хулгай зэлгий янз бүрийн зүйлтэй тэмцэх дээр Их Хурал санаачилгаа өөр дээрээ авсан нь дээр ээ Бат-Эрдэнэ дарга аа, авсан нь дээр шүү. Ялангуяа энэ хар тамхины асуудал бүр замбараагаа алдсан. Яаж ч чаддаггүй, энэ мөрийтэй тоглоомын асуудал Их Хурал сая нэг хууль баталсан, байдал улам дордож байна.

Тэгээд бид бол хууль батлаад байдаг доор хэрэгждэггүй ээ, тэгээд хар тамхиндаа живээд, мөрийтэй тоглоомдоо живээд, ажилгүй хүмүүс тэр шөнө дунд цуглаж байгаа залуучуудыг та бид харлаа шүү дээ тийм. Цахим донтолтод бүрэн автаж байна гээд, бидэнд бол өнөөдрийн зовлон их байна аа эрхэм нөхөд өө, Ардын намынхан минь ээ. Тийм учраас парламент өөр дээрээ жоохон асуудлыг өнөөдрийн асуудлыг шийддэг, маргаашийн тэр айх аюулаас сэргийлж чаддаг гэдэг ийм шийдвэрүүдийг гаргаад явах нь зөв шүү, зөв шүү. Ингэж чадах юм болбол магадгүй бид нар үлдэж байгаа 3 жилд Монголынхоо асуудлыг тодорхой хэмжээгээр шийдэх боломж бол бидэнд үлдэж байгаа. Үгүй тохиолдолд улам их уналтууд биднийг хүлээж байгаа гэдгийг бид бүгд мэдэж байгаа шүү дээ. Мэдэж байгаа шүү дээ. Сая Ерөнхий сайд хэлж байна лээ шүү дээ. 7 хоногийн дотор нэг их наяд...

Ж.Бат-Эрдэнэ: Би үг хэлнэ гээд бас санал өгчихсөн байгаа. Энэ процедурын асуудлуудыг түрүүний хурал дээр бас ярьсан шүү дээ. Тэгээд Тэмүүжин гишүүн нэг асуудлаасаа тайлбарлаад байгаа юм. Би ч бас уг нь бол бас хуульч юм шүү дээ. Таны төгссөн их сургуульд бас л сурсан юм байгаа юм уг нь. Тэгээд энэ хуулиар Улсын Их Хурлын 27.3 дээр Улсын Их Хурлын байнгын хорооны бүрэлдэхүүнд дараах дэд хороог байгуулна аа гээд. Таны хэлсэнчлэн хуулиар болбол энд заачихсан. Тэгээд тусгайлан 27.4 дээр энэ хуулийн 27.3 буюу энэ 5 дэд хорооноос бусдыг бол бусдыг нь бол тухайн харьяаллын хариуцах асуудлыг харьяалах Байнгын хорооны саналыг үндэслэн гээд, сая одоо Сандаг-Очир гишүүн асуугаад байгаа шүү дээ. Танай байнгын хорооноос одоо энийг нь тасалж авъя аа. Өнөөдрийг хүртэл 30 жил одоо мэдэхгүй хэдэн жил ингээд ажиллачихлаа. Энэ чинь зөв юм уу, буруу юм уу. Ингээд бид нар тэр Байнгын хорооны саналыг нь аваад үндэслээд тэр саналыг авчхаад хүрээд ир гэсэн шүү дээ. Саналыг авчхаад хүрээд ир. Түүнээс биш одоо эсэргүүцээд байгаа юм биш. Би болбол тэгж л тайлбарлаад байгаа.

Нөгөөтээгүүр бид нар хар даа нэг зүйл дээр дандаа алдаж яваа шүү. Нэг чуулганаар орж ирээд л нэг ухаантан гарч ирээд л нэг хууль санаачлаад л паг гээд л өөрчлөөд, өөрчлөөд л явчхаж байгаа юм. Тэрний цаад утга учир цаана болохгүй байгаа зүйлүүдээ хэлэлцэж ярихгүйгээр зүгээр шууд, магадгүй зүгээр дараагийнх дээр энийг дахиад өөрчлөөд ингээд явахыг ч үгүйсгэхгүй шүү дээ. Тэгэхээр түрүүн Сандаг-Очир гишүүн үндсэндээ бол хулгай хийх гээд байна гэдэгтэй адилхан энэ Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хүрээнд хууль санаачилж байна гэдэг үндэслэлээр бид нар бүх хуулиудыг өөрчилж байгаа юм. Бүх Үндсэн хуулиас бусдыг нь байх шүү бараг. Бүх хуулийг эрхийнхээ дагуу гээд л өөрчлөөд өөрчлөөд явчхаж байгаа байхгүй юу. Тэгэхээр би бол зүгээр энэ талаас нь л хэлээд байгаа юм шүү. Процедурын юм байна аа л гэж. Түүнээс биш бусдыг нь болбол та бүхний хувьд бол бас ярьсан зүйлүүд дээр бол өөрсдийнх нь байр суурь байх аа гэж.

За ингээд санал хураалтад бэлдье гишүүд. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад бэлдье гэдгээ хэлсэн шүү дээ.

19 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, 47.4 хувиар санал дэмжигдсэнгүй ээ.

За санал хураалт. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дэмжих нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

19 гишүүнээс 3 гишүүн. Санал гараагүй тийм үү. Горимын санал алга байна. 19 гишүүнээс 3 гишүүн дэмжиж, 15.8 хувиар санал дэмжигдсэнгүй ээ.

Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дэмжих нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

19 гишүүнээс 7 гишүүн дэмжиж 36.8 хувиар санал дэмжигдсэнгүй ээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн хэн танилцуулах вэ? Танилцуулах хүн Баярмаа гишүүн танилцуулъя. Хууль санаачлагч юм байна. Болормаа гишүүн танилцуулна.

13:17

Ж.Бат-Эрдэнэ: 3 дугаар асуудалд орёе.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл нарын 26 гишүүн 2025 оны 3 дугаар сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэх тухай.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын УИХ-ын гишүүн О.Цогтгэрэл хийнэ ээ. Цогтгэрэл гишүүний микрофоныг нээе.

О.Цогтгэрэл: Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Парламентат ёсны хувьд нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн хууль тогтоох, төлөөлөх, хянан шалгах гэсэн тодорхой 3 чиг үүрэг байдаг аа. Өнгөрсөн 30 жилийн хугацаанд Улсын Их Хурал хууль тогтоох төлөөлөх бүрэн эрхээ тодорхой түвшинд хэрэгжүүлэн тогтоосон. Гэвч хянан шалгах бүрэн эрхээ үр нөлөө багатай хэрэгжүүлж ирснийг судлаачид тэмдэглэсэн байдаг. Тиймээс 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулахдаа эрх мэдлийн тэнцлийг хангах зорилгоор Улсын Их Хурлын хянан шалгах бүрэн эрхийг шинэ шатанд гаргах зарчмын өөрчлөлт хийсэн.

Улсын Их Хурлын хянан шалгах бүрэн эрхээ 7 арга хэлбэрээр хэрэгжүүлэхээр хуульд заасны нэг нь Хянан шалгах түр хороо байгуулах юмаа. Түр хороо байгуулах нь иргэдийн мэдэх эрхийг хангах хамгийн гол түлхүүр бөгөөд энэхүү хяналтыг үр дүнтэй нээлттэй хэрэгжүүлэх нь маш чухал байдаг. Иймээс Монгол Улсын Үндсэн хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсэг хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь хүн хянан шалгах түр хороо байгуулах санал тавивал Улсын Их Хурал дахь цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна аа гэж.

Монгол Улсын Их Хурлын хянан шалгах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 2-т түр хорооны бүрэлдэхүүнийг тогтоохдоо Улсын Их Хурал дахь олонх цөөнхийн төлөөллийг хувь тэнцүүлэн Түр хорооны бүрэлдэхүүний гуравны нэгээс доошгүй нь цөөнхийн төлөөлөл байх. Улсын Их Хурал дахь нам, эвсэл бүрийн төлөөллийг оролцуулах зарчмыг баримтална аа гэж тус хороог Түр хороог байгуулах тухай тэр тусмаа цөөнхийн төлөөллийг түлхүү хамруулах тухай заажээ.

Олон улсын парламентын үйл ажиллагаанд мөрдөн шалгах нээлттэй сонсгол хийх нь жишиг болсон арга хэлбэр ээ. Энэ тухайн асуудалд холбогдох албан тушаалтан, гэрч, шинжээчийг Улсын Их Хурлаас дуудаж тайлбар мэдүүлэг авах, тусгай шинжээч, хянан шалгагч томилох замаар нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тухайн асуудлыг тал бүрээс нь шинжлэн судалж, бодит мэдээллийг ард түмэнд ил тод болгоход чухал ач холбогдолтой. Гэвч өнөөгийн хэрэгжиж буй хуулиар Улсын Их Хурлын олонхыг бүрдүүлж буй улс төрийн хүчин Хянан шалгах түр хорооны олонхыг бүрдүүлэхийн зэрэгцээ Түр хорооны даргыг олонхоос сонгож байгаа явдал нь Түр хорооны үр нөлөөг үлэмж хэмжээгээр бууруулж байна аа.

Иймд Түр хорооны даргыг сөрөг хүчин цөөнхийн төлөөллөөс ажиллуулж чадвал хяналтын энэ чухал хэрэгслийг үр дүнтэй болгоно гэж Улсын Их Хурлын 26 гишүүн үзэж Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл санаачилсан. Өнөөгийн хэрэгжиж буй хуулийн 33 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт Түр хорооны даргыг сонгох зохицуулалтыг Түр хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар түр хорооны бүрэлдэхүүнд орсон цөөнхийн бүлгийн төлөөллөөс, хэрэв цөөнхийн бүлэг байхгүй бол цөөнхийн төлөөллөөс сонгоно оо гэж уг хуулийн өөрчлөхөөр уг хэмээн өөрчлөхөөр уг хуулийн төсөлд тусгалаа. Энэхүү өөрчлөлтийг батлуулснаар Түр хорооны даргыг цөөнхийн төлөөллөөс ажиллуулдаг болж чадвал хяналтын нэн чухал хэрэгслийг үр дүнтэй ашиглах, эрх баригчдыг ард иргэдтэйгээ хамтран цөөнх буюу цөөнх хянах нөхцөл бүрдэж, парламентат ёс нутагшихад томоохон дэвшил болох нь гарцаагүй юмаа.

Мөн Түр хороо байгуулах Түр хорооны бүрэлдэхүүнийг Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар олонхын саналаар шийдэх учраас парламентын олонхын оролцоо чухал хэвээр үлдэж байгааг бас дурдах нь зүйтэй. Хуулийн төсөл батлагдсанаар нэмэлт зардал гарахгүй, хяналт бүрэн хэрэгжиж, Түр хорооны үйл ажиллагаа үр дүнтэй явагдахад чухал нөлөөтэй зэрэг олон ач холбогдолтой хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг эрхэм гишүүдээс хүсье ээ.

Ж.Бат-Эрдэнэ: Хууль санаачлагчийн илтгэл, хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? нэрсээ өгнө үү? алга

байна. За Сандаг-Очир гишүүнээр тасаллаа. Номинчимэг гишүүн, Сандаг-Очир гишүүн. За Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Хуулийн төслийн үзэл баримтлалыг үзсэн. Энэ одоо хяналт шалгалт тавих Хяналт шалгалтын тухай хуулиараа Түр хорооны дарга нь олонх цөөнх байхаасаа хамаараад байгаа юм уу гэж асуухаар байна. Олонхын бүлгээс цөөнхийн бүлгээс сонгогдсоноосоо хамаарч тухайн асуудал Түр хорооны асуудлын ач холбогдол үр дүн нь харагдаад байгаа юм уу гэж ойлгогдохоор байна. Олонхын бүлгээс Түр хорооны даргыг сонгочихвол асуудал шийдэгдэхгүй байна, үр дүнд хүрэхгүй байна. Заавал хяналт шалгалтын Түр хорооны даргыг цөөнхийн бүлгээс сонгож байж асуудал одоо хяналт шалгалт хийсэн болж ингэж харагдах гээд байна аа л гэж ингэж ойлгогдож байгаа учраас та бүхэн энэ хуулийг ингэж санаачилсан юм уу?

Тэрнээс одоо Түр хорооны даргыг дотроосоо яриад тэгээд олонхын саналаараа л сонгоод явчих нь асуудал нь болох юм биш үү. Заавал цөөнхөөс одоо хорооны даргыг сонгодог байх нь ямар үр дүнтэй юм бэ? Нөгөө түрүүнд муур хар цагаан байх нь хамаагүй. Гол нь одоо хулгана барьдаг л байх ёстой гээд байгаа. Бид нар Түр хороо тухайн асуудлаар хяналт шалгалтын Түр хороо байгууллаа. Тухайн асуудал нь үнэхээр нийгэмд асуудал болоод, үнэхээр хэлэлцэх шаардлагатай болоод ингээд хэлэлцэж байгаа юм. Тэрний дарга нь хэн байхаас үл хамаарч тэр одоо асуудлыг хэлэлцэх тухайн асуудлаас шийдвэр гаргах нь хамаардаг юм уу? Яагаад энэ хуулийг ингэж санаачлах болсон юм бэ гэдгийг л нэг.

Өнгөрсөн хугацаанд, 4 жилийн хугацаанд та бид мөр зэрэгцэн суухдаа олон асуудлуудаар Түр хороо Хяналт шалгалтын Түр хороо ажиллаж сонсголууд хийсэн. Тэгээд бүгд л үр дүнтэй болоод л явсан гэж ойлгож байгаа. Тэгээд одоо заавал Түр хорооны даргыг цөөнхөөс байгуулбал одоо үр дүнтэй болно гэж хэн хэлж байгаа юм. Өнгөрсөн хугацааны сонсголууд үр дүнгүй болсон гэж хэн хэлээд байгаа юм. Тийм учраас хууль санаачлагчаас заавал цөөнхийн төлөөллөөс бүлгийн Түр хорооны даргыг сонгодог болгох гээд байгаа учир шалтгаан нь, практик хэрэгцээ шаардлага нь юу байгаа юм бэ гэдгээ нэг тайлбарлаж өгөөч ээ гэж асууя.

Ж.Бат-Эрдэнэ: Хууль санаачлагч Цогтгэрэл.

О.Цогтгэрэл: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. 2 зүйл байгаа юм. Нэгдүгээрт нь Улсын Их Хурлын хяналтын чиг үүрэгтэй холбоотой 2019 оны Үндсэн хуультай холбоотой энэ Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн анхдагч хууль 2021 онд өргөн баригдаж батлагдсан байна лээ. Ер нь энэ тухайн үед яригдаж байсан нөхцөл байдлуудыг харахад Улсын Их Хурлын хяналтын чиг үүрэг гэдэг чинь ерөөсөө Гүйцэтгэх засаглалыг эрх баригчдыг хянах гэж байгаа гэдэг нь олонхыг хянах гэж байгаа гэсэн үг. Тэгэхээр өөрөө өөрийгөө хянаа аа, өөрөө өөрийгөө шалгана аа гэдэг агуулга энэний цаанаас энэ засаглалын асуудал гарч ирж байгаа юм нэгдүгээрт.

Хоёрдугаарт энэ өөрөө дахиад бид нарын хувьд нэг их тийм шинэ санаачилга шинээр дугуй зохиох зурах гээд байгаа асуудал ерөөсөө биш. 2021 оны Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль анх өргөн баригдахдаа яг энэ үзэл баримтлалаар Хяналт шалгалтын түр хороо байгуулахдаа цөөнхөөс ахлах ёстой гэж 2021 оны тэр үед Занданшатар дарга оролцсон Хяналт шалгалтын тухай хууль

дээр анхны үзэл баримтлал дээр ингэж өргөн баригдсан байдаг. Батлагдах явцдаа горимын саналаар энэ заалтыг хасаж батлагдсан. Тухайн үедээ яагаад бас ингэж баталсан гэхээр ерөөсөө олон улсын парламентын жишиг нь өөрөө ийм байдаг юм. Бид нарын сонгодог гэж хэлдэг парламентын жишиг нь ерөөсөө Улсын Их Хурлын хяналт шалгалтын Түр хороо байгуулахдаа энийг цөөнх бус ахална аа гэж. Энэ чинь түр хороо чинь өөрөө олон гишүүдтэй, Их Хурлын нэгдсэн чуулганаар батлагддаг. Энэ дээр олонх цөөнхийн харьцаа олон талаасаа олонхын хяналт нь бас явчихна.

Тэгэхдээ энэний ахлагч даргалагч нь цөөнх бус байна аа гэж. Тухайн үеийн үзэл баримтлал дээр. Дахиад тухайн үеийн баримтуудыг авч үзсэн л дээ. Одоо энэ цаас байж байна. Улсын Их Хурлын Хянан шалгах түр хороо ба үндсэн хуулийн үзэл баримтлал олон улсын сайн туршлага гээд ингээд судалгааны олон улс Монголын парламентын судалгааны хүрээлэнгээс гаргаж байсан баримт бичиг байгаа юм. Жишээ нь одоо энэ баримт бичиг дээр гэхэд яг саяын үзэл баримтлалыг энэ болбол олон улсын жишиг юм байна аа гэж саналаа өгөөд тухайн үед анхдагч хууль өргөн барихдаа яг энэ үзэл баримтлалаар саналаа өгч байсан. Энэ өөрөө нөхцөл байдлын хувьд, хэрэгцээ шаардлагын хувьд дахиад олон улсын сонгодог парламентын гэдэг жишгийн хувьд байдаг л зохицуулалт юм билээ.

Ж.Бат-Эрдэнэ: Сандаг-Очир гишүүн тодруулъя.

Ц.Сандаг-Очир: Тэгэхээр ингэж болдоггүй юм уу? Түрүүн бас Тэмүүжин гишүүн бид нар хальт санал солилцоод авсан. Тухайн асуудлаар хяналт шалгалтын Түр хороо байгуулах гэж байгаа бол тэр санаачилсан этгээд нь субъект нь өөрөө Түр хороогоо ахлаад явчихдаг байх бололцоо боломж байхгүй юм уу? Энийг та бүхэн ярилцаж үзсэн үү? ажлын хэсэг дээрээ, хууль санаачлагчид дээр нэгд. Таны өргөн барьсан хуулиар одоо жишээ нь би олонхын бүлгээс сонгогдсон гишүүний хувьд тодорхой нэг асуудлаар хяналт шалгалтын Түр хороо байгуулаад одоо сонсгол хиймээр байна шүү дээ. Гэтэл одоо миний санаачилсан асуудлаар таны хууль батлагдчихвал тэгээд л цөөнхөөс нэг хүн ахлаад л, тэр Түр хороог байгуулаад л явах нь л дээ. Ямар ч хамаагүй хамааралгүй санаачилга гаргаагүй ийм хүн. Тэгэхээр миний нөгөө санаачилсан тэр асуудал маань цаашдаа бас үр дүнд хүрэх үү. Миний хүссэн хэмжээнд тэр тодруулах гээд байгаа, хянаж шалгах гээд байгаа тэр асуудал үр дүнд хүрэх үү. Тэгснээ би нөгөө олонхын бүлгээс сонгогчихсон гишүүнийхээ хувьд тухайн санаачилсан асуудлаараа Түр хороо байгуулж, Түр хороогоо даргалаад явах асуудал бол одоо хумигдах нь.

Ж.Бат-Эрдэнэ: Хууль санаачлагч Цогтгэрэл гишүүн хариулъя.

О.Цогтгэрэл: Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд зааснаар хяналт шалгалтын Түр хороо байгуулах нь Улсын Их Хурлын нийт гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй дэмжиж байж буюу одоогийн зохицуулалтаар бол 32 гишүүн гарын үсэг зурснаар байгуулагдана. Тэгэхээр энийг олонх цөөн гэхгүйгээр одоо жишээ нь энэ 32 гарын үсэг хаанаасаа санаачилгатай эхэлснээсээ асуудал явж болно. Тэгэхээр яг саяын зүйл, заалтыг жишээ нь магадгүй бид нар энэ саяын тэр таны хэлж байгаа магадгүй олонхын гишүүд энэ дээр санаачлаад яагаад хяналт шалгалтын асуудлыг явуулж болохгүй гэж. Энэ дээр болбол хэлэлцэх эсэх шийдэгдсэний дараа бид нар ажлын хэсэг дээрээ ярилцаад явах бүрэн боломжтой юм.

Ер нь бол 32 гишүүн санаачлаад хяналт шалгалтын Түр хороо байгуулах үндсэн эрх нь бол байгаа. Тэр гишүүдийн эрх нь бас одоо чинь бид нар жишээ нь хуулиар халдаж болохгүй шүү дээ. Тэгэхээр энэ болбол хэлэлцүүлгийн явцад одоо харгалзаж үзээд явах боломжтой зүйлээ гэж үзэж байна. Өөр бас энэ Улсын Их Хурлын хяналтын тухай хуулиар чинь жилд 2-оос илүүгүй удаа хяналтын сонсгол явуулна аа гээд 2-оос илүүгүй гээд бас тоог сүүлд заачихсан байх нь. Нэг тийм зүйл байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Номинчимэг гишүүн асуулт асууна.

О.Номинчимэг: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Энэ Хяналт шалгалтын хууль батлагдах үед би бас Улсын Их Хуралд ажиллаж байсан юмаа. Тэгээд Цогтгэрэл гишүүн бас энэ хуулийн үзэл санааг тайлбарлахдаа буруу тайлбарлаад байх юм. Хянан шалгалтын түр хороо байгуулж байгаа гол учир шалтгаан энэ хууль дээр яагаад орж ирсэн гэхээр Үндсэн хуулийн 28.2-т буюу ерөөсөө л хуулийн хэрэгжилт биелэлт болон нийтийн ашиг сонирхлыг хамарсан тодорхой нэг асуудлаар л хянан шалгах жоохон шүдтэй арслантай больё л гэдэг ийм асуудал шүү дээ. Тэрнээс олонхыг хянах гэж цөөнхийн бүрдүүлдэг бүтэц биш байхгүй юу. Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль чинь өөрөө тодорхой чиг үүрэгтэй. Та хуулийнхаа угаасаа зорилгыг нэг унших. Энэ ерөөсөө олонхыг хянах гээд цөөнх нь одоо цөөнхөд гаргаж өгдөг ийм механизм бол биш. Энэ Улсын Их Хурал өөрөө өөрийнхөө чиг үүргийг хэрэгжүүлэхдээ хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхэд л зориулсан Засгийн газраа хуулийн хэрэгжилтээ тодорхой асуудал чинь яаж байна гэдэг л юм. Энэ олонх цөөнхийн асуудал биш.

Хоёрдугаарт, та яриандаа бас энэ танилцуулгадаа дурдчихсан байна л даа. Энэ олон улсын жишиг байна аа. Хянан шалгах Түр хорооны олонхыг бүрдүүлэхийн зэрэгцээ Түр хорооны даргыг олонхоос сонгож байгаа байдаг нь олон улсын жишиг. Та яг ямар улсын, ямар аль хууль дээр энэ Түр хороог майнорити буюу цөөнхөөс нь томилдог гэдэг заалт байгаа юм. Бүгдийг нь гаргаад ир тэгэх үү? Миний судалж байгаагаар бол хууль зүйн тийм ерөөсөө хязгаарлалт байхгүй. Ямар асуудал вэ гэдгээсээ болоод практик дээрээ тэрийгээ шийддэг. Тэрнээс хуулиараа бүх хянан шалгах хороог цөөнхөд өгчихнө гэх юм бол, одоо жишээ нь Хөгжлийн банкны асуудал байна. Хөгжлийн банкны 2012-2016 онд Ардчилсан намынхан орж ирээд зэрэгцээ төсөв байгуулаад яаж идэж уусан асуудлыг МАН олонх болохоороо энийг хийж чадахгүй гэсэн үг юм уу? Заавал өөрсдөө бид нар Хөгжлийн банкныг шалгахдаа 2012-2016 оны асуудлыг шалгахдаа өөрсдөө хийнэ гэсэн үг болох юм уу? Тэгээд ийм явцуу утгаар энэ хуулийг бол тайлбарлаж болохгүй юм байгаа юм.

Энэ өөрөө Хянан шалгах Түр хороог нийтийн ашиг сонирхлыг хөндөж байгаа хуулийн хэрэгжилт биелэлттэй холбоотой асуудал байгаа учраас энэ бол ерөөсөө зарчим нь заавал цөөнх байх ёстой гэсэн юм аль ч улсын хуульд байхгүй байх гэж би бодож байна. Мэдээж сэдэв сэдвээрээ ямар асуудал шалгах гэж байна гэдгээсээ хамаараад цөөнхөөс байх уу, олонх байх уу, тэр үедээ тэрийг бол шийддэг практик бол байж болох байх. Тэгэхээр та нэг судалгааны тоо баримт олон улсын жишиг дурдлаа. Яг ямар улсын, ямар хууль дээр байгаа тэрийг бас нэг хариулж өгөөч ээ.

Ж.Бат-Эрдэнэ: Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Номинчимэг гишүүн хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хууль байгаа гэж байна л даа. Хууль

үгчилж бичихээсээ гадна хуулийн цаана үзэл баримтлал гэж байдаг. Хуулийн үзэл баримтлалын хувьд ер нь хууль тогтоох байгууллагаас гарч байгаа хуулийг гүйцэтгэх засаглал болоод хууль сахиулах байгууллагуудад хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа гэдэг чинь үзэл баримтлал үзэл санааны хувьд энэ өөрөө гүйцэтгэх засаглалыгаа илүү хянах гэдэг тал руу агуулга байна аа гээд яг одоо энэ би түрүүн хэллээ. Энэ тухайн үед Мөнхсайхан доктор ахлаад Улсын Их Хурлын Тамгын газар Парламентын судалгааны хүрээлэнгээс энэ зузаан баримт бичиг гаргаад, Үндсэн хуулийн үзэл баримтлал ба Хянан шалгах Түр хороо гэдэг энэ баримт бичиг гаргасан дээр нь саяын жишээнүүдийг бүгдийг нь дурдсан. Жишээ нь одоо зарим ингээд тусгайлсан зүйлүүд дээр Германы Бундестаг, Францын одоо бүр Үндсэн хуулийн заалтад яг энэ үзэл санааг одоо ингээд биччихсэн байгаа гээд энэ бүүр үгчилбэл нэлээн урт өгүүлбэрүүд байна л даа. Жишээ нь одоо ингээд яг энэ бол манай Парламентын судалгааны хүрээлэнгийн баримт бичигт бүүр огноог нь хэлбэл 2021 оны 3 сарын 25-нд гаргаж өгсөн үзэл баримтлалын түвшний судалгааны бичгүүдэд жишээ нь энэ асар зузаан баримт бичгүүдийг гаргаж өгсөн.

Тэгэхээр эндээс юу гэж хэлэх гэж байна вэ гэхээр мэдээж хуулийн хэрэгжилтийг л хянах гэж байгаа юм. Хуулийн хэрэгжилтийг хянахад хэрэгжүүлэхэд олонх цөөнх гэж байхгүй гэж хууль дээр мэдээж зөвхөн цөөнх хянаана гэсэн өгүүлбэр байхгүй нь тодорхой. Тэгэхдээ үзэл баримтлалын түвшинд энэ асуудлыг ер нь олон улсын парламентын жишгээрээ ингэж үздэг юм байна шүү. Энэ дээр энэ та сонирхвол энэ тухайн үеийн баримт бичгийг бид танд өгч болж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Хууль санаачлагчаас тодруулах уу? Номинчимэг гишүүн.

О.Номинчимэг: Харин үзэл баримтлал нь парламент өөрсдийнхөө хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхдээ яах вэ л гэдэг асуудал шүү дээ. Олонх цөөнх гэхээсээ илүү засаглал хоорондын тэнцвэртэй байдлыг хангах. Тэгээд энэ засаглал чинь дөрвөн жил дөрвөн жилдээ солигдох боломжтой, яах ч боломжтой, тэгээд нийтийн ашиг сонирхлыг хөндсөн эсвэл хуулийн хэрэгжилт дөрөв дөрвөн жилээр угаасаа хэмжигдэнэ, зөвхөн тэр үедээ Түр хороо байгуулна гэсэн асуудал байхгүй байх. Тэрийг та ч гэсэн мэдэж байгаа шүү дээ. Тэгэхээр угаасаа хуулиараа энэ асуудлыг зөвхөн цөөнхөд даргалах ёстой гээд өгчих чинь өөрөө гажуудал үүсгэнэ ээ. Тэгээд та нэг олон улсын судалгаа ярьж байна. Би яг тантай зэрэгцээд ChatGPT-ээс асуулаа. Францын Францад яг ийм хянан шалгах түр хороог заавал цөөнхийнхөн даргалах ёстой хууль байна уу гээд асуусан чинь тийм юм байхгүй ээ л гэж байна. Тэгэхээр олон улсын судалгаа жишээ ингээд дурдахдаа нарийвчилж нөгөө чөтгөр деталь гэдэг шиг зүгээр ийм байна аа гээд ерөнхий дурдах биш нарийвчилсан юмыг нь харж байж хийхгүй бол ингээд ерөнхийдөө олон улсын жишиг гэнгүүтээ ийм юм руу битгий бас яваач ээ. Яах вэ сэдэв сэдвээсээ хамаараад...

Ж.Бат-Эрдэнэ: Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Энэ Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 2 дугаар бүлэг дээр байна л даа. Хяналт шалгалт гэхээр зөвхөн одоо саяын бид нарын ярьж байгаа хяналтын түр хороо биш 7 арга хэрэгслээр Улсын Их Хурал эрхээ хэрэгжүүлнэ ээ гэсэн байна, 7 арга хэрэгслийн саяынх зөвхөн нэг нь. За жишээ нь гишүүд асуулт тавих, асуулга тавих, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх, тайлан илтгэл хэлэлцүүлэх, төсвийн хяналт хийх, хяналтын сонсгол хийх, саяын сонсголоос тусдаа хяналтын түр хороо байгуулах гээд гэх мэтийн энэ одоо яг хуульд зааснаар 7 арга хэрэгслээр одоогийн байдлаар Хяналт

шалгалтын тухай хуульд боломж байгаа гэж байгаа. Бид нар зөвхөн 7 арга хэрэгсэл, 7 арга хэрэгслийн зөвхөн нэгийнх нь тухай ярьж байгаа шүү. Энэ нэгээр зөвхөн цөөнхийг хамааруулж ойлгох биш. Энэ жишээ нь, одоо энэ нийт 7 арга хэрэгсэлд бүх гишүүдийн оролцоо, олонх цөөнх, эрх баригч сөрөг хүчний бүгдийнх нь оролцоо энд байж л байгаа. Энэ 7 арга хэрэгсэлд.

Ж.Бат-Эрдэнэ: Номинчимэг гишүүн

О.Номинчимэг: 7 арга хэмжээ байгаа. Гэхдээ та бүхний хууль бол яг энэ Хянан шалгах түр хороотой холбоотой орж ирсэн. Тэгээд Хянан шалгах түр хорооныхоо асуудал чинь зарчим нь юу юм бэ л гэдэг асуудал дээр төвлөрөе. Тэгээд Хянан шалгах түр хороог чинь заавал цөөнхийн төлөөллийг оролцуулж байгуулах ёстой гээд хуулийг нь угаасаа Хяналт шалгалтын хууль дээр байгаа шүү дээ Цогтгэрэл дарга аа. Цөөнхийн оролцоо энэ дээр бүүр заавал байх ёстой шүү гэдгийг чинь энэ хуулиараа хийгээд өгчихсөн юм. Зөвхөн толгойлогч тэр ахлах хүн чинь ингэж хуулиараа зөвхөн цөөнхөд байна гэдэг чинь өөрөө нийтийн ашиг сонирхлыг төлөөлж одоо ажиллаж байгаа бусад гишүүдийнхээ эрхийг бараг хөндөх гэж байна. Дээр нь дахиад гажуудал үүсгэх гэж байна. Тэгэхээр зарчмын хувьд сэдвийнхээ хүрээнд, сэдвээсээ хамаараад цөөнх даргалж болно. Тэрийг бол тэрийг одоо юу байдаг юм ёстой жишгээ харж байгаад хийж болох. Хууль дээр ийм хатуу заалт байж болохгүй ээ л гэдэг юмыг хэлээд байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Тэгээд би тэр хуулийн танилцуулга дээр дурдсан. Хурал даргалагч цөөнхөөс байлаа гээд энэ 100 хувь цөөнхийн хяналтад асуудал ярих гэж байгаа зүйл биш ээ. Түр хороо байгуулах шийдвэрийг Байнгын хорооноос биш Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаас гаргадаг. Олонхын саналаар гэж байгаа юм. Тэгэхээр тэндээс тэр Түр хорооны бүрэлдэхүүн хэдэн гишүүнтэй байх юм, ямар асуудлаар байх вэ гэдгийг нэгдсэн чуулганаар гаргаж байгаа болохоор тэр Түр хорооны бүрэлдэхүүн, жишээ нь тэрэн дотор олонх цөөнх, Түр хороо байгуулагдахдаа олонх гишүүд нь олонхоос байж болно. Түр хороо чинь өөрөө олонх цөөнхөөрөө шийдвэрээ гаргачихна. Тэгэхээр олонхын бас оролцоо хяналт тэнд байдгаараа байж л байна. Олонхын оролцоо. Яагаад гэвэл нэгдсэн чуулганаас хэдэн гишүүнтэй байх, хэн хэн байхыг нэгдсэн чуулганаас баталж өгнө энийг. Тэгэхлээр энэ олонхын оролцоогүй хяналтын тухай яриа ерөөсөө биш. Олонхын оролцоо хяналтан дор асуудал явагдана аа. Зөвхөн даргалагчийн тухай яриа л гэж.

Ж.Бат-Эрдэнэ: Хууль санаачлагчийн илтгэл, төслийн үзэл баримтлалтай холбогдуулан гишүүд асуулт асууж дууслаа. Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Болормаа гишүүн байна, Баярмаа гишүүн. Нэр тасаллаа. За Болормаа гишүүн.

Э.Болормаа: Энэ Түр хороотой холбоотой энэ хуулийн танилцуулга дээр одоо логикийн аягүй доголдолтой зүйлсүүд байна аа. Улсын Их Хурлын олонхыг бүрдүүлж буй улс төрийн хүчин Хянан шалгах түр хорооны олонхыг бүрдүүлэхийн зэрэгцээ Түр хорооны даргыг олонхоос сонгож байгаа явдал нь Түр хороо байгуулсан ач холбогдлыг бууруулж байна аа гэдэг ийм аягүй аюултай дүгнэлтийг би оруулж болохгүй гэж бодож байна. Ер нь энэ хууль өөрөө ганц зүйлийг л өөрчлөх гэж байна шүү дээ.

Түр хорооны даргыг заавал цөөнхийн бүлгийн төлөөллөөс л болох ёстой гэдэг ийм хэтэрхий явцуу улс төржсөн ойлголт оруулж ирж байна. Одоо бүгдээрээ энэ 126 гишүүнтэй энэ шинэ парламентад одоо жоохон байпартисн гэж ярьдаг юм шүү дээ. Жоохон эрүүл ухаантай, юмыг ингэж хэтэрхий улс төржиж харж, олонх цөөнх гэлтгүйгээр эрүүл ухаанаар хармаар байна аа. Өмнөх Улсын Их Хурал дээр одоо сая Номинчимэг гишүүн хэллээ. Энэ хуулийг одоо боловсруулж байхаас нь авхуулаад одоо ажиллаж байсан, яг л одоо олонх байхдаа л олон асуудал дээр шүгэл үлээж, түр хороонууд байгуулсан шүү дээ. Одоо эмийн сонсгол, Хөгжлийн банк, нүүрс гэх мэтчилэн. Энэний үр дүнтэй байсан эсэх талаарх асуудлууд хэрхэн илүү үр дүнтэй болох вэ гэдэг зүйлсийг ярьж болно.

Тэр бол тэгэхдээ Түр хорооны дарга олонхоос байсантай огт хамаагүй зүйл гэж би бодож байна. Эргээд заавал цөөнхийн бүлгээс дарга байна гэдэг бол тэр Түр хороонд байгаа гишүүдийн эрхийг зөрчиж байна. Тэр Түр хороонд байгаа гишүүд Улсын Их Хурлаар батлагдаад, тэд нар өөрсдөө дотроосоо даргаа сонгох бүрэн эрхтэй. Тэгэхээр тэд нарын эрхийг зөрчиж байгаа явдал гэж үзэж байгаа учир би энийг дэмжихгүй байгаа. Харин магадгүй санаачлагч нь дарга нь байна аа гэвэл сая Сандаг-Очир гишүүний хэлсэнчлэн дэмжиж болж байна. Өнөөдөр жишээлбэл Батнайрамдал гишүүн Оюутолгойн асуудал дээр Түр хороо байгуулахыг Онтретой холбоотой ингээд санаачлаад явж байна. Тэр хүн энэ дээрээ мэдлэгтэй, чадвартай улс төрийн зориг гаргаад ингээд явж байхад заавал цөөнхийн бүлгээс ингээд ахална аа гэдэг бол тэр хүний эрхийг зөрчиж байна, эргээд хэлэлцэж байгаа асуудал нь хамгийн сайн одоо чадвартай хамгийн энэний төлөө бас зүтгэж байгаа хүний нөгөө гишүүний эрхэд нь би халдаж байна гэж үзэж байгаа учир дэмжихгүй байгаа.

Гэхдээ зарим нь бас энийг одоо зарчмын зөрүүтэй саналаар энийг хэлэлцүүлэгт өөрчилж болно гээд байгаа юм. Гэхдээ энэ оруулж байгаа өөрчлөлт өөрөө ганцхан зүйлтэй байхгүй юу. Тэрийг нь өөрчлөх гэж байгаа бол энийг хэлэлцээд яах юм бэ буцаагаад та бүхэн энийгээ санаачлагчийг нь өөрчлөөд ороод ирвэл болж байна. Ганцхан зүйлтэй асуудлыг орчхоод өө энийг нь агуулгыг нь ороод хэдүүлээ өөрчилж болно гэх юм бол энийг хэлэлцэхийг дэмий байх аа гэж бодож байна. Бид нар бас одоо Улсын Их Хурлын гишүүн гэдгийг зөвхөн аль нэг нам гэж харахгүйгээр ард түмний төлөөлөл гэж харах ёстой шүү. Тэгэхээр гишүүдийнхээ эрхийг нь зөрчихгүй байх, тэр Түр хороог санаачилж байгаа гишүүн, тэр Түр хорооны бүрэлдэхүүнд орж байгаа энийг даргаараа сонгох гэж байгаа эдгээр гишүүдийн эрхийг нь зөрчиж болохгүй ээ гэсэн үндэслэлтэйгээр энэ нэмэлт, өөрчлөлтийг дэмжихгүй байна аа.

Ж.Бат-Эрдэнэ: Баярмаа гишүүн үг хэлнэ.

Ж.Баярмаа: Энэ ер нь бол олонхоос биш цөөнхөөс ч юм уу, магадгүй Сандаг-Очир гишүүний хэлсэнчлэн санаачилсан этгээд нь өөрснөө даргалах нь зүйтэй юм билээ. Яагаад гэвэл яг бид нар ноднин яг Улсын Их Хурал анх бүрэлдсэний дараахан Түр хороо ч арай биш л дээ. Гэхдээ яах вэ агуулга нь нөгөө нийтийн сонсгол зохион байгуулах эрүү шүүлттэй холбоотой санаачилгыг 22 гишүүн гаргаад гарын үсэг зураад явуулсан. Тэгээд очоод яг нөгөө хуулийнхаа дагуу даргалах хүн нь болохоор олонход ноогдоод, тэгээд Сайнзориг гишүүн даргалах болсон л доо. Би яг нөгөө практик талаас нь хэлэх гээд байна. Тэгэнгүүт хугацаагийг нь хойшлуулсан. Эхлээд нэг тов товлосон байснаа тэгээд 1 хуульд өөрчлөлт оруулахаас нааш билүү журмыг нь батлахаас тиймээ Номинчимэг гишүүн ээ, журам

байх ёстой юм байна аа, тэгээд журмыг нь батлахаас нааш ерөөсөө энэ сонсголыг чинь зохион байгуулж болохгүй юм байна гээд хойшлуулсан л даа.

Тэгээд сүүлдээ нэг тийм субъектив хандлага байсан мэт болж хувирсан. Яагаад гэхээр нөгөө журмаа ч батлаагүй. Тэгээд нөгөө үндсэндээ хойшлуулсан шалтгаан нь ерөөсөө огт үр дүнгүй болоод, тэгээд журамгүйгээр хийж таарсан. Тэгээд би энэ дээрээс юу гэж дүгнэсэн бэ гэвэл ер нь энэ сонсгол ч бай, түр хороо ч бай хийх тухайн даргалагчаас бас их зүйл хамаардаг юм байна аа. Бас субъектив хандлагаар хандвал ханддаг юм байна аа гэдэг нь бол тодорсон. Тэгээд чухамхүү журамгүй бол огт хийж болохгүй гэсэн чинь сүүлдээ за за болох юм байна аа, зөндөө хэлсэн байхгүй юу. Энэ хууль нь ийм ийм юм байна аа, бусад ерөнхий заалтаараа хийж болох юм байна аа гэсэн боловч тийм юм байхгүй яагаад ч болохгүй гэсээр байгаад л хойшлуулсан. Тэр ямар ч улс төрийн зорилго байсан юм. Орон нутгийн сонгуулийн өмнө хийж таарах гээд байсан болоод тийм одоо галтай эрүү шүүлттэй холбоотой асуудлыг хийхгүй гэж хойшлуулсан уу, үгүй юү гэж улс төрийн утгаар хардахуйц ийм явдал болоод өнгөрсөн. Тэгээд дараа нь нөгөө журам ч үгүй, тэгээд ерөөсөө ямар ч утгагүйгээр хойшлуулаад хийсэн. Тэгэхээр энд бол субъектив хандлага орох магадлал өндөр юм байна лээ.

Тийм учраас сөрөг хүчнээсээ мэдээж хэн засаглаж байна тэдгээртэй холбоотой л асуудал үүсэж таарна. Тэр засаглаж байсан хүмүүс, этгээдүүд, субъектүүдтэй холбоотой асуудал дээр л хяналт шалгалт явуулж таарна. Тэгэхээр ерөнхий үзэл баримтлал философийн утгаараа бол хяналт хэн тавих ёстой вэ гэхээр сөрөг хүчин л тавина. Зөвхөн энэ 4 жилээр харж болохгүй л дээ, дараагийн 4 жилд Ардчилсан нам ялж байх үед Монгол Ардын намаас бас ингээд хөөрхөн санаачлаад бас тийм тэгээд тухайн үед бас эрх барьж байгаа Ардчилсан намынхныг бас шалгах ажиллагааг сөрөг хүчин хийж болно шүү дээ. Тэгэхээр тэр цаад утгаар нь харах нь л зүйтэй байх. Яг философи нь угаасаа хэн шалгах ёстой юм, аливаа асуудлыг чинь яах гэж шалгадаг юм, хэн хэрэг тарих магадлалтай юм гэдэг өнцгөөс нь л харах нь зүйтэй байх. Тэгээд тэр субъектив асуудал гарах магадлалтай учир би энэ хуулийн төслийг бол дэмжиж гарын үсгээ зурсан байгаа. Дэмжиж өгцгөөнө үү. Тэгээд хэлэлцүүлэх явцдаа бол бас Сандаг-Очир гишүүний бас саналаар явахыг үгүйсгэхгүй л дээ. За баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Гишүүд байр сууриа илэрхийлж үг хэлж дууслаа. Гантөмөр гишүүн үг хэлнэ.

Л.Гантөмөр: Би Цогтгэрэлийн санаачилсан асуудлыг зүгээр Ардчилсан нам санаачилж байгаа юм шигээр Их Хурлын гишүүд битгий хараасай гэж хүсэж байгаа юм. Ер нь бол энэ өнөөдөр орж байгаа хуулиуд бол парламент жоохон хүчтэй байгаасай л гэдэг ийм хуулиуд шүү дээ. Тэгэхээр Монгол Ардын намын гишүүд энэ юмнууд дээр нэг жоохон хариуцлагатай хармаар байна Болормаа гишүүн ээ. Ийм болоод байна. Үнэхээр мэдлэг чадалтай залуучууд Их Хуралд орж ирсэн. Яг үнэндээ өнөөдөр тэр улсуудын хэрэг гарахгүй байна. Гарахгүй байгаа үндсэн шалтгаан бол намын бодлого гэдэг зүйл бол үнэхээр хайрцаглаж байна. Тэгээд энэ бол аль ч үед бол тохиолдох юм байна. Хэн нь эрх барьж байгаагаас үл хамаараад. Жишээлбэл нүүрсний сонсгол хийсэн. Үр дүн байна уу та хэд бодох хэрэгтэй. Эмийн сонсгол хийсэн үр дүн гарсан уу, Ковидын сонсгол хийсэн үр дүн гарсан уу, тэр түлшний сонсгол хийсэн ямар их мөнгө хулгайлсан байна түлшин дээр.

Тэгээд одоо сүүлдээ бол тэр түлшнээс маш их хар тугалга илэрсэн байдаг аа гэдэг ийм дүгнэлт гараад хариуцдаг эзэн байхгүй. Одоо яг тэр үйлдвэрийг гардан хийсэн улсууд өнөөдөр магадгүй том сайд болно гээд ингээд явж байна шүү дээ. Тэгэхээр болбол парламентын нэр хүндийг бид нар ингээд аваад явъя аа, цаашаа энэ засаглалаа жоохон төгөлдөржүүлээд явъя аа гэх юм бол яг өнөөдрийн Монголын орчноо бид нар мэдрээд, хяналтаа бол цөөнх нь хийгээд явах нь зөв өө. Хяналт нь цөөнх нь хийх хэрэгтэй. Олонх болбол Монголын энэ арын хаалга өнөөдөр зогсоогүй байна. Намын дарангуйлал гэдэг юм бол зогсоогүй байна. Тэгээд бид ингээд бодит байдлаа хараад энэ цаашид болбол хяналт гэдгийг сөрөг хүчин нь хийдэг тэр эрх мэдлийг нь өгч явахгүй бол ерөөсөө болохгүй шүү. Одоо бид нар ковидын сонсгол гээд хийх гээд л хөөрхий Бейсен гишүүн гүйгээд байсан. Нэг ч материал өгөөгүй шүү дээ. Мэдээллийн хомсдолд оруулж байгаа байхгүй юу. Гэтэл Түр хороог яг удирдаад хөдлөөд тэр нь тэгэхдээ одоо Герман энэ тэр болбол 3, 4 жилээр давж Түр хороо ажиллаж байна шүү дээ. Тийм байдлаар жоохон ажил хэрэгч байдлаар асуудалд хандаасай гэж бодож байгаа юм. Түүнээс Цогтгэрэл нэг Ардчилсан намаас нэг Түр хорооны дарга тавих гээд ч юм уу, эсвэл албаартаж ингэж улс төр хийх гэсэн зүйл энд бол байхгүй шүү гэдгийг эрхэм гишүүд минь ойлгож ухамсарлаж, энэ асуудлыг шийдэж өгөөч ээ гэж хүсэж байна. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Батбаатар гишүүн үг хэлье.

Б.Батбаатар: За ингээд ер нь бол бид нар энэ парламентын тухай ярьж байна шүү дээ. Парламент ямар байх ёстой юм, парламентын чиг үүргүүд ямар байр байх ёстой юм. Өнгөрсөн 2024 оны Их Хурлын сонгуулиас парламент тангаргаа өргөсөн цаг мөчөөс хойш энэ тухай байнга ярьсан. Бүгдээрээ нэг болохоор эрх баригчийн дүрд орчихдог, нэг болохоор сөрөг хүчин гээд дүрд орчихдог. Сөрөг хүчин чинь цөөнх чинь олонх чинь хаана байгаа юм бэ гэхлээр хуулиараа дэгэн дээрээ цөөнх гэж байдаг аа. Сөрөг хүчин гэдэг үг энэ хуульд байхгүй ээ гээд хэлж байсан бүх үгийг маань няцааж байсан. Тийм болохоор би Болормаа гишүүний үгэн дотор гарсан сөрөг хүчин, Баярмаа гишүүний үгэн дотор гарсан сөрөг хүчингийн тухай ярьж байна шүү дээ. Нэр цохож өөрийг чинь хэлээгүй. Ингээд одоо ч гэсэн ингээд л тэгээд цөөнх гэж байгаа биз дээ гээд л үг хэлж байхад нь тасалдаг. Нөгөө намын дарангуйлал үзүүлдэг чинь өөрсдийн чинь энэ байдал шүү дээ.

Тийм болохоор хэдүүлээ энэ парламентад суудалтай байгаа энэ 5 нам нь ярьж байгаад яг парламент нь ямар байх юм. Энийгээ нэг бүгдээрээ нэг ойлголцох хэрэгтэй шүү дээ. Хэдэн гишүүнтэй байна вэ, тухайн цаг мөчид одоо улс орны нөхцөл байдал байдаг юм уу, хэн нэг нь олонх нь болсон болоогүй байдаг юм уу? Эндээсээ хамаараад засаг байгуулах эд нар үедээ алийгаа цөөнх гэх юм. Алийг нь сөрөг хүчин гэх юм. Дэг нь ямар байх юм. Тэгээд тэр хяналтын чиг үүргүүд нь хэн дээр байх юм. Засагт оролцсонд нь байх юм уу, оролцоогүйд нь байх юм уу. Энэ бүх юмаа бүгдээрээ нэг ярилцаж байгаад энэ дээрээ Монголын парламентыг зөв хадгалж үлдэхийн төлөө бүгдээрээ нэг ойлголцох ёстой байхгүй юу. Ингээд нөгөө тухайн цаг үеийнхээ улс төрийн нөхцөл байдлаас хамаараад өөр өөр нөгөө өмнө ярьж байснаа үгүйсгэж, өмнө нь хэлж байснаа өөрчилж ингэж ярьдаг биш.

Монгол Улсын парламент бол ард түмний төлөөлөл шүү дээ. Тухайн үед ард түмнээ сонгогчдын хэн нь олонхын санал авна тэр нь засгаа барьдаг л юм байгаа юм биз. Хүнээс юм уу, улс төрийн нөхцөл байдал юм уу, засаг барьж байгаа, бариагүйгээс үл хамаараад тэр нь ойлгомжтой байдаг. Энэ чиглэл дээрээ бүгдээрээ нэг нэгдмээр байгаа юм. Нэг түр хороо байдаг юм уу, ямар нэг санаачилга дээр

болонгуутаа улс төрийн нөхцөл байдлаас хамаараад өөртөө ашигтай хувилбараар, ашиггүй хувилбараар давамгай юм уу, давуу байдал үүсгэх хувилбараар тайлбарлаж ярьдаггүй бүгдээрээ нэг тойрч сууж байгаад эрүүл саруулаар ярилцаад, ингэж нэг шийдэл гаргах чиглэл рүүгээ явбал зөв болов уу гэдэг ийм л байр суурь илэрхийлэх гэсэн юм.

Яг одоо байгаа Их Хурлын тухай хууль, Дэгийн тухай хуулиар бол олонх цөөнх гэсэн 2 л үг байгаа шүү дээ. За тэр нь бүлэгтэй болбол одоо цаашаа бүлгийн ийм эрхүүд эдэлнэ, эдлэхгүй гэсэн, бүлэг өөрөө Их Хурлын бүтцийн байгууллага. Тэгэхээр энэ дээрээ хэдүүлээ нэг ярьж, ойлголцол хийх маягаар одоо ингээд хүчээр кноп дараад цөөнх, одоо тэр цөөнх нь тэр түр хороог тэргүүлье гэдэг чинь огт буруу зүйл бас биш шүү дээ, хяналтын зарим үүргүүд. Тэгэхээр энийгээ нэг бүгдээрээ нэгэн жигд ойлгодог болчихоод яриад хийгээд явбал яасан юм бэ? Энэ чиглэл рүүгээ энэ улс төрийн намууд нь нэг тэнцүү тоотой байна уу, тэр одоо хүнийхээ тооноос хамаараад хувьтай байдаг юм уу сууж байгаад энийгээ нэг ойлголцож аваад парламентын ардчилал энэ парламент гэдэг зүйлээ ойлгоод бүгдээрээ энэ парламентынхаа юуг нэг жигдлээд, тоглоомын дүрмээ ойлгомжтой болгоод ямар нэг байдлаар тухайн цаг үеийн ашигтай, ашиггүй хувилбарын өнцгөөс юм ярьдаг биш ингэж шийдэх чиглэл рүү нэг санаачилга гаргаад ажиллавал яасан юм бэ л гэж санал өгч байна.

Ж.Бат-Эрдэнэ Номинчимэг гишүүн. За нэмж өгч байгаа юм чинь жоохон товчхон шиг яриад явчихъя.

О.Номинчимэг: Гишүүдийн хэлж байгааг бас ойлгож байна аа. Гэхдээ одоо Түр хорооны сонсголын үр дүн гарахгүй байна аа гэдэг даргалагч хаанаас байсантай ямар ч холбоогүй шүү Гантөмөр дарга аа. Та энийг бас ойлгож байгаа байх. Тэгээд бидний хувьд ч гэсэн энэ дээр ерөөсөө намчирхал гэж харагдахгүй харахгүй байгаа. Энэ бол намчирхал гэж харахгүй байгаа учраас хууль дээр бол зарчим байх ёстой гэж харж байгаа. Хэн нэг нь намын цөөнхөд ч юм уу, хэн нэг нь өнөөдөртөө зориулж бид хууль хийх ёсгүй. Өөрөө энэ үзэл санаа, хуулийн зарчим чинь юу байх ёстой юм бэ гэдгийг л ярьж байгаа юм. Тийм ч учраас би Цогтгэрэл даргаас яг ямар улсын парламентын тиймээ парламент ёстой ийм улсад тийм хууль байна аа гээд тэгэхээр гаргаж ирж чадахгүй байгаа. Хууль байхгүй ээ, хууль байна шүү дээ хууль болчих юм бол нөгөө талаараа, нөгөө санаачлагч олонхын гишүүд байдаг юм уу. Эд нарын эрх нь зөрчигдөх нөхцөл үүсэх гээд байна аа.

Тэгэхээр сэдэв чинь мэдээж гүйцэтгэх засаглалыг хянахтай холбоотой асуудал бол цөөнх угаасаа тэргүүлэх ёстой, тэр хяналтыг бол угаасаа хийх нь парламентат ёс. Энийг ерөөсөө үгүйсгэсэн юм байхгүй. Гэтэл та бүхний оруулж ирж байгаа хууль чинь бүх түр одоо хянан шалгалтын хороо буюу нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудал. Бүхий л хуулийн хэрэгжилтийн асуудал дээр түр хороо дээр цөөнх заавал даргалах ёстой гэдэг юм орж ирж байгаа чинь өөрөө энэ зарчмыг алдагдуулаад байгаа юмаа. Парламентат ёсны Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн энэ зарчмыг алдагдуулаад байгаа юмаа.

Тэгэхээр энэ дээрээ учир начиртай, наанатай, цаанатай хандаач ээ, зарчим нь ийм юм шүү гэдэг юмыг хэлж байгаа. Тэгэхээр хууль санаачлагч маань өөрөө энийгээ илүү бас нарийвчлаад хэрвээ томьёолол эд нараа өөрчилж орж ирэх юм бол харж ирэх боломжтой. Яг одоогийнхоороо орж ирж байгаа томьёолол үзэл баримтлалын хувьд бол өөрөө Хяналт шалгалтын тухай хуулийн зарчмыг, ер нь энэ

парламентат ёс энэ энэнийхээ зарчмыг эвдэх гээд байгаа учраас дэмжих боломжгүй байна аа л гэдгийг хэлж байгаа шүү.

Ж.Бат-Эрдэнэ: За хэн удирдахаас даргалахаас үл хамаараад би бас ярилцлага өгөөд байгаа, зөвшөөрөл өгөөд байгаа шүү. Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Үг хэлэх боломж олгосонд баярлалаа. Сая гишүүдийн үгэн дотор эрх баригч сөрөг хүчин аль эсвэл олонх цөөнх гэдэг үгүүд дээр бас нэлээн тийм акцент өгөгдөөд байна л даа. Улсын Их Хурлын тухай хууль, Дэгийн тухай хуулиудад эрх баригч сөрөг хүчний тухай зохицуулалт гэж байдаггүй юм байна лээ. Олонх цөөнх болбол сонгуулийн үр дүнгээр тоотой хэмжээтэйгээ гарчихдаг зүйл. Тэгэхээр бид нарын ярьж байгаа энэ хууль дээр ярьж байгаа зүйл бол олонх цөөнхийн л тухай яриа. Тэр эрх баригч сөрөг хүчний яриа бол Засгийн газрын түвшиндээ илүү нэгдүгээрт нь яригддаг байх аа гэж.

Тэгээд сая зарим гишүүдийн ингээд ярьж байгаа өнцгүүдийг харахад нэг ийм Улсын Их Хурал энэ чинь 4 жил тутам ард түмний сонголтоор өөрчлөгдөөд явдаг төрийн эрх барих дээд байгууллага. Энийг яг өнөөдрийн түвшинд нэг нь нэг байнга эрх барьж байх юм шиг, нөгөөдөх нь нэг байнга сөрж байх ёстой нэг хэдэн хүмүүс байгаа юм шиг нэг ийм мөнхийн сэтгэхүйнээс асуудалд бас ингээд хандаад байна аа. Энэ ерөөсөө энэ парламентат ёсных нь үзэл баримтлалын түвшинд л гэж бид нар ярьж байгаа юм. Тэгээд аль улсад байдаг жишээн дээр бол яг тэр Германы, Бундестагийн Германы парламентын зохицуулалт дээр бол энэ тухай нэлээн тийм том бүлэг, хэрхэн яаж энэ хяналтын түр хороог байгуулж, энийг үр ашигтай явуулах тухай яг саяын тэр бүрэлдэхүүн жилд бүр 2, 3 парламент дамжиж явдаг нэг түр хороо гэх мэтээр маш тийм өргөн зохицуулалт цөөнхөөсөө ахалдаг зохицуулалт Бундестагт бол маш том, том хэмжээний зохицуулалт энд байдаг гэдгийг дурдъя.

Тэгээд гишүүд үзэл баримтлалынх нь түвшинд асуудлыг дэмжээд тэр Сандаг-Очир гишүүний ярьж байгаа өнцөг бол бас анхаарч үзэх ёстой өнцөг байна лээ. Тэгээд тэр тэр саналуудыг бид нар хэлэлцүүлгийн түвшинд бас ярилцаад явах боломжтой гэж бодож байна.

Ж.Бат-Эрдэнэ: Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалтад бэлдье.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 19 гишүүнээс 18 гишүүн оролцож, 42.1 хувиар.

Тэгээд яах юм. Санал дэмжигдсэнгүй ээ. Баярмаа гишүүнийг үгүй ээ тэгэхээр чинь яах юм наадах чинь. Санал дэмжигдсэнгүй. Баярмаа гишүүн дэмжсэн гэж протоколд оруулъя.

13:57

Ж.Бат-Эрдэнэ: Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Их

Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 11 гишүүн 2025 оны 6 дугаар сарын 10-ны өдөр өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэх тухай.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин хийнэ. Тэмүүжин гишүүний микрофоныг өгье.

Х.Тэмүүжин: Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын Их Хурлын дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг Улсын Их Хуралд суудал бүхий бүх намын гишүүд төлөөлөл болж гарын үсэг зурж өргөн барьсан. За энэ хуулийн төсөл бол дотроо хоёрхон гол үзэл санаатай. 1 дүгээр үзэл санаа бол одоо Дэгийн тухай хууль дээр байгаа Ерөнхий сайдын мэдээллийн цаг гэдгийг Улсын Их Хурлын асуулгын цаг болгож өөрчилж байгаа.

Одоо байгаа зохицуулалтаар Ерөнхий сайд Улсын Их Хуралд ямар мэдээлэл өгөхөө өөрөө сонгодог, тэр мэдээллийнх нь хүрээнд гишүүд асуудаг ийм зарчим байгаад байгаа юм. Гэтэл бусад парламентын засаглал бүхий парламент ёс бүхий улс орнуудад ямар зарчим байна вэ гэхээр асуултыг асуух эрх нь бол парламентын гишүүдэд байдаг аа. Тэр дундаа тодорхой нөхцөл байдал, цаг үеийн болон нийгмийн тулгамдсан асуудлуудаар парламентын гишүүд Ерөнхий сайдыг дуудаж асуух эрх бол парламентат ёсны хамгийн чухал амин сүнс байна аа. Тэгэхээр Ерөнхий сайдын мэдээллийн цаг биш Улсын Их Хурлын асуулгын цаг болгож өөрчлөх, Ерөнхий сайд биеэрээ ирж асуултад хариулдаг байх. Асуулга асуулт асуух эрх нь зөвхөн цөөнхөд биш бас олонхоос ч гэсэн асууж болдог тэр хувилбараар бид нар хуулийн төслийг өргөн барьсан.

2 дахь нь бол парламентаас шийдвэр гаргах. Парламент хяналтаа тавихад хамгийн чухал зүйл бол үнэн бодит мэдээлэл гэдэг юм байна лээ. Тийм учраас Улсын Их Хуралд мэдээлэл өгч байгаа албан тушаалтнууд худал мэдээлэл парламентад өгдөггүй байх энэ зарчмыг хангуулахын тулд Улсын Их Хурлын чуулганд худал мэдээлэл өгсөн бол хариуцлага тооцдог, чуулганд мэдээлэл өгөхөөсөө өмнө тэр хариуцлагын баталгаа болгож гарын үсэг зурдаг энэ жишгийг бол одоо хуульчлах шаардлагатай юм байна. Байнгын хороон дээр бол энэ байхгүй. Байнгын хороон дээр алдаа гарсан бол тэр алдаагаа чуулган руу чирч оруулж ирдэггүй байх. Хариуцлагатай байх гэдэг энэ зарчмыг хангуулахын тулд энэ парламентыг хуурах буюу худал мэдээлэл өгөх асуудлыг бол бас зохицуулалтаар оруулж ирж байгаа.

Өргөн барьж байгаа хуулийн 2 гол агуулга бол ердөө энэ. Асуулгын цаг парламентад худал мэдээлэл албан тушаалтанд өгөхгүй байх тухай.

Ж.Бат-Эрдэнэ: Хууль санаачлагчийн илтгэл үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу нэрсээ өгнө үү? Алга байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? алга байна. За санал хураалтад бэлдье.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

19 гишүүнээс 14 гишүүн санал хураалтад оролцож, 73.7 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дэмжих нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 19 гишүүнээс 14 гишүүн оролцож 73.7 хувиар санал дэмжигдлээ.

Одоо санал хураалт хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дэмжих нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

19 гишүүнээс 14 гишүүн оролцож, 73.7 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны санал дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн хэн танилцуулах вэ. За Сандаг-Очир гишүүн танилцуулна.

Түрүүний хэлэлцсэн хуулийг бас Сандаг-Очир гишүүн танилцуулчих уу? Түрүүнийх чинь тийм. За Сандаг-Очир гишүүн танилцуулна. За тэгье. Тэр чинь хуулийн нэр юу гэж байгаа билээ?

Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Пүрэвдорж гишүүн танилцуулна. Чуулганд Пүрэвдорж гишүүн танилцуулъя.

14:03

Ж.Бат-Эрдэнэ: 5 дахь асуудал. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах нэмэлт оруулах тухай хуулийн төсөл Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 40 гишүүн 2025 оны 6 сарын 12-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэх.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин танилцуулна аа. Тэмүүжин гишүүний микрофоныг нээе.

Х.Тэмүүжин: Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 40 гишүүн санаачилж бас өргөн барьсан. Маш товчхон агуулгатай. Гишүүдийн дунд яриагаар бол сандал суудлын асуудал байгаа. Ер нь бол Улсын Их Хурал, Засгийн газар хоёрын хил хязгаарыг тогтоож, Үндсэн хуулийн дэг журмыг сахиулахын тулд хэлбэр дүрсийн хувьд ч гэсэн бас шийдэх ёстой асуудлууд зөндөө байдаг юм байна. Яг одоогоор бол Улсын Их Хурлын чуулганы сандал суудлын асуудлыг ямар нэгэн хуулиар зохицуулаагүй юм байна. Тэгээд практикаараа юу явсан бэ гэхээр Улсын Их Хурлын нэг дэд дарга өөрийн одоо тушаалаар маягтай сайн дураараа гарын үсэг зураад баталгаажуулдаг тийм хэв маягтай юм байна.

Сандал суудлын хуваарийг яг шийдэж байгаа хүмүүс нь бол ёслолын албаныхан үндсэндээ шийдчихдэг юм байна. Тэгэхээр ер нь бол хуулийн зохицуулалттай болох хэрэгцээ бол нэгдүгээрт байна.

2 дугаарт энэ санал суудлын хуваарьтай холбоотойгоор Үндсэн хуулийн зарчмуудыг амилуулах хэрэгцээ байна аа. 1992 оны Үндсэн хууль бол эрх мэдлийг хуваарилсан. Гүйцэтгэх эрх мэдэл буюу Засгийн газрыг толгойлох, удирдах нь бол Ерөнхий сайд. Тэгээд Улсын Их Хурлын өмнө төрийн хууль биелүүлэх ажлыг хариуцна гэж байгаа юм. Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага, хууль тогтоох эрх мэдлийг дангаар хэрэгжүүлдэг. Хуулийн биелэлтийг хянах эрх мэдэлтэй, Ерөнхий сайдыг томилох, огцруулах эрх мэдэлтэй ийм байгууллага байгаа. Гэтэл энэ одоо эрх мэдлийн хуваарилалтын хил хязгаар бүдгэрэхээс гадна нөгөө харилцан хяналттай түвшин байх ёстой, түвшингийн зааг бол эвдэрсэн байна гэж харагдаж байгаа.

Улсын Их Хурлын толгой дээр буюу хойморт Ерөнхий сайд гараад тусгайлсан сандал ширээ засаад суудаг нь бол Үндсэн хуулийн дэг журмыг бол үндсэндээ бол эвдэж байгаа юм байна лээ. 1992 оны Монгол Улсын Үндсэн хууль алдагдаж байна гэсэн үг. Энэ суудалтай холбоотой асуудлыг олон улсын жишгээр ингээд судлахаар парламентын засаглал бүхий парламентат ёс бүхий улс орнууд бол ерөөсөө Ерөнхий сайдын суудлыг гишүүдийнх нь дунд нь олонх цөөнхийн харьцаагаар суулгадаг юм байна лээ. Зарим нэг парламент бол Засгийн газрын гишүүдэд бүр тусад нь суудал гаргаж өгөөд, тэр суудлынх нь дотор Ерөнхий сайд нь энгийнчилж сууж байдаг юм байна лээ. Тэгээд манайх шиг ийм одоо хээ хуартай тусдаа сэнтий ноён сэнтий засаж өгөөд толгой дээрээ залдаг парламент бол байхгүй. Тэр битгий хэл Ерөнхийлөгчийн суудал дээр юу ямар асуудал тавигддаг вэ гэхээр яг орж ирээд үг хэлэхэд нь тусдаа сандал засаж өгөөд тэгээд чуулганд орж ирээгүй үед нь бол тэр суудлаа авдаг юм байна лээ. Яагаад гэвэл нөгөө Үндсэн хууль дээр байгаа хамгийн чухал заалт. Дэлхийн бүх улс оронд яг ижил заалт байна. Улсын Их Хурал 126 гишүүнээс бүрдэнэ. Өөр хэн ч байхгүй.

Улсын Их Хурал чуулган болон байнгын хорооны хуралдааны хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулна. Энэ хуралдааныг зохион байгуулахтай холбоотойгоор спикер буюу Улсын Их Хурлын дарга гарч ирнэ. Хуралдаан зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлэх зорилготойгоор спикерийг тусгайлан хуралдаан даргалагчийн суудал дээр суулгана. Өөр 126-гаас тусдаа суудал засахыг хорьдог юм байна лээ.

Хоёрт нь нөгөө парламентад байгаа бас нэг аягүй чухал зарчим зөвхөн Улсын Их Хурлын буюу парламентын мандаттай хүн Улсын Их Хуралд үг хэлдэг юм байна лээ. Бусад хүнийг үг хэлнэ гэж хэлдэггүй, мэдээлэл өгнө гэж хэлдэг юм байна лээ. Ерөөсөө зарчим нь. Бид өнөөдөр юу болгоод хувиргачихсан гэхээр Монгол Улсын Үндсэн хууль дээр ч байгаа. Ерөнхийлөгчийг хүртэл мэдээлэл өгнө гэж бичсэн байна лээ. Үг хэлнэ гэж биш. Гэтэл бид нар өнөөдөр юу болсон гэхээр Улсын Их Хурал дээр дуртай нь үг хэлдэг болоод орчихсон. 126-аас гадна өөр статустайгаар. Тэгэхээр ийм Үндсэн хуулийн бус зарчим агуулгыг засахгүй бол хэлбэр дүрсний юм шиг боловч энэ бол концепцын шинжтэй, Үндсэн хуулийн байгууллагыг хамгаалах зорилготой, тэр дундаа 1992 оны Үндсэн хуулийн эрх мэдэл хуваарилалт болон энэ хяналт тэнцлийн зарчмыг хангуулах зорилттой маш чухал хууль байгаа юм шүү.

Ж.Бат-Эрдэнэ: Хууль санаачлагчийн илтгэл төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна.

За энэ бүлгийн намын бүлгээр хэлэлцсэн нь зүйтэй байх гэсэн ийм санал гаргаж байна аа тийм. Горимын санал гаргаж байна. Гишүүдээс МАН-ын бүлгээр хэлэлцье гэсэн ийм санал гарч байгаа тул миний хувьд санал гаргаж байна аа. Энэ бүлэг хуралдах хүртэл энэ асуудлыг хойшлуулъя гэсэн горимын санал гаргаж байна. Ингээд горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

Саяын горимын саналыг буцаалаа. Ариунзаяа гишүүн. Ариунзаяа гишүүний микрофоныг өгье.

А.Ариунзаяа: Байнгын хорооны дарга аа. Энэ ер нь жоохон их маргаантай асуудал байгаа учраас бүлгээрээ дахиж ярилцсан нь зүйтэй байх аа. Ийм учраас 5 хоногийн завсарлага МАН-ын бүлгээс хүсэж байна.

Ж.Бат-Эрдэнэ: 5 хоногийн завсарлага өглөө энэ хуулийн хүрээнд.

14:14

Ж.Бат-Эрдэнэ: Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ нарын 10 гишүүн 2025 оны 6 сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэх тухай.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ танилцуулна. 4 номерын микрофон.

Б.Бат-Эрдэнэ: Эрхэм дарга, гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая аа. 2024 оны 12 дугаар сард иргэдээс тавьсан маш олон жагсаал, цуглааны асуудлууд хөндөгдсөн. Үүн дотор бол агаар орчны бохирдолтой холбоотой асуудлууд бас байсан. Ингээд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4.2-т заасны дагуу 70 мянга ба түүнээс дээш тооны иргэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хяналт шалгалт явуулах санал гаргаж, хуульд заасан журмын дагуу шаардлага нөхцөл хангагдсан тул Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2024 оны 12 сарын 19-ний өдрийн 7 дугаар тогтоолоор агаарын бохирдол, утааны асуудлаар ерөнхий хяналтын сонсголын бэлтгэлийг хангах, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн ерөнхий хяналтын сонсголыг Монгол Улсын Их Хурлын хяналт, шалгалтын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Улсын Их Хурлын Тамгын газар 2025 оны 2 дугаар сарын 3, 4-ний өдөр зохион байгуулж санал, дүгнэлтээ 2025 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд, 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд албан ёсоор танилцуулсан.

Ерөнхий хяналтын сонсголын нэгдсэн санал дүгнэлтэд Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо цаашид Утаа агаарын бохирдлыг бууруулах дэд хороог байгуулж, хариуцлага алдсан албан тушаалтнуудад хариуцлага тооцох талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах, хянан шалгах эрх бүхий байгууллагын мэдээллийг тогтмол сонсох, холбогдох хууль, тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг шийдвэрлэх гэж тусгасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг тодорхойлж, түүнд нийцүүлэн хуулийн төслийг боловсруулсан болно.

Агаар орчны бохирдлын асуудлыг төрийн бүх байгууллага, нийслэл, орон нутгийн байгууллага, бусад эрдэм шинжилгээний болон судалгааны байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшлийн байгууллагууд өөрсдийн чиг үүргийн дагуу хариуцан гүйцэтгэж байгаа. Гэвч агаарын агаар орчны бохирдлыг бууруулахтай холбоотой хууль, тогтоомж, шийдвэрийн уялдааг хангах, зөрчлийг арилгах, хэрэгжилтэд хяналт тавих, холбогдох өөрчлөлтийг тухай бүр хийх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох ажил төдийлөн хийгдээгүй талаар судалгааны дүгнэлтүүд гарсаар байна аа. Энэ нь хууль тогтоох дээд байгууллагын хувьд батлагдсан, батлагдан гарсан хууль, тогтоомжийн биелэлтэд тавих хяналт сул, хяналт шалгалтын ажил хийгдсэн ч төдийлөн оновчтой, үр дүнтэй бус байгаагийн нэг илрэл хэмээн үзэж байгаа.

Тийм учраас Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 2-т Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй гэж заасныг ханган баталгаажуулах зорилгоор Монгол Улсад агаар орчны бохирдлыг бууруулахад чиглэсэн хууль, эрх зүйн орчныг сайжруулж, бодит үр дүнд хүрэх стратегийг хэрэгжүүлэх, бодлогын хэрэгжилтийг дэмжих орчныг бүрдүүлэхийн тулд Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны харьяанд агаарын бохирдол, хорт бодис, байгаль орчны асуудал, байгаль орчныг хамгаалах, байгалийн тэнцлийг хангах асуудал, цаг уур, орчны хяналтын асуудал, усны бодлого, нөөц, усны бохирдол, хог хаягдал, дахин боловсруулалт зэрэг асуудлыг дагнан хариуцах үүрэг бүхий Агаар орчны бохирдлыг бууруулах дэд хороог байгуулах хуулийн төслийг боловсруулан өргөн барьж байгаа болно оо. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Хууль санаачлагчийн илтгэл болон төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Хууль санаачлагчийн илтгэл төслийн үзэл баримтлалтай холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? Алга байна. Гишүүд санал хураалтад бэлдье. Санал хураалтдаа бэлдье, болсон уу?

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

19 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, 47.4 хувиар санал дэмжигдсэнгүй. Горимын санал гаргаж байна. Хэн гаргах юм. Г.Уянгахишиг гишүүн.

Г.Уянгахишиг: Дарга аа, горимын санал гаргах гэсэн юм. Сая уг нь дэмжсэн санал ийшээгээ орсонгүй. Дахиад энэ саналыг хүчингүй болгоод дахин санал хураалт явуулах хүсэлттэй байна.

Ж.Бат-Эрдэнэ: Уянгахишиг гишүүний гаргасан горимын саналын дагуу саяын санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Санал хураалт.

19 гишүүнээс 11 гишүүн санал хураалтад оролцож, 57.9 хувиар санал хүчингүйд тооцлоо.

За анхааралтай санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 19 гишүүнээс 11 гишүүн оролцож, 57.9 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг хийж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Болормаа танилцуулъя.

14:20

Ж.Бат-Эрдэнэ: Дараагийн асуудал сүүлийн асуудал.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нарын 9 гишүүн 2025 оны 6 сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэх тухай.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа хийнэ ээ. Ариунзаяа гишүүний микрофоныг нээе.

А.Ариунзаяа: Улсын Их Хуралд суудалтай 5 намын төлөөлөл бүлгийн дэд дарга нар, бүлэггүй намын гишүүд, Улсын Их Хурлын гишүүн Алдаржавхлан, Батболд, Жаргалан, Лодойсамбуу, Найдалаа, Номтойбаяр, Отгонбаяр, Тэмүүжин нарын хамтаар хуулийн төсөл боловсруулж өргөн барьсан.

Энэ одоо юутай холбоотой юм бэ гэхээр Улсын Их Хурлын үйл ажиллагааг илүү оновчтой болгох, цомхон болгох, өмнө нь хүнд зориулсан бүтцүүдийг бий болгосон асуудлуудыг цэгцлэх, түүхэндээ явж ирсэн 7-8 одоо Байнгын хороотой байх зэрэг асуудлуудыг өдгөөгийн Улсын Их Хурал бас өөрчлөлтийг өөрөөсөө оновчтой болгох ийм шийдлийг оруулж ирэх ийм санаачилга гараад хуулийг өргөн барьж байна аа.

Иргэд, байгууллагаас Улсын Их Хуралд ирүүлсэн өргөдлийг судлах, дүн шинжилгээ хийх, холбогдох санал бэлтгэх болон нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийн асуудлыг Өргөдлийн байнгын хороогоор дамжуулж авах нь зүйтэй байна аа гэдэг ийм асуудлыг дэвшүүлсэн.

Аж үйлдвэржилтийн бодлогын болон Инновац, цахим бодлогын байнгын хороог Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэх, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороог Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэх, Ёс зүй, дэгийн байнгын хороог Төрийн байгуулалтын байнгын хороонд эргүүлэн шилжүүлэх ийм асуудлыг боловсруулсан.

Төрийн байгуулалтын байнгын хороонд Ёс зүйн бүсчилсэн хөгжлийн Эдийн засгийн байнгын хороонд жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжлийн Инновац цахим бодлогын хөгжлийн, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд агаар орчны бохирдлын, хүнс, хөдөө аж ахуйн, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шинжлэх ухааны спорт, соёл, спорт, залуучуудын дэд хороог байгуулахаар тусгасан буюу нийтдээ 11 байнгын хороо

байгааг 8 байнгын хороо болгох, 5 дэд хороо байгааг 13 дэд хороо болгох ийм өөрчлөлтийг оруулсан байна аа.

Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлийн хуралд зөвлөлийн одоогийн байгаа бүрэлдэхүүнээс гадна Улсын Их Хуралд суудалтай нам, эвслийн бүлэг байгуулаагүй нам, эвслийн төлөөлөл Улсын Их Хурлын гишүүн санал өгөх эрхтэйгээр оролцох. Нам, эвслийн бүлгийн дэд дарга нарын хувьд бол санал өгөх эрхгүйгээр оролцохыг тусгаж хуульчилсан болно. Хэлэлцэж шийдвэрлэж өгөхийг хүсье ээ.

Ж.Бат-Эрдэнэ: Хууль санаачлагчийн илтгэл болон төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Номинчимэг гишүүнээр тасаллаа. За Зулпхар гишүүн.

С.Зулпхар: Ариунзаяа гишүүний санаачилсан хуулийг зарчмын хувьд бол дэмжиж байгаа юмаа. Гэхдээ нэг зүйлийг тодруулмаар байна аа. Энэ Боловсрол, шинжлэх ухаан, спортын байнгын хороог Нийгмийн бодлогын байнгын хороонд чиг үүргийг нь шилжүүлж байгаа юм байна шүү дээ. Яагаад гэдэг асуулт гарч ирээд байна л даа. Манай улс төрийн одоо аль ч нам сонгуулийн мөрийн хөтөлбөртөө боловсрол хүний хөгжил бол манай улс орны одоо тэргүүлэх чиглэл байх болно гэж хөгжлийн гээдд тэгчихсэн. Тэгээд энэнтэй уялдсан байдлаар Байнгын хороон дээр нь бид нар энэ бодлогыг тодорхойлж, шийдвэр гаргаж явах учиртай. Цаашлаад энэ багаар бодоход 1.4 сая хүний хөгжлийн асуудал, сургуулийн өмнөх боловсролоос авхуулаад бага боловсрол тэгээд одоо ерөнхий боловсрол, бүрэн болон бүрэн дунд боловсрол, мэргэжлийн боловсрол, тэгээд дээд боловсрол, насан туршийн боловсрол гээд тэгээд ийм чухал асуудлыг аваачаад Нийгмийн бодлогын байнгын хороо руу ингэж шилжүүлдэг нь бол зөв үү? Одоо энэ дээр та бүхэн яаж одоо бодож энийг ингээд шилжүүлэв. Энийг би зориуд асууж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Ариунзаяа гишүүн хариулъя.

А.Ариунзаяа: Зулпхар гишүүний асуултад хариулъя аа. Ер нь бол Монгол Улсад байнгын ажиллагаатай парламент байгуулагдан ажилласнаас хойш Улсын Их Хурал 7-11 Байнгын хороотой байнга тогтмол одоо үйл ажиллагаа явуулж ирсэн. 1992-1996 онд 10 байнгын хороо, 1996-2004, 2006-2012 онд 7 Байнгын хороо, 2012-2020 онд 8 Байнгын хороотой үйл ажиллагаа явуулсан. 2004-2006, 2020 оноос одоог хүртэл 11 Байнгын хороотой явж ирсэн байна аа. Ер нь болбол сүүлийн одоо энэ 30 жилийн түүхийг аваад үзэх юм бол 7 Байнгын хороо яг тогтмол ажиллаж ирсэн. Үндсэн одоо 7 Байнгын хороо байна аа гэсэн үг.

Тэгэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Нийгмийн бодлого, боловсрол, соёл шинжлэх ухааны байнгын хороо, Төрийн байгуулалтын байнгын хороо, Төсвийн байнгын хороо, Хууль зүйн байнгын хороо, Эдийн засгийн гэсэн ийм 7 үндсэн Байнгын хороод үйл ажиллагаа явуулж ирсэн байна. Нийгмийн бодлогын байнгын хороог хэзээ хуваасан юм бэ гэхээр 2020 онд хуваасан болж таарч байгаа юм. Тэгэхээр үүнийг бол эргүүлэн нэгтгэх нь зүйтэй юм байна аа ердөөсөө ер нь бид нар одоо залуучуудын хүн амын бүлгүүдийг аваад үзэхэд хүртэл, хүүхдийн асуудлыг аваад үзэхэд хүртэл 2 өөр Байнгын хороонд яваад байгаа нь бол өөрөө ердөөсөө зохисгүй байна аа. Бодлого хэрэгжих юм болбол ердөөсөө нэг л одоо толгойтой байх

хэрэгтэй. Харин дэд хороондоо болбол тухайлсан чиглэл чиглэлээрээ бол мэргэших мэргэшин одоо явах нь зүйтэй юм байна аа гээд гэдэг ийм асуудлыг оруулсан.

Ж.Бат-Эрдэнэ: Уянгахишиг гишүүн асуулт асууя.

Г.Уянгахишиг: Асуулт Зулпхар гишүүний асуулттай ерөнхийдөө давхацчихлаа. Тэгээд яах вэ Ариунзаяа гишүүний хэлсэн хариулттай холбогдуулж хэлэхэд энэ өөрөө улс орны нөхцөл байдал болон одоо хүн амын өсөлттэй холбоотой асуудлуудын илүү нарийвчлалтай холбоотойгоор бид нар яамдынхаа тоог ч гэсэн нэмэгдүүлж байгаа. Яг юу гэдэг юм статистик тоогоороо хэдэн яамтай явж байсан бэ гэдгээ одоо Байнгын хорооны тоо гэдэг шигээ яамдынхаа тоог ярих юм бол бас асуудал үүснэ ээ. Бид нар яамдаа тэгвэл нэгтгэх асуудал ярих юм уу. Энэ талаасаа яг боловсролын Байнгын хороог нийгмийн бодлогынхтой нэгтгэх гэдэг дээр бол санал нийлэхгүй байна аа. Бид нар боловсролын асуудал өөрөө маш өргөн хүрээний асуудал. Энийг нэг Байнгын хороо руу нэгтгээд тэр дотор жишээлбэл дэд хорооны хэмжээнд авч үзнэ гэдэг бол энэ бол байж болохгүй л гэж харж байна. Тэгэхээр энэ дээр бол адилхан саналтай, адилхан асуулттай байгаа гэсэн үг.

Ж.Бат-Эрдэнэ: Санал хэллээ. Тэмүүжин гишүүн.

Х.Тэмүүжин: Байнгын хороо болон Улсын Их Хурлын тухай хуульд Байнгын хорооны тоо цөөлөх болон дэд хороо шинээр байгуулахтай холбоотой зохицуулалтууд бол түрүүчийн Бат-Эрдэнэ минийх энэ тэртэй яг адилхан. Тэгээд бид бол нэг юман дээр одоо нэгдсэн ойлголтод хүрэх ёстой. Хуулиар нэр зааж байгуулж байгаа байнгын хороод бол хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хууль санаачлагчдын бүрэн эрх байгаа. Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахгүйгээр нэр заахгүйгээр Байнгын хороо байгуулах эрх бол Улсын Их Хуралд бас байж байгаа. Тэгээд тэр нь бол Байнгын хорооны саналаар зохион байгуулагддаг энэ хэлбэр нь бол байгаа шүү. Энэ 2 замыг ингээд хооронд нь зөрчилдүүлж, эсвэл нэг болгож хүчилж ерөөсөө болохгүй шүү гэдэг үгийг хэлэх гэж байна.

Хоёрт нь, Тусгай хяналтын дэд хороо байгуулах болон түрүүн Цогтгэрэл гишүүний өргөн барьсан тэр чинь бас манай бүлгийнхний өргөн барьсан хуулиуд байхгүй юу. Тэгээд энэ 2 хууль дээр, чуулган дээр ямар байр суурь илэрхийлэхээс шалтгаалаад бид энэ хууль дээр завсарлага авах эсэхээ бол тэндээ шийднэ. Энийг би сануулж хэлж байна. Ер нь бол Цогтгэрэл гишүүний өргөн барьсан тэр хяналтын түр хороо отхок гэж ярьдаг түр хороо байгуулаад, хэн нь даргалах вэ гэдэг асуудал бол аль хууль, аль хуулиараа биднүүс шууд хүчиндээд олонх юм уу, цөөнх гэж бичих нь жоохон зохимжгүй байж магадгүй. Гэхдээ дундын шийдэл болгоод тэр сэдвээр санаачилга гаргасан илүү мэргэшсэн санал одоо санаа зовоод, хамтраад ажиллаж байгаа 32 хүн гишүүн гарын үсэг зурж байгаа учраас тэр дундаас нь даргалагчийг тавих гэдэг бол илүү үр дүнтэй, оновчтой хяналт явуулах парламентат ёсны нэг зөв хэлбэр байж магадгүй.

Тийм учраас хэлэлцэхийг нь дэмжээд, хэлэлцүүлгийнхээ явцад бол тэгж засаад явах боломж байгаа шүү. Тийм учраас хэлэлцүүлгийг нь чуулган дээр дэмжээрэй, дэмжээсэй гэж би хүсэж байна. Нөгөөтээгүүр Тусгай хяналтын дэд хороо бол энэ чинь хүний эрхийн асуудал, хуулийн засаглалын асуудал, Хууль зүйн байнгын хороо өөрөө өөрийнхөө эрхлэх асуудлыг илүү үр дүнтэй ажиллах. Нөгөөтээгүүр парламентынхаа толгой дээр гараад суучихсан хууль сахиулагчидтай байхгүй байх гэдэг аягүй чухал. Парламентын бие даасан дархлааны тухай асуудал

чинь ерөөсөө л гүйцэтгэх эрх мэдэл буюу Засгийн газрын хамгийн хүчтэй арга хэрэгслээс парламент бие даасан айхгүй айдасгүй байх тухай ярина шүү дээ. Тийм учраас энэ бол Монгол Улсын парламентын өнгөрсөн 30 жил, дараагийн 30 жил энэ 60 жилийн түүхийг илэрхийлэх бас нэг том шийдэл шүү. Энэ дээр бас та бүхэн бодолцоорой. Энэ 2 асуудал дээр ойлголцолд хүрэхгүй бол чуулган дээр Ардчилсан намын бүлэг албан ёсоор одоо хэлэлцэж байгаа хуулиас завсарлага авна аа гэдгийг хэлчихье.

Ж.Бат-Эрдэнэ: Санал хэллээ. Шижир гишүүн асуулт асууя.

Ө.Шижир: Засгийн газрын бүтэц өөрчлөгдөхөөр дагаад Их Хурлын бүтэц өөрчлөгдөж байгаа юм шиг л харагдаж байна л даа. Тэгэхээр нөгөө өчигдөр би хэлсэн хүнд нь зориулж, Засгийн газрын бүтэц бол хүнд нь зориулж бүтэц зуран байна гээд. Одоо энэ нэг одоо энэ Их Хурлын энэ бүтэц бас яг тэрний араас л явж байна гэж би бол дүгнэж байна. Яагаад гэхээр энэ дүгнэлт дээрээ Улсын Их Хурлын зохион байгуулалтыг цомхон, үйл ажиллагааг нь боловсронгуй болгоно гэхихсэн байх юм. Тэгээд 2 Байнгын хороог татан буулгаад бусдад нь нэгтгээд, нэгтгэхээр цаасан дээр л харагдах болохоос энэ чинь бүтэц орон тоо хэвээрээ л үлдэнэ шүү дээ. Яг ний нуугүй хэлэхэд.

Дараа нь дахиад энэ арга хэмжээн дээрээ Улсын Их Хурлын дотоод зохион байгуулалт сайжирна аа гэхихсэн. Одоо байгаа нь тийм өөрөө оновчгүй байгаа юм уу? Энэ одоо яг бичсэн үг нь харин асууж байгаа шүү. Улсын Их Хурлын Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээ оновчтой болно гэхихсэн байх юм. Тэгээд одоо байгаа Байнгын хороодыг чинь одоо оновчгүй байна гэж үзэж байгаа юм уу? Ер нь бол одоо энэ цахим бас Аж үйлдвэржилтийн байнгын хороо 2 чинь маш чухал 2 Байнгын хороо шүү дээ. Бид нар үйлдвэрлэе, хөгжье, улсаараа баяжъя, урагшаа явъя, ДНБ нь 10 мянган долларт хүргэе гээд ингээд энэ чинь дандаа л энийг чинь юу хүргэх вэ гэхээр аж үйлдвэрлэгч л хүргэнэ шүү дээ. Тэгээд аж үйлдвэрлэлтийн бодлогоо ингээд бүүр байхгүй болгоод нэг өөр бусад Байнгын хороонд харьяалах. Энэ бол Аж үйлдвэржилтийн байнгын хороо бол маш хэрэгтэй.

Дээр нь цахим ийм орчин үе одоо бид нарын интернэт хэрэглээ, гар утас, одоо өдөр тутам хэрэглэж байгаа зүйлүүд бол бүгд л цахимжиж байгаа шүү дээ. Тэгээд Цахим бодлогын байнгын хороогоо байгаад энэ дээрээ төрийн бодлогоо хэрэгжүүлээд явахгүй бол энэ чинь бид нар чинь бүүр цахим яамтай биз дээ бас. Тийм байхад ингээд энэ аж үйлдвэр цахим 2-ыг нэгтгээд явдаг нь хэр зөв юм бэ. Одоо байгаа тэгээд энэ бүтцүүд чинь нэг тийм маш зохион байгуулалтгүй, тэгээд уялдаа холбоогүй ийм л байгаа юм байна л даа. Энэ дүгнэлтээс нь. Энэ чинь ингээд дүгнээд биччихсэн байгаа байхгүй юу. Уялдаа холбоогүй, зохион байгуулалтгүй цомхон гээд ингээд биччихсэн байгаа байхгүй юу. Тэгээд одоо би бол энэ хаа ч байж манай энэ Их Хурлын Тамгын газар энэ хуралдаан зохион байгуулалт, энэ байнгын хороодынх нь бол их сайн ажилладаг гэж боддог шүү дээ. Тэгээд энэ дээр ингээд шууд үгүйсгээд ороод ирчихсэн байна л даа. Энийг л асуух гэсэн юм.

Ж.Бат-Эрдэнэ: Ариунзаяа гишүүн хариулъя.

А.Ариунзаяа: Шижир гишүүний асуултад хариулъя аа. Өчигдөр билүү хэзээ билээ хүнд зориулсан бүтцийг одоо болих хэрэгтэй гэдэг үгийг хэлж байсан. Түүнийг бол би бас алга ташиж хүлээж авсан. Яагаад гэвэл яг эдгээр байнгын хороод болбол 2020 онд хүнд зориулж байгуулагдсан байнгын хороод байгаа юмаа. Тэгэхээр

үүнээсээ улбаалж яг одоо үйл ажиллагаа явуулж байгаа байнгын хороодыг аваад үзэх юм бол зарим байнгын хороод нь нийт одоо 25-аас илүүгүй гишүүн нэг байнгын хороонд одоо байна аа гэсэн заалт байгаа шүү дээ тийм ээ. Тэгэхээр зарим байнгын хороонд болбол 11-хэн хүнтэй Байнгын хороо хүртэл байгаа байхгүй юу.

Тэгэхээр ер нь нийт гишүүдийнхээ 50 хувьдаа ч хүрэхгүй ийм байнгын хороод болбол байна аа. Нэгдүгээрт ирц нь үүнээсээ улбаалаад одоо тухайн гаргаж байгаа шийдвэрийнх нь талаар нь ирц нь бүрдээд, түүнээсээ одоо эргээд талаар нь хүчин төгөлдөр одоо санал нь авагддаг болбол энэ гаргаж байгаа шийдвэрийнх нь одоо чанарын хувьд ч гэсэн ирцээсээ авхуулаад маш бага байна аа гэдэг ийм дүгнэлтийг бол хийж байгаа.

Хоёр дахь нь болохлоор харилцан адилгүй ачаалалтай байна аа. Зарим байнгын хороод болбол маш ачаалалтай 7 хоног болгон хуралдаж байгаа болбол зарим байнгын хороод болбол Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлөөс асуудал хуваарилагдахгүй байх. Тухайн асуудлууд нь давхардах, нэн ялангуяа мэргэжлийн яамдуудын хувьд төсөв байна уу, гүйцэтгэл байна уу, төлөвлөгөө байна уу тухайн асуудлууд дээр яг ижилхэн асуудлуудын хүрээнд олон байнгын хороонд зэрэг орох ийм асуудал үүсэж байгаа нь бол чиг үүргийн давхардлыг бол харуулж байгаа юмаа. Ийм учраас үндсэндээ хүнд зориулсан одоо тэр бүтцийг байхгүй болгож үндсэндээ 30 жилийн түүхэнд явж ирсэн энэ мэргэжлийн парламент үндсэн байнгын хороодоороо л үйл ажиллагаагаа одоо эргүүлээд явдаг байя гэсэн ийм одоо саналыг оруулж ирж байгаа.

Эргээд нөгөө төсөвтэй ч гэсэн холбоотой 3 Байнгын хороо татан буугдаж байгаатай холбоотой төсөв харин ч хэмнэгдэнэ. Ажлын алба байхгүй байна аа гэсэн үг тиймээ. Дэд хороо 13 дэд хороо байгуулагдаж байгаа нь бол тухайн дэд хороонд ямар нэгэн ажлын алба гэдэг юм уу, цалин зардал хөлс байхгүй шүү дээ. Тухайн Улсын Их Хурлын гишүүд харин чиг яг одоо мэргэжил мэргэжлээрээ тухайн салбар салбараараа илүү мэргэшиж, илүү одоо тогтвортой үйл ажиллагаа явуулах ийм боломж нь бүрдэж орж ирнэ ээ гэсэн ийм саналыг Улсын Их Хуралд суудалтай 5 улс төрийн намын төлөөллүүд одоо бас боловсруулж оруулж ирлээ.

Ж.Бат-Эрдэнэ: Баярбаатар гишүүн. За Шижир гишүүн тодруулна.

Ө.Шижир: Баярбаатар гишүүнд л зориулсан бүтэц байсан юм байна л даа тийм. Одоо таны тайлбараас бол тэгж л уншлаа 2020 онд харин тийм. Тэгээд одоо энэ тухайн үеийн энэ байнгын хороод чинь одоо ер нь бол бид нар яах вэ Засгийн газрын бүтэц одоо цомхотгол гэдэг зөв байгаа. Ер нь бол Их Хурлын бүтцээр дан ялангуяа байнгын хороодын бүтцээр бол ер нь нэг их бас оролдоод өөрчлөөд байх уг нь хэрэггүй л юм байгаа юм. Яагаад гэвэл бид нар энэ чинь одоо нийгмийн хөгжлийн хэрээр ч тэр цахим бодлого гэдэг бол бид нарт зайлшгүй шаардлагатай зүйл шүү дээ. Тэгээд энийг нь одоо өөр байнгын хороонд харьяалуулчихдаг, эрхлэх асуудал нь бүдгэрээд л эхэлнэ. Тэгээд ер нь бол энэ одоо дан ялангуяа энэ Их Хурлын бүтцийн Их Хурлын Тамгын газрын дотоод бүтцийн асуудлыг бол ер нь нэг их бас хөндөөд өөрчлөөд байх бол ер нь тийм зохимжгүй ээ. Нэг өөрчлөх юм бол энэ чинь байнга өөрчилдөг л болчихно. Тэгээд би энийг хэлэх гэсэх юм.

Ж.Бат-Эрдэнэ: Санал уу, санал хэллээ. Хууль санаачлагчийн илтгэл болон төслийн үзэл баримтлалтай холбогдуулан үг хэлэх гишүүд. Үг хэлэх гишүүд байвал

нэрсээ өгнө үү? Зулпхар гишүүнээр тасаллаа. Пүрэвдорж гишүүн үг хэлнэ. Уянгахишиг гишүүнийг нэмье.

Б.Пүрэвдорж Тэгэх дээр энэ яах вэ хүнд зориулж Байнгын хороо байгуулдаг гэдгийг би Ариунзаяад хэдэн өдрийн өмнө хэлж байсан л даа. Тэгэхээр энэ анх энэ Ёс зүйн байнгын хороо, Ёс зүйн байнгын хороо гэж сахилга хариуцлагын Байнгын хороо гэж. Энэ нэг Бат-Эрдэнэ аваргад зориулж байгуулж байсан юм. Аж үйлдвэрийн байнгын хороог Чойжилсүрэн ажилгүй үлдчих дээр нь Чойжилсүрэнд байгуулж өгч байсан, Цахим бодлогын байнгын хороог Учралд бас залуу хүн байна гээд байгуулж өгч байсан. Боловсрол нийгмийн бодлогын байнгын хороог 2 салгаад Анужин, Оюунчимэг 2-т одоо аль аль нь дийлдэхгүй байгаад байсан учраас 2 салгаж өгсөн байхгүй юу. Тэгээд энэ нөгөө манай Занданшатар дарга чинь эвийг нь олоод эвтэйхэн явчих гээд байдаг. Тэгээд энэ асуудлыг хийсэн юм л даа. Тэгээд одоо энийг ингээд буцааж нийлүүлж байгаа нь зөв өө. Би энийг дэмжиж байгаа.

Тэгэхдээ бас ингээд яг нюансыг нь ингээд харах дээр нийлүүлсний ард бас энэ нөгөө нэг асуудал гарчхаж байна л даа. Одоо би 2 Байнгын хорооны гишүүд дээр дүгнэлт хийсэн. Төсвийн байнгын хороо, Төрийн байгуулалтын байнгын хороо. Гол хуулиуд явдаг. Хууль зүйн байнгын хороо бол 22 хүнтэй, Төсвийн байнгын хороо, Төрийн байгуулалтын байнгын хороо хоёулаа 25 хүнтэй тулчихсан. Тэгээд энэ тохиолдолд бол МАН-ын гишүүд аль алин дээр нь 13 байгаа. Бусад намууд бол 12 байгаа. Тэгэх дээр энэ өөрчлөлтийн цаана юу хийх гэж байгаа вэ гэх дээр одоо 13, 12 гээд 1 хүний зөрүү байна шүү дээ, тэрнийгээ 17, 15 болгож ихэсгэх гэж байгаа юм. 32 болгож. Тэгээд яах вэ тэглээ ч гэсэн бид нар бас аргыг нь олно л доо. Яаж ажиллах вэ гэдгээ тийм. Тэгэхээр энэ дээрээ нөгөө нэг бүтэц бүтцээ юу гишүүдээ хуваарилахдаа энэ зүйлийг бодоорой. Бусдаар бүгдийг нь ингээд бид нар азаргалаад явна гэсэн ийм байдлаар асуудалд хандаж болохгүй шүү л гэж хэлмээр байна.

Ж.Бат-Эрдэнэ: Зулпхар гишүүн.

С.Зулпхар: Би бол яах вэ энэ хуулийн төслийг үндсэн зарчмыг нь, үндсэн зорилгыг нь бол бас яах вэ сайшааж байна. Гэхдээ бас бодууштай зүйл байна л даа. Сая одоо асуулт дотор л санал явж байгаа шүү дээ. 2020 онд энэ зарим Байнгын хороо тэрэн дотроо Боловсрол, шинжлэх ухаан, спортын байнгын хороог байгуулчихсан энэ хүнд зориулсан гэж бас зарим талаар та бүхэн үзэж байгаа юм байна. Би бол энэнтэй санал нийлэхгүй. 2020 онд бид Алсын хараа 2050-ийг одоо боловсруулж, ажлын хэсэг дээр ажиллаж байхад ер нь зорилготойгоо нийцсэн бүтцүүд одоо байх юм гэдэг ийм л зүйлийг бол судлаач нар, захиргааны байгууллагынхан, энд оролцсон улсууд бол ярьж байсан. Энэнтэй холбоотойгоор яамдыг тэр үед тодорхойлж байсан юм. Тодорхой яамдыг. Жишээ нь үндэсний нэгдмэл үнэт зүйлтэй холбоотойгоор Соёлын яамны асуудал тэр үед яригдаж байсан шүү дээ. Тэгэхлээр яг энэнтэй холбоотойгоор энэ Соёлын яам одоо жишээ нь байгуулагдаж байсан. Энэ асуудал бол Их Хурал дээр өөрөө хэлэлцэгдээд бүтэцтэй байх ёстой юм гэж бас үзэж байна шүү гэж байгаа юм.

Нөгөөтээгүүр боловсролын асуудлыг бол бид нар хүний хөгжлийг бол алсын хараа дээр бол 2 дахь одоо том зорилт болгоод тавьчихсан юм. Одоо энийг тодорхойлсон. Энэнтэй уялдсан байдлаар энэ Байнгын хороо байгуулагдсан байх, байгуулагдах ч ёстой. Жишээ нь бид урьд нь болбол 7-той байсан, 6-тай байсан гэдэг бол энэ ерөөсөө яриа биш бид зорилготойгоо нийцсэн бүтэцтэй байх ёстой.

Заримдаа 7 ч байж болно, хүсвэл 5 ч байж болно, шаардлагатай бол 8 ч байж болно. Энийг бид нар бол хэтэрхий бас одоо ингээд хавтгайруулж бас одоо ойлгодог, эсвэл одоо ингээд тайлбарлачихвал одоо зөв болох юмаа гэж байгаа бол энэнтэй болбол бид бас санал нийлж болохгүй байх гэж бодож байна.

Хоёр дахь зүйл нэг Байнгын хороо байхгүй болохоор зэрэг хэмнэлт гарна гэж байна. Хэмнэлт гарахгүй тэрнээс илүү бидэнд асуудал. Бодлого чинь хэрвээ мэргэжлийн түвшинд хэлэлцэгдэхгүй өөр газар очоод байх юм бол магадгүй тэрнээс үүдсэн үр дагаврууд гардаг. Тэгэхлээр энийг сайн бодооч ээ гэж байгаа юм. Нөгөөтээгүүр Монгол Улсын хөгжил нь боловсрол мөн юм бол, цаашдаа шинжлэх ухаан мөн юм болбол энэ дээр бид нар бол нэг Байнгын хороотой байхад бол болохгүй юм бол байхгүй шүү. Бид боловсролдоо анхаараагүйгээс болоод өнөөдөр баахан асуудлын үндсийг тавьчихсан сууж байгаа улс орон шүү дээ. Тэгчихээд нэг Байнгын хороо байсных нь төлөө энийг болбол одоо жишээ нь буцаад нийлүүлэх юмаа, буцаад нийлбэл сайн байна гэж одоо зүйл ярьж байгаа бол энэ би бол одоо энэ бол буруу гэж ойлгож байна. Хууль санаачлагчид та бүхэн энэ дээр өөрсдөө одоо жишээ нь энэ дээр анхаарлаа хандуулаад, хуулиа одоо жишээ нь хэлэлцүүлэх үедээ энэ асуудлыг дахиж одоо нарийвчлан танилцуулаач ээ гэж байгаа юм, оруулж ирээч ээ гэж байгаа юм. Бүхэлд нь бол энэ хуулийн төслийг бол дэмжиж байна. Баярлалаа

Ж.Бат-Эрдэнэ: Уянгахишиг гишүүн.

Г.Уянгахишиг: Энэ дээр бол бас нэг аягүй олон анхаарах зүйлс байгаад байгаа. Тийм одоо яг энэ дээр хэлэлцэж, одоо өнөөдөр бол бид нар хэлэлцэх эсэхээ санал хураах гэж байна. Яваандаа ер нь бол яг хэлэлцээд эхэлсэн тохиолдолд энэ дээр нэлээн олон юмыг бид нар нягталж харах хэрэгтэй байна аа. Өөрөөр хэлэх юм болбол жишээлбэл яг нэгтгэгдэж байгаа байнгын хороодын хурлын ачааллыг жишээлбэл хармаар байна. Үнэхээр хуралдаад ачаалал нь дийлэхгүй, ирц нь хүрдэггүй ч юм уу тиймээ, эсвэл хурлынх нь жагсаалтад орж чаддаггүй, асуудал нь орж чаддаггүй тийм байнгын хороодын хувьд бол буцаагаад дахиад нэг салбар асуудал аваад ороод ирэхээр асуудлуудынх нь жагсаалт багтах уу, шингэх үү, хуралдаж амжих уу гэдэг асуулт байна.

Нөгөө талаасаа бүх байнгын хороодын гишүүдийн тоог 25-32 болгож өөрчилж байна аа. Тэгээд бид нар 25 дээр ирцээ бүрдүүлж чаддаггүй хүмүүс 32 дээр ирцээ бүрдүүлж чадах уу асуудал үүсэх юм биш биз. Нөгөө талаасаа яг ачаалал гишүүдэд ирэх ачаалал буюу 2 Байнгын хорооноос дээш Байнгын хороонд орох боломжгүйг одоо 3 болгож байна аа. Тэгэхээр нөгөө 3 Байнгын хороонд орчихсон гишүүд маань нөгөө байнгын хороодын хурлууд нь давхцаад, хуралдаа орж чаддаггүй дахиад нөгөө ачаалал болон ирцийн асуудал үүсэх вий гэх мэтчилэн нэлээн олон нарийн ярилцах ёстой асуудлууд бол байна. Тийм учраас хэлэлцэж эхэллээ гэхэд эхний хэлэлцүүлэг дээр яг энэ талаар статистик мэдээллүүдийг өмнөх мэдээллүүдийг хууль санаачлагчийн зүгээс оруулж ирээсэй. Тэрэн дээрээ бид нар яг харж байж асуудлаа яг бодитой шийдвэрлэхгүй бол дараа нь дахиад асуудал үүсээд ер нь ингээд л тоог нь нэмсэн нь дэмий болсон юм, 3-т орсон нь дэмий болсон юм. Нийгмийн байгуулал дээр боловсролын асуудал жагсаалтад нь орж чадахгүй байна, өмнөх асуудал нь ороогүй байна гэдэг ийм асуудлууд гарах вий дээ гэдэг ийм бас нэг эмзэглэл байгаад байна аа тийм. Тэгэхээр энэ тал дээр бас анхаарч хараасай гэдэг ийм саналтай байна.

Ж.Бат-Эрдэнэ: 2-оор 2 шүү. Баярбаатар гишүүн үгээ хэлье.

Б.Баярбаатар: Гишүүддээ өдрийн мэнд хүргэе ээ. Хуулийн төслийг бол дэмжиж байгаа. Ер нь бол тодорхой түвшинд бас энэ чиг үүргээрээ өмнө нь нэг байсан байнгын хороод бол буцаад нэгдэх нь зөв байх. Дэд хорооны түвшинд очоод үйл ажиллагаа явуулах нь зөв байх. Ажлын хэсгийн даргын хэлж байгаа зарим Байнгын хороод нь 25 гишүүнтэй, зарим нь 11, 12 гишүүнтэй асуудал шийдэхээр бол 5, 6 гишүүний ирцтэйгээр асуудал шийдээд яваад байгаа ийм зүйлүүд бол бас байгаа гэдэг нь зөв. Тэгэхдээ би нэг Байнгын хороог бол энэ дангаар нь ажиллах нь бол зөв болов уу гэж. Энэ Боловсролын байнгын хороо бол одоо бид нар чинь энэ багш нар энэ боловсролын салбар дээрээ ер нь нэлээдгүй анхаарах ёстой.

Ирэх жил Монгол Улсын Засгийн газар 2026 оны боловсролыг дэмжих жил болгоод зарлачихсан байдаг. Тэгээд өнөөдөр энэ боловсролын салбар дээр тулгамдаж байгаа асуудлууд чинь шийдэгдээгүй байдаг, олон асуудлууд байгаа учраас яах вэ энэ боловсролын асуудлыг нь бол бас хэвээр нь байлгавал яасан юм бэ гэдэг ийм санал байна. Бусад одоо тэр хүнд зориулсан гэдэг Байнгын хороодууд нь бол одоо тэгээд чиг үүргээрээ нэгтгээд явах, ямар ч байсан сая Пүрэвдорж гишүүний хэлснээр бол надад бол зориулаагүй гэдгийг бол харин баталчих шиг боллоо. Тэгэхгүй бол сүүлд нь бас хэрэгт орох магадлалтай учраас тийм ээ.

Тэгээд хэлэлцэх эсэхээ хэдүүлээ энэ Байнгын хороон дээрээ дэмжээд, тэгээд дараагийн асуудал дээр тэр Боловсролын байнгын хороон дээр зарчмын зөрүүтэй саналуудаа гаргаад, нэгдсэн чуулган дээрээ бас хэлэлцэх эсэхээ хэлэлцүүлээд, хуулиа ингээд дэмжээд явах нь зөв болов уу гэсэн ийм байр суурийг илэрхийлж байна. Тийм за баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Баярмаа гишүүн үг хэлнэ.

Ж.Баярмаа: Зарчмын хувьд бол дэмжиж байгаа юмаа. Одоо ерөөсөө цомхотгоно, багасгана гэсэн бүх зүйлийг л дэмжиж байгаа юм. Тэгэхээр бид нар бас энэ гаднын, би түрүүн асуултдаа асуух байж л дээ. Гаднын одоо энэ парламентуудын тэр нөгөө рэйшио харьцааг бас харах харсан болов уу, яасан бол жишээлбэл. Зүгээр эндээс халт би харахад Германы Бундестаг 736 МПТ парламентын гишүүнтэй мөртөө 25-30 Байнгын хороотой байдаг юм байна. Өөрөөр хэлбэл 27 гишүүнд нэг Байнгын хороо ногдож байна. Яах вэ зүгээр механик. Тэгэнгүүт манайд болохоор 126-г 11-ээр нь бодоход 11 хүнд гээд ингээд тиймээ нэг хүнд одоо жишээлбэл тэнд их олон хүнд нэг ноогдож байхад, манайх цөөн хүнд нэг ноогдоод байна гэсэн үг байхгүй юу.

Тэгэхээр энэ одоо харьцаануудыг харсан ч гэсэн нөгөө л нэг 100 ямаанд 60 ухна гэдэг шиг л манай бүх бүтэц дандаа бүх талдаа л том байгаад байгаа юмаа. Тэгэхээр угаасаа энэ чинь маш тодорхой. Ингээд өөрснөө одоо ичиж нэрэлхэлгүйгээр гаргаад ирсэн байна шүү дээ хөөрхөн. Хүнд зориулж хийсэн юмаа гээд. Тэгэхээр чинь одоо энэнээс илүү баатарлаг үйлс гэж юу байх вэ. Тэгэхээр энийг нь бол одоо маш их сайшааж байна, сайн байна. Тэгээд ингээд алдаа дутагдлаа алхам тутамдаа засаад бүгдээрээ үнэнтэйгээ нүүр тулаад явах юм бол маш их баяртай байна. Тэгээд яг энэ Байнгын хорооны бүтцийг багасгадаг шигээ уг нь бол энэ яамдынхаа тоог бас уг нь багасгах ёстой байсан юм. Тэгээд харамсалтай нь тэрийг болбол бид нар хийж чадсангүй.

Тэгэхээр аль ч утгаараа бол одоо энэ чинь маш бодитоор тэр жижиг, за жижиг гэх нь хаашаа юм одоо Инновац, юуны Байнгын хороо билээ? Тэр бол ерөөсөө баргийн хуралдаж чаддаггүй юм байна лээ шүү дээ. Ерөөсөө хэзээ ч, юу нь хүрэлцэхгүй. Аж үйлдвэр байна. Тэгэхээр энэ чинь бодит практик дээр, тэр функт тэр Байнгын хороо чинь ажиллахгүй байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр хаа нэгтээ өөр газар аваачиж тэр нь одоо өөр сонирхолтой хүмүүс нь нэгдэж тэрийгээ ажиллуулахгүй болбол бүүр ингээд нэг их сүрхий тусад нь байлгасны гороор бараг нөгөөдөх нь ажилладаггүй ийм Байнгын хороо байгаад байна аа. Тэгэхээр энийг болбол маш баяртайгаар дэмжиж байна аа. Тодорхой хэмжээнд хөрөнгө, санхүү хэмнэгдэж байгаа эсэхийг нь уг нь асуух ёстой байсан юм.

Тэгээд түрүүн Ариунзаяа гишүүн бол үгэндээ маш тодорхой хэлсэн л дээ. 3-ын 3 Байнгын хороо байхгүй болно гэдэг чинь тодорхой хэмжээнд бол ажлын алба нь байхгүй болж байна, татан буугдаж байна гээд ямар ч байсан бага ч атугай санхүүгийн хувьд бол бас хэмнэлт үүсэж байгаа гэж найдаж байгаа учир би бол дэмжиж байгаа юмаа. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Гишүүд үг хэллээ. Ер нь болбол Байнгын хороогоо хэдүүлээ цомхотгоё гэж байгаа шүү дээ. Зарим нэгэн Байнгын хороон дээр болбол хууль цохогдож очихгүй байгаа. Өөрөөр хэлбэл хэлэлцэх асуудалгүй болчхоод байна гэсэн үг байхгүй юу. Тэр одоо хүндээ зориулсан байна уу, юундаа зориулсан байна ямар ч л байсан бодит одоо амьдрал дээр болбол хэлэлцэх асуудал байхгүй боломж одоо хуралдах тийм бололцоогүй болчхоод байна шүү дээ. Тийм болохоор сая гишүүд бас хэллээ. Пүрэвдорж гишүүн ч хэллээ, Баярмаа ч хэллээ. Ер нь бол бас бид нар алдаагаа засаад буцаад орж ирж байгаа нь сайшаалтай байна аа гэж байгаа шүү дээ.

Тийм болохоор энийг хэдүүлээ хэлэлцье. Хэлэлцэх явцад асуудлуудаа бас засаад ажлын хэсэг байгуулаад ч юм уу ингээд явчихъя.

Гишүүд ингээд байр сууриа илэрхийлж төслийн үзэл баримтлалтай холбогдуулан байр сууриа илэрхийлж дууслаа. Санал хураалт явуулъя. Санал хураалтад бэлдье.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

19 гишүүнээс 12 гишүүн санал хураалтад оролцож, 63.2 хувиар санал дэмжигдлээ.

Бас нэг санал хураалт байгаа. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дэмжих нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 19 гишүүнээс 12 гишүүн оролцож, 63.2 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлуудыг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Баярбаатар танилцуулъя.

Одоо үдээс хойш чуулганы хуралдааны ар дээр хэдүүлээ бас хуралдах шаардлагатай болж байгаа шүү. Тийм болохоор ирцээ бол хадгалаад үлдчихье.

Ингээд өнөөдрийн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

14:50

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ГЭРЭЭТ АЖИЛТАН

Д.ЭНЭБИШ

